

# ОРЧИН 21

## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО



### 2-5 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ

мэндчилгээ



### 6-51 МЭДЭЭЛЭЛ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
2013 ОНД ХИЙСЭН ТОМООХОН  
АЖЛУУД, 2014 ОНЫ ЗОРИЛТУУД



### 52-68 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

БИОЛОГИ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БАЙГУУЛАМЖИЙН  
ТЕХНОЛОГИ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ  
ХЯНАЛТЫН ТООЦОО ТҮҮНИЙ БОЛОМЖИТ ҮР  
ДҮН



### 69-70 ЯРИЛЦЛАГА

2014 ОН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД  
ОНЦГОЙ АНХААРСАН ЖИЛ БАЙНА



### 71-78 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

"ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХК



### 79-86 ХУУЛИЙН ЗӨВЛӨГӨӨ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ  
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ



### 87-90 ЭРҮҮЛ МЭНД

НАЙМДУГААР БҮЛЭГ

БИЕ МАХБОД УС НЭХЭХ НЬ

# ОРЧИН 21

## ЭРХЛЭГЧ:

**Б.Пүрэвжав**

/Монгол улсын аж үйлдвэрийн  
гавьяат ажилтан, Техникийн ухааны  
магистр, МУ-ын зөвлөх инженер/

## ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

**Д.Басандорж** /МУШУТИС/

**С.Дагвадорж**

/Таван Өндөр ХХК-ийн захирал/

## МЕНЕЖЕР:

**Б.Алтантуул**

## ДИЗАЙНЕР:

**Б.Мөнхцацрал**

## СЭТГҮҮЛЧ:

**Б.Баяртогтох**

ISSN 1032-1040/20

# орчин·21

2014 01(18) Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо

**2014 оны 3 дугаар сарын 22 ны  
дэлхийн усны өдөрт зориулав**

**2014 он орон нутгийн  
хөгжилд онцгой анхаарсан  
жил байна**

WWW.ORCHIN21.MN УТАС: 70101779 MNAUIN@YAHOO.COM



## МЭНДЧИЛГЭЭ

Монголын Нийтийн Аж Ахуй Үйлчилгээний салбарын хамт олон Та бүхэндээ Тулгар төрийн 2223, Их Монгол Улсын 808, Ардын хувьсгалын 93 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Төв Азийн цээжинд орших туурга тусгаар Монгол түмний маань үндэсний бахархлын охь манлай, өвөг дээдсээс зуун зуунаар улбаалж бидний үед өвлөгдөн ирсэн дэлхийд ганцхан Эрийн гурван наадмаа ХХ зууны эхэн үеэс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласаны түүхт үйл явдлын баяр болгон тэмдэглэж эхэлснээс хойш 93 дахь жилийнхээ ойтой золгож байна.

Монголчууд бид үндэснийхээ их баяр наадмыг үндэсний эв нэгдлийн бэлгэдэл, Монгол туургатны давтагдашгүй өв соёлын эрхэм дээд бахархал, улс орны тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн бэлгэ тэмдэг, өвгөд хөгшдөөс эхлээд өсвөр багуучуудыг хүртэл бүх нийтийг хамарсан их цэнгүүн, угтах ирээдүйгээ гэгээлэг сайхнаар төсөөлөх өөдрөг хүсэл тэмүүллийн баяр болгон тэмдэглэдэг сайхан уламжлалтай билээ.

Та бүхний маань уясан морь хурдан, унасан хүүхэд нь хийморьтой, барилдсан бөх нь бяртай, одтой, харвасан сум нь онч мэргэн байж, хотлоороо сэтгэл тэнүүн, цог золбоотой сайхан наадаарай.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Жамьянсүрэнгийн БАТСУУРЬ



## МЭНДЧИЛГЭЭ

“МОНТС” ХХК нь орон сууцны ашиглалт, үйлчилгээг хариуцан ажилласнаас хойш 10-н жил болж байна. Энэ хугацаанд манай байгууллагын ажлын цар хүрээ өргөжин тэлж, ажиллагсдын тоо өсч, тэдний мэргэжил мэдлэг, ур чадвар сайжирч багагүй дадлага туршлагатай боллоо.

Өргөжин тэлж байгаа их хотын нэгээхэн хэсэг болох БГД-ийн 5,6,7,8,17-р хороо, БЗД-ийн 5,13,14,22-р хорооны оршин суугчид хэрэглэгчдийнхээ ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэн ус дулааныг тасралтгүй, найдвартай дамжуулан түгээх, бохир усыг татан зайлуулах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэй биелүүлж ойгоо угтаж байна.

Бид үйлчилгээний соёлыг дээшлүүлэн, чирэгдэлгүй шуурхай ажиллаж НАА-н хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах болно.

Байгууллагынхаа 10-н жилийн ойг тохиолдуулан энэ салбарт ажиллаж байсан ахмадууд болон одоо ажиллаж байгаа мэргэжил нэгт хамт олон, харилцагч байгууллагууд, оршин суугч иргэд, компанийхаа ажиллагсад та бүхэндээ эрүүл энх, сайн сайханыг хүсч ажил үйлс тань аз хиймورتой байж, инээд баясал, аз жаргалаар дүүрэн амьдрахын өлзийтэй ерөөлийг дэвшүүлье.

ЗАХИРАЛ Д.МЯГМАРСҮРЭН



## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ЭЭЛЖИТ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ БОЛЛОО

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны удирдах зөвлөлийн хурал 2014 оны 05 дугаар сарын 27-ны өдөр болж өндөрлөлөө.

Тус хурлаар нийтийн аж ахуйн үйлчилгээний салбартай холбоотой манай улсад тулгамдаж буй асуудлууд, хууль эрх зүйн орчин, үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын менежментийг сайжруулах, усны үнэ тарифийг нэмэгдүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар өргөн хүрээтэй ярилцаж хэлэлцлээ.

Мөн тус хурлаар Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүнийг сонголоо. Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүн асан Б.Жигжид, Улсын Их Хурлын

гишүүн Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, Улсын Их Хурлын гишүүн Д.Батцогт нарыг тэргүүнд нэр дэвшүүлсэнээс Удирдах зөвлөлийн гишүүд 100%-ийн санал нэгтгэйгээр Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийг Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүнээр сонголоо.

Удирдах зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын гишүүн, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны тэргүүн Ж.Батсуурийг салбарын өмнө тулгамдаж буй бэрхшээл, олон асуудлуудыг хамтдаа өөрчилж, шинэчлэнэ гэдэгт итгэж, найдаж байгаагаа илэрхийллээ.



Жамъянсүрэн овогтой Батсуурь 1960 онд Дорноговь аймагт төрсөн.

Төгссөн сургууль, боловсрол:

1. 1978 онд Дорноговь аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль
2. 1983 онд Чехословак улсад Техникийн Их Сургуулийг Барилгын Инженер-Эдийн засагч мэргэжлээр төгссөн.
3. 1998 онд Чех Улсын Прага хотын Техникийн Их Сургуульд доктрантурт суралцаж “Барилгын үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа эрсдэл сэдвээр” эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.БАТСУУРЬ

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

1. 1983-1987 онд Монгол Улсын Их Сургуулийн Инженер-эдийн засгийн салбарт багш
2. 1987-1988 онд Техникийн Их Сургуульд багш
3. 1988-1990 онд Техникийн Их Сургуулийн ХЗЭ-ийн хорооны дарга
4. 1990-1992 онд Техникийн Их Сургуульд багш
5. 1992-1994 онд Техникийн Их Сургуулийн Мэдээллийн техникийн сургуульд дэд захирал
6. 1994-1998 онд Чех Улсын Прага хотын Техникийн Их Сургуульд доктрант багш
7. 1998-2000 онд Улаанбаатар хотын “ Ус орчин ” ХК-ны ерөнхий захирал
8. 2000-2008 онд Дорноговь аймгийн Засаг дарга, МАХН-ын хорооны дарга.
9. 2008 оноос одоог хүртэл УИХ-ын гишүүн



## АЙМАГ БҮРД БАРИГДАХ 1000 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймаг бүрд 1000 айлын орон сууц” төсөл хэрэгжүүлэхээр тусгагдсан.

### 1. ОРОН СУУЦНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 8 дүүрэгт 110171 айлын, хөдөө орон нутагт 22240 айлын орон сууц баригдахаар төлөвлөгдсөн.

Дээрх хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд улсын хэмжээнд 2010 онд 9899 айлын, 2011 онд 11349 айлын, 2012 онд 11453 айлын, 2013 онд 20300 айлын орон сууц /үүнээс орон нутагт 5360 айлын орон сууц/ баригдаж ашиглалтад орсон байна.

2014 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар өмнө нь орон сууцны ипотекийн зээл авсан зээлдэгчдээс 845.7 тэрбум төгрөгийн зээлийг 8 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлэх хүсэлт банкуудад ирсэн байна. Үүнээс банкууд 17632 зээлдэгчийн нийт 500.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, 8 хувийн хүүтэй ипотекийн зээл рүү шилжүүлсэн байна.

Түүнчлэн орон сууц шинээр худалдан авахыг хүссэн иргэдээс 1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн өргөдөл банкуудад ирснээс 17019 иргэнд 947.6 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгохоор шийдвэрлэсэн байна.

### 2. АЙМГИЙН ТӨВҮҮДЭД БАРИГДАХ ОРОН СУУЦНЫ ХОТХОН, ХОРООЛЛУУДЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖЛЫН ЯВЦ

- “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймгийн төвийг хот болгон хөгжүүлэх”, “Аймаг бүрд 1000 айлын орон сууц барих” зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу аймгийн төвүүдэд баригдах цогцолбор орон сууцны хотхон, хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.
- 2013 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн 143.5 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймгийн төв Арвайхээр, Булган аймгийн төв Булган хотуудад баригдах орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.
- 2014 онд улсын төсвийн хөрөнгөөр Говьсүмбэр аймгийн Чойр, Ховд аймгийн Ховд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Баян-Өлгий аймгийн Өлгий хотуудын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж байна. Энэхүү ажлын хүрээнд тухайн аймгийн төвд баригдах 1000 айлын орон сууцны хотхон, хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хамтатган хийгдэж байна. /Хүснэгт 1/
- Мөн энэ онд улсын төсвийн 364.6 сая төгрөгийн санхүүжилтээр Дорнод аймгийн

төв Чойбалсан, Завхан аймгийн төв Улиастай, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотуудад баригдах орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна.

### 3. АЙМАГ БҮРД БАРИГДАХ 1000 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ГАДНА ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ УГСРАЛТЫН АЖЛЫН ЯВЦЫН ТАЛААР

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “21 аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам, сүлжээ, 2013-2015 он, 62.0 тэрбум төгрөг”, мөн 2014 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 2014-2015 он, 5.6 тэр бум төгрөг/”, “Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум, 2014-2015 он, 4.5 тэр бум төгрөг/” төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдэх 27 ажлаас 13 ажлыг эхлүүлсэн, 2014 онд 14 ажлыг эхлүүлэхээр тендерийг зарлаад байна.

Аймаг бүрд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:

1. Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Орхон, Сүхбаатар, Төв аймгуудын төвд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн.
2. Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгуудын инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын тендер шалгаруулалт явагдаж байна. Завхан аймгийн “ХХ1 зуун” орон сууцны хорооллын зураг төсөв хийгдсэн боловч 2014 оны төсөвт 00 дүнтэйгээр тусгагдсан. Хөрөнгийн эх үүсвэрийг 2014 онд шийдвэрлэх шаардлагатай.
3. Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Увс, Ховд аймгуудад 1000 айлын орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгийг шийдвэрлэх шаардлагатай байгаа болно
4. Үүнээс Говьсүмбэр, Дундговь аймгуудад хийгдэх ажлын зураг төсөв бэлэн боловч угсралтын хөрөнгө шийдээгүйгээс ажил эхлээгүй байна. Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд аймгуудад хийгдэх 1000 айлын гадна ИШС-ний зураг төслийг боловсруулах ажлын тендерийг зарлаад байна.
5. Аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийн хувьд:
  - Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Орхон, Дорнод, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Ховд аймгуудын цэвэрлэх байгууламжийн асуудал шийдвэрлэгдсэн.
  - Баян-өлгий, Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгуудын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ БОЛЛОО



2014 онд “Монголдоо бүтээцгээ” уриа дэвшүүлсэн Барилга, хот байгуулалтын яам салбарын нээлттэй өдөрлөгөө 2014 оны 6 дугаар сарын 14-нд Чингис хааны нэрэмжит төв талбайд зохион байгууллаа.

Өдөрлөгт Барилга, хот байгуулалтын яамны удирдлага, хамт олон, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, Монголын барилгачдын холбоо, Монголын барилгын үндэсний ассоциаци, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын барилгын инженерүүдийн холбоо, Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд оролцсон юм.

Өдөрлөгийн үеэр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, салбарын

яамны бодлого үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчиллаа. Барилга, хот байгуулалтын салбарын бодлого үйл ажиллагааг иргэд хэрхэн үнэлж байгаа, ямар арга хэмжээ, хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх талаар мөн санал асуулга явууллаа. Ажилтай, орлоготой Монгол хүн хөтөлбөрийн хүрээнд барилгын салбарт ажилд зуучлах, батламж гардуулах арга хэмжээ боллоо.

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо үйл ажиллагаагаа иргэд болон байгууллагуудад танилцуулж, улирал тутам эрхлэн гаргадаг “Орчин 21” сэтгүүлийг уншигч олондоо түгээлээ.



Мөн Усны үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс үйл ажиллагаагаа иргэд, олон нийтэд сурталчлан,



танилцуулж, усны зүй зохистой хэрэглээг хэвшүүлэх, иргэдэд усны үнэ цэнийг ойлгуулах зорилгоор сурталчилгааны материалуудыг тарааж, усны үйлчилгээний тусгай зөвшөөрлийн талаар иргэд, аж ахуй нэгжүүдэд шаардлагатай зөвлөмж, зөвлөгөө, мэдээллийг өглөө.



2012 онд Шинэ засгийн газраас яамдын бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт оруулсанаар Зам тээвэр, Барилга, хот байгуулалтын яамыг салгаж Барилга, хот байгуулалтын яамыг дангаар нь ажиллуулахаар болсон юм. Барилга, хот байгуулалтын яам өнгөрсөн 2 жилийн хугацаанд дараахь томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### **ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРТ 2012-2014 ОНД**

- Иргэдийг орон сууцжуулах бодлогыг шинээр тодорхойлж, 8 хувийн хүүтэй зээл олгож эхэллээ. "Иргэдийг орон сууцжуулах талаар авах арга хэмжээний тухай" шийдвэрийг ЗГ-ын 2013.04.13-ны өдрийн 135 дугаар тогтоолоор "Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам"-ыг ЗГ-ын 2013.05.30 өдрийн 200 дугаар тогтоолоор тус тус баталж, 2013 оны.06.17-ноос хэрэгжүүлж байна.

Энэхүү шийдвэрийн хэрэгжилт 2014.05.15-ны байдлаар

- Өндөр хүүтэй зээлтэй 18210 иргэний зээлийг 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлж, үүнд 520.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийлээ.
- Шинээр 19228 иргэнд 1 их наяд 78,2 тэрбум төгрөгийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийг өнгөрсөн 1 жилийн хугацаанд олгоод байна.
- Ипотекийн зээлээр орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулж 1300 айлын түрээсийн орон сууц барих ажил эхлүүлээд байна. 2014 онд 504 айлын орон сууц Баянзүрх дүүрэгт ашиглалтанд орно.
- 2014 оны 6 дугаар сараас инженерийн дэд бүтцийн шийдэл бүхий амины орон сууцыг орон нутагт ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэлээ. Түүнчлэн аймаг, сумдад ипотекийн зээлийн хүүг жилийн 7% байхаар "Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам"-д нэмэлт орууллаа.
- Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөр Улаанбаатар хотод шинэ суурьшлын бүс бий болгож, гэр хорооллыг өөрчилж эхэлнэ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний тухай" ЗГ-ын 118 дугаар тогтоол батлагдлаа. "Дэд бүтэц" төслийн нийт төсөв 416 тэрбум төгрөг юм.
- Улаанбаатар хотод шинэ орон сууцны хороолол хотхон, гэр хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээ баригдсанаар 60,300 айлын орон сууц, 31,000 хүүхдийн сургууль, 15,000 хүүхдийн цэцэрлэг, өрхийн эмнэлэг, ахуйн үйлчилгээ, олон нийтийн барилга байгууламж барих боломжийг "Дэд бүтэц" төслийн хүрээнд бүрдүүлж байна.
- "Үндэсний бүтээн байгуулалтын корпораци" барилгын компаниудын нэгдэл орон сууцны хороолол барилаа. Үндэсний барилгын



компаниуд нэгдэн нэг жилийн дотор орон сууцны хороолол барилаа. Буянт-Ухаа-1 хороололд 1764 айлын 25 барилга, 128 хүүхдийн цэцэрлэг, үйлчилгээний төвтэйгээ баригдаж байна.

- Орон сууцны нийлүүлэлтийг дэмжих үүднээс Монгол банкнаас 534,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан хотын 73, хөдөөгийн 28 нийт 101 компанид олгосон юм. Дэмжлэг авсан 101 компани санхүүжилтийн улмаас гацаад байсан орон сууцны барилгуудаа энэ жил ашиглалтанд оруулна.
- Иргэд орон нутагтаа таатай амьдрах зорилго бүхий “Шинэ сум”, “Сумын төвийн шинэчлэл” төслүүдийг хэрэгжүүлж байна. Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд БХБЯ, ЭЗХЯ зэрэг 4 яамны хамтарсан баг өнгөрсөн 2013 оны 3 дугаар сард 330 сумд ажиллаж, 2013-2016 онд хийвэл зохих ажлын жагсаалтыг сумын иргэдтэй хамтран гаргасан юм. Эдгээр ажлыг хийхтэй холбогдуулан сумын төвүүдийг 5 ангилалд хувааж, хөгжлийн загваруудыг тодорхойлон, хийгдэх ажлын нэг маягийн зургийг боловсруулж дууслаа. 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, дулаан хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэр, шугам сүлжээний ажил хийгдэж эхлээд байна. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 8 сум, концессын гэрээгээр 50 сумыг шинэчлэх ажил 2014 оноос хийгдэж эхэллээ. “Шинэ сум” төслийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянлиг, Бууцагаан сум Канад модон байшин бүхий сумын төвийн захиргаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг барилга байгууламжтай боллоо. Энэ төсөл Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ч хэрэгжиж байгаа юм.
- Барилга, барилгын материалын салбарт 2012-2014 онд
- Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо хангах зорилгоор “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг ЗГ-ын 2012 оны 171 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрт хамрагдсан аж ахуй нэгжүүдээс 21 үйлдвэр тоног төхөөрөмжөө шинэчлэж, шинээр 11 барилгын материалын үйлдвэр нээгдлээ.
- Цементийн дотоодын хэрэгцээг эх орондоо хангадаг болохын тулд дэмжлэг үзүүлснээр “Хөтөлийн цемент шохойн үйлдвэр” жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэрээ нээлээ.
- Чингис бондын санхүүжилтээр Монголын алт ХХК-ийн жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Хөх цавын” цементийн

үйлдвэр, Монполимет ХХК-ийн жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Монцемент” төслийг дэмжсэнээр 2016 он гэхэд Монгол Улс цементийн хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээсээ хангана.

- Иргэдийг орон сууцжуулах ажлын хүрээнд ЗГ-ын 180 дугаар тогтоолоор “Байшин үйлдвэрлэх комбинат-1” төслийг батлуулж, БҮК-1-ийг сэргээн угсармал хавтгаалжин барилгын үйлдвэр байгуулах гэрээ байгуулан эхний ээлжийн санхүүжилтийг өнгөрсөн онд хийсэн юм. Энэхүү үйлдвэр 2014 онд ашиглалтанд орох гэж байна. Үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр барилга угсралтын ажил улирлын хамаарлаас гарна.
- Барилгын гол нэр төрлийн материалын нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор үндэсний барилгын материал үйлдвэрлэгч 71 аж ахуйн нэгжид 174 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг мөн цемент, арматур нөөцлөх, нийлүүлэх 55 аж ахуйн нэгжид 125.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Монгол банкнаас арилжааны банкуудаар дамжуулан олголоо. Ингэснээр барилгын улирлын хугацаанд цементийн үнэ 150,000 төгрөг, арматурын үнэ 1,150,000 төгрөг байж барилгын салбарт бодит дэмжлэг болов.
- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хугацаа 5 дахин, гарын үсгийн тоо 3 дахин буурлаа.
- Өмнө нь Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөлд 208 хоног, 120 хүний гарын үсэг шаардагддаг байв. Тусгай зөвшөөрөл
- Барилга угсралт
- Барилгын материалын үйлдвэрлэл
- Зураг төсөл
- Өргөх механизм

Харин одоо 151-р тогтоолоор

Аймаг нийслэлийн газрын захирамж, техникийн нөхцлийг Нэг цонхны үйлчилгээгээр 30-35 хоногт олгодог боллоо.

Экспертизийн ажлыг 7 хоногт зохион байгуулж, 3 хоногт зөвшөөрөл олгож байна. Барилга байгууламж ашиглалтанд хүлээн авах хугацаа 14 хоног боллоо.

-Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах суурь нөхцлийг хөнгөвчилж, зарим тусгай зөвшөөрлийг ТББ-д шилжүүллээ. Сайдын 2012 оны “Журам шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тушаалын дагуу “Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл” олгох үйл ажиллагааг “Барилгын хөгжлийн үндэсний нэгдсэн төв” ТББ зохион байгуулж ажиллаж байна.

-Сайдын 2013 оны 89 дүгээр тушаалаар “Барилгын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл” авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах суурь нөхцөл шаардлагыг практикт нийцэж байхаар хөнгөвчиллөө.



### **ХОТ, БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРТ 2012-2014 ОНД**

- Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн бодлогыг тодорхойллоо. БХБЯ, НЗДТГ, НИТХ санаачлан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийг боловсруулахдаа 9098 иргэн, аж ахуйн нэгжийн санал хүсэлт, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг тусган нийт 25 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, УИХ-ын 2013.02.08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлууллаа.
- Аймгийн төвүүдийг хот болгон хөгжүүлэх шинэ төлөвлөлт боловсруулж эхэллээ. 2013-2014 онд улсын төсвийн 5,2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Говьсүмбэр аймгийн Чойр, Төв аймгийн Зуунмод, Ховд аймгийн Ховд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Баян-Өлгий аймгийн Өлгий Хэнтий аймгийн Өндөрхаан, Дархан хотуудын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж байна.
- “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил төсөл”-ийн хүрээнд Сайншанд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дууслаа.
- 2014 онд Дундговь аймгийн Мандалговь, Увс аймгийн Улаангом, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Говь-Алтай аймгийн Алтай, Дорнод аймгийн Чойбалсан, Хэнтий аймгийн Өндөрхаан хот зэрэг 6 аймгийн төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.
- Аймаг бүрт баригдах 1000 айл орон сууцны инженерийн дэд бүтцийн хамт барих ажлыг эхлүүллээ. 2013 онд улсын төсвийн 18,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай, Булган, Архангай, Сүхбаатар, Орхон, Хөвсгөл, Дорнод, Дархан-Уул аймагт баригдах 1000 айлын орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдэж, батлагдлаа. Дорнод, Завхан, Хэнтий аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж дууслаа.
- 2013 онд аймгийн төв, томоохон суурин газруудад инженерийн дэд бүтэц болон барилга угсралтын ажил хийгдсэнээр 5360 орчим айлын орон сууц ашиглалтанд орлоо. Мөн 16 аймгийн 60 гаруй суманд ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулсанаар 130,000 гаруй хүн стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангагдлаа.
- Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх “Шинэ хороолол” төсөл хэрэгжүүлээ. Барилга хот байгуулалтын яам, Нийслэл, НҮБ-ын ХАБИТАТ, “Атмор” компани хамтран нэгдүгээр хорооллын арын дэнжийн 168 айлыг жишиг хороолол болгохоор ажиллалаа. Гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх “Шинэ хороолол” төслөө

иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн юм. Шинэ технологи бүхий авто замтай болсон оршин суугчид орон сууцны иргэдээс дутуугүй тохитой орчинд амьдарч, халуун хүйтэн устай болж, цэвэр бохирын сүлжээнд холбогдлоо.

#### **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ 2012-2014 ОНД**

1. Салбарын эрх зүйн орчны шинэчлэлтийн хүрээнд дараахь хуулиуд дээр ажиллаж байна. Шинэчлэн боловсруулж буй хуулиуд

1. Газрын тухай хууль / УИХ-д өргөн барьсан /
2. Барилгын тухай хууль / өргөн баригдахад бэлэн болсон /
3. Хот байгуулалтын тухай хууль / өргөн баригдахад бэлэн болсон /
4. Геодези зураг зүйн тухай хууль / УИХ-д өргөн барьсан /
5. Газрын кадастрын тухай хууль / УИХ-д өргөн барьсан /
6. Газрын төлбөрийн тухай хууль / УИХ-д өргөн барьсан /

#### **ШИНЭЭР БОЛОВСРУУЛЖ БҮЙ ХУУЛИУД**

1. Хотыг дахин хөгжүүлэх тухай хууль / ЗГ-аар дэмжигдсэн /
2. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газрыг нөхөн олговортой чөлөөлөх тухай хууль / УИХ-д өргөн барьсан /
3. Ногоон байгууламжийн тухай хууль / Боловсруулж байгаа /
4. Авто зогсоолын тухай хууль / Боловсруулж байгаа /
5. Барилгын материал, хийц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах тухай хууль / Боловсруулж байгаа /

#### **БАРИЛГЫН САЛБАРЫН ӨСӨЛТ**

- 2013 онд барилга угсралтын ажлын гүйцэтгэл өнгөрсөн онтой харьцуулахад 78,4 хувийн өсөлт гарлаа.

Барилга угсралт 2010 онд 463 тэрбум

2011 онд 745 тэрбум

2012 онд 1 их наяд 034 тэрбум

2013 онд 1 их наяд 845 тэрбум

- 2013 онд улсын хэмжээнд 20 300 айлын орон сууц эд хөрөнгийн эрхийн бүртгэлд шинээр хамрагджээ. Орон нутагт сүүлийн жилүүдэд анх удаа 5360 гаруй айлын орон сууц баригдаж ашиглалтанд орлоо.
- Орон сууцны эрэлт нийлүүлэлтийн судалгааг Улаанбаатар хот болон аймгийн төвүүд, хүн ам ихтэй 11 суманд “Барилгын үндэсний ассоциаци” ТББ-аар хийлгэлээ. Ирэх 3 жилд нийслэлд 80,000 хөдөө орон нутагт 26,000 орчим айлын орон сууц ашиглалтанд орно.
- АНУ-ын хөгжлийн агентлагаас гаргасан судалгаагаар Монгол Улс барилгын салбар дахь бизнесийн таатай орчин бүрдүүлэлтээрээ дэлхийн 185 орноос 2013 онд 107 дугаар байранд орж, 25 байраар урагшилсан амжилт үзүүлсэн юм.

Барилга, хот байгуулалтын яам



## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛӨӨС МЭДЭЭЛЖ БАЙНА

Зохицуулах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаан нь 2014 оны хагас жилийн байдлаар 8 удаа хуралдаж, хэлэлцсэн асуудлаар нийт 26 тогтоол батлан гаргасан байна. Хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

**НЭГ. ДҮРЭМ, ЖУРАМ БАТЛАН, МӨРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага /хангагч/ болон үйлчилгээг хүртэж буй иргэд, байгууллагууд /хэрэглэгч/-ын хоорондын харилцаа, тэдгээрийн хооронд гэрээ байгуулах нөхцөл, түүнд тавих шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцлийг зохицуулах “Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулав.

**ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Орон нутагт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чиглэлээр дараах байгууллагуудад шинээр тусгай зөвшөөрөл олгов. Үүнд:

- “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ
- “Хархорин ус суваг” ОНӨААТҮГ

Хот, сууринд хотын орон сууцны ашиглалт, засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг дараах байгууллагуудад шинээр тусгай зөвшөөрөл олгов. Үүнд:

- “Смарт план” ХХК
- “Опен хаус ӨНӨ” ХХК
- “Паблик сервис” ХХК

Ус олборлон, цэвэршүүлэн савлах дараах үйлдвэрүүдэд шинээр тусгай зөвшөөрөл олгов. Үүнд:

- “Галшинт” ХХК,
- “Хэгсакуа” ХХК,
- “Улаанбаатар зочид буудал 2” ХК,
- “Эм-си-эс Кока кола” ХХК,

Бохир усыг тусгай зориулалтын машинаар соруулах үйлчилгээ эрхэлдэг дараах байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгов. Үүнд:

- “Жайент трейд” ХХК,
- “Маргад Монгол” ХХК,
- “Хантайшир хайрхан” ХХК,
- “Голден-Эко” ХХК,

“Онги ус суваг” ОНӨХХК, “Ухаа худаг ус хангамж” ХХК, “Ганманлай” ХХК, “Цэнгэлдэх ОСНААК” ХХК, “Хайспийд” ХХК, “Баян Монгол

хотхон” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг тус тус сунгав.

Ус сувгийн удирдах газрын харьяа “Урьдчилан цэвэрлэх байгууламж” ОНӨААТҮГ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

**ГУРАВ. ҮНЭ ТАРИФ ХЯНАН, БАТЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:**

2014 оны 01-р сарын 28-ны өдрийн Зохицуулах зөвлөлийн 2-р хурлаар Ус сувгийн удирдах газрын харьяа “Харгиа” урьдчилан цэвэрлэх байгууламжийн боохир усны үйлчилгээний түр тариф тогтоох тухай асуудлыг хэлэлцэн, шийдвэрлэв.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг Зохицуулах зөвлөл 2014 оны 6-р сарын 13-нд хуралдаж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай зөвшилцөж, Улаанбаатар хот, Налайх, Багануур, Төв аймгийн Орон сууц, үйлдвэр, аж ахуйн нэгжийн усны үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх шийдвэр гаргалаа.

Өнөөгийн бодит хэрэглээ болон цэвэр, бохир усны үйлчилгээний өртөг зардлыг хянаж үзсэний үндсэн дээр зардлаа нөхөж, хэрэглэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү алхмыг хийж байгаа бөгөөд Улаанбаатар хотод орон сууцны цэвэр усны төлбөр 1л ус 48 мөнгө, бохир усны төлбөр 24 мөнгө байхаар тогтов. Мөн хэрэглэгчийг усаар тасралтгүй хангаж, 24 цаг бэлэн байлгахад шаардагдах зардлыг нөхөх, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах зорилгоор усны суурь хураамжийг нэвтрүүлэхээр болов. Усны суурь хураамжийг Улаанбаатар хотын орон сууцны нэг өрх сардаа 2500 төгрөг төлөхөөр тогтоосон бөгөөд энэ нь хоногт 83 төгрөг, Багануур, Налайх, Төв аймагт 1800 төгрөг буюу хоногт 60 төгрөг болж байгаа юм.

Үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр усны тариф Улаанбаатар хотод 91 мөнгөөс 1.2 төгрөг, бохир усны тариф 60- мөнгөөс 1.5 төгрөг, Налайх цэвэр усны 1.67-1.8 төгрөг, бохир ус 1.2-1.3 төгрөг, Багануур дүүргийн цэвэр, бохир усны тариф 1.15-1.2 төгрөг, Төв аймгийнх 1.83-2.28 төгрөг болж нэмэгджээ.

Усны үйлчилгээний үнэ сүүлийн 4-9 жил өөрчлөгдөөгүй, тогтвортой байсан нь салбарыг уналтад оруулж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөн, улмаар хэрэглэгчдийг хохироох үзэгдэл түгээмэл болох нөхцөл болсон байна.

Дээрх шийдвэртэй холбогдуулан Усны үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааны өртөг, зардлыг хянаж, үйлчилгээний чанарт хатуу хяналт тавьж ажиллана гэдгийг мэдэгдэж байна.

# МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН СУРГАЛТ СЕМИНАР

## А. ДОТООД СУРГАЛТ

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо салбарын удирдлага болон инженер техникийн ажиллагсадын мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулж хот, хөдөөгийн нийтийн аж ахуй, ус сувгийн байгууллагуудад мэргэжлийн 8 төрлийн сургалтад 149 инженер техникийн ажилтан хамруулж мэдлэг, мэргэжил олголоо. Үүнд:

1. Нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудын бичиг хэргийн ажилтаны мэргэжил дээшлүүлэх сургалт мөн байгууллагуудын орон тооны болон орон тооны бус Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нарт Тарифын хэлэлцээр байгуулах ойлголтын сургалтыг 2014 оны 04-р сард тус тус зохион байгууллаа.
2. 2014 оны 04 дүгээр сарын 07-12-ны хооронд 5 хоногийн “ЦАХИЛГААНЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ” чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад хөдөө орон нутгийн 5 инженер техникийн ажилтан хамрагдлаа. Сургалтад хамрагдсан ажилчдыг сүүлийн үеийн шинэ техник технологитой танилцуулж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж мэргэжлийн зөвлөх инженерүүд хичээл заалаа.
3. 2014 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын Удирдах ажилтаны зөвлөгөөн зохион байгуулахгүй болсотой холбогдуулан Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо салбарын байгууллагын дарга, захирал нарт «НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТАНЫ» 3 хоногийн сургалт, хэлэлцүүлгийг 2014 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад орон нутгийн 19 байгууллагын захирал, удирдлага, Улаанбаатар хотын 10 байгууллагын удирдлага нийт 29 удирдах ажилтан хамрагдаж сургалт амжилттай зохион байгуулагдлаа.





Орон сууц, нийтийн аж ахуйн салбар нь тасралтгүй үйл ажиллагаа үйлчилгээний байнгын бэлэн байдлыг шаарддаг онцлогтой үйлчилгээний цөөн салбаруудын нэг юм. Салбарын өмнө шийдвэрлэгдэж зохицуулагдаагүй, шийдвэрлэх шаардлагатай нэлээд асуудал тулгамдаж байгааг сургалтад хамрагдсан удирдлагууд хөндөн ярилцаж, цаашид авах арга хэмжээний талаар өргөх бичиг гарган санал гарган Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлд хүргүүлээ, мөн сургалтад хамрагдсан байгууллагын дарга, захирлууд салбарын өмнө тулгамдаж буй асуудлаар хэвлэлийн бага хурал хийлээ.

Мөн нийт сургалтад хамрагдсан удирдлагууд “Барилга экспо-2014” үзэсгэлэнд оролцлоо. Тус үзэсгэлэнд гадаад, дотоодын 240 гаруй компани, аж ахуйн нэгж оролцож өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд танилцуулсан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр “Дэвшилтэт техник технологийн танилцуулга”, “Ханган нийлүүлэгч, хөрөнгө оруулагчдын бизнес уулзалт” зэрэг олон сонирхолтой арга хэмжээ зохиогдлоо.

“ГЕО МАНДАЛ” жуулчны баазад нэг өдрийг цэвэр агаарт сайхан өнгөрүүлж, Улаанбаатар хотын Ус хангамжийн дээд эх үүсвэр, насосны станцтай танилцлаа.

4. Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, “ЦЭГЦ ТӨВ БОГД АУДИТ” ХХК-тай хамтарч 2014 оны 05 дугаар сарын 12-оос 16-ны өдрүүдэд 5 хоног “Нягтлан бодогч”-дын сургалт зохион байгууллаа. Тус сургалтад Улаанбаатар хотоос 2, орон нутгаас 7 нийт 9 компанийн Нягтлан бодогч хамрагдлаа.



5. “Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо”, УСУГ-н сургалтын төв, Монголын үйлдвэрчний эвлэлийн хорооны сургалтын төвтэй хамтран “Хүний нөөцийн удирдлага” сэдэвт 5 хоногийн сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад хот, хөдөө орон нутгийн 10 Хүний нөөцийн менежер хамрагдсан бөгөөд сургалтаар Хүний нөөцийн менежмент, Хүний нөөцийн менежерийн үндсэн асуудал, Хүний нөөцийн менежерийн баримтлах зарчим, Хүний нөөцийн менежерийн удирдлага зохион байгуулалт, Удирдах ухааны арга барил, ур чадвар, Хүний нөөцийн бодлого стратеги, Хөдөлмөрийн харилцааны ёс зүй, тулгамдаж буй асуудал, Хүний нөөцийн бүрдүүлэлт, оновчтой сонгон шалгаруулалт, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний систем, Цалин хөлс урамшууллын систем гэх зэрэг нийт 21 цагийн сургалт явуулж УСУГ, ОСНААУГ-н Захиргаа хүний нөөцийн хэлтэстэй танилцаж туршлага судаллаа.





6. Налайх дүүрэгт нийт 7 хороодын гэр хорооллын 23000 гаруй иргэдэд зөөврийн усан хангамжаар 30 ус түгээх цэгт цэвэр ус түгээх үйлчилгээ үзүүлж байна. Иргэдийн хүсэлтээр 7 хоногийн 2, 3, 4 дэх болон хагас бүтэн сайн өдрүүдэд ажилладаг, нийт ус түгээх цэгийн 14 худаг Ус түгээх шугамд холбогдсон, 14 түгээх цэгт 2 авто машинаар усыг зөөж, үйлчилж байна. Эдгээр ус түгээх цэгт үйлчилж байгаа “Гэр хороололлын ус түгээгүүрийн шугамаас буюу зөөврөөр ус түгээгч” нарт Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Холбооноос 2014 оны 05 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулсан ба сургалтад 30 хүн хамрагдаж, идэвхи санаачлагатай оролцож, чадамжийн гэрчилгээ гардан авлаа. Энэ сургалтад Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооноос 3 мэргэжлийн багш нар ирж газар дээр нь сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олгож, сургалтад хамрагдсан Ус түгээгчид маш өндөр сэтгэгдэлтэй байлаа.



7. “Ус яагаад байгаль дахь хамгийн гайхалтай энгийн, аюулгүй, үнэгүй, үр дүнтэй эм болохыг мэдэх” сэдэвтэй 2 цагийн лекцийг Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын инженер техникийн ажилтнууд, Улаанбаатар хотын Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын усны инженерүүдэд Канад улсад амьдран суудаг Монгол мэргэжилтнүүд лекц уншлаа.

#### Б. ГАДААД СУРГАЛТ

Хөгжилтэй орны зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллаж туршлага судлах, харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага, техник технологитой газар дээр нь танилцаж өөрийн улс орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс дараах сургалт, үзэсгэлэн, семинарыг зохион байгууллаа. Үүнд:

1. Бүгд найрамдал Солонгос улсын Сөүл хотод “Орон сууц ашиглалт, менежмент техникийн сургалт”-д 2014 оны 02 дугаар сарын хооронд 6 хоногийн сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар Солонгос улсын орон сууц ашиглалт, орон сууцны менежмент, барилга барих явц, барилгыг хүлээн авах зэрэг асуудлуудаар туршлага судалж, газар дээр нь танилцаж туршлага судаллаа. Сөүл хотын “Вүүри” ХХК-ийн орон сууцны конторын үйл ажиллагаатай танилцаж, оршин суугч айл өрхөөр орж танилцлаа.





Солонгос Улсын Дулааны Шугам Сүлжээний Газрын харьяа дулааны цахилгаан станцын үйл ажиллагаатай сонирхлоо.

БНСУ-ын “Жанхан Инженеринг” ХХК-ний төлөөлөгчид хүлээн авч үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулж, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж болох ялтсан бойлер, насос, хаалт арматур, бакийн ажиллагааны бүдүүвч, үйлдвэрлэлт, угсралтын явцыг газар дээр нь нарийн үзэж сонирхлоо.

Мөн бидний сургалт амжилттай болсон бөгөөд чөлөөт цагаараа Сөүл хоттой танилцаж сэтгэл хангалуун ирлээ.

2. 2014 оны 04-р сарын 11–ээс 18-ны өдрийн хооронд 8 хүний бүрэлдэхүүнтэй АНУ-ын Лас Вегас хотын Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, цэвэрлэх байгууламжийг газар дээр нь үзэж туршлага судаллаа.

Мөн Лас Вегас хотын Clark County Wetland парк, Hoover Dam, Venetian Resort-уудад хэрэгжүүлсэн усны зүй зохистой хэрэглээ зөв дадал, усыг хэмнэх аргачлал болон усны нөөцийн талаар саарал усыг эргүүлэн ашиглах талаар техникийн аялал хийж, туршлага судаллаа. техникийн аялал хийж туршлага судаллаа.

Өдөр тутмын ердийн хэрэглээнээс гарч байгаа усны бараг 50 орчим хувийг гал тогооны угаагуур, душнээс гарч байгаа саарал ус эзэлдэг байна. Усанд орсон дараах халуун ус нь ихэнхдээ цэвэр саарал ус байдаг. Гэтэл амьдрал дээр энэ ус шууд бохир усны шугам руу орж урсдаг. Ус болон цахилгааны хэрэглээ хоорондоо холбоотой. Усыг халаахын тулд цахилгаан энерги ихээр зарцуулж, нүүрс хүчлийг ялгаруулан улмаар байгаль орчинд агаарын бохирдол үүсгэж байна. Гэтэл хэрэглээнээс гарч байгаа халуун усыг зүгээр асгаж, үргүй зардал өссөөр л байдгийг бид анзаардаггүй.

Саарал уснаас гаргасан цэвэршүүлсэн усыг дараах байдлаар эргүүлэн ашигладаг байна:

- Зүлэг услах
- Суултуурын ус
- Машин угаах гэх мэт.

Мөн саарал уснаас гарсан халуун усны температурыг ашиглан халуун ус халаахад хэрэглэж байна. Саарал усны системийг нэвтрүүлснээр цэвэр усны нөөц баялагийг хэмнэх, агаарын бохирдлыг багасгах зэрэг өндөр ач холбогдолтой гэдгийг бид Америкийн нэгдсэн улсын Лас Вегас хотод хийсэн сургалтаар сайн мэдэж авлаа.

Америкийн нэгдсэн улсын Лас Вегас хот, Сан Франциско хоттой танилцаж, аяллаа.

3. 2014 оны 06-р сарын 16-24-ны хооронд Дархан, Эрдэнэт, Зүүн хараа Улаанбаатар хотын орон сууцны Захирлууд оролцсон Усан хамгамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бидний хэсэг төлөөлөгчид Улаанбаатар хотын Ус Сувгийн Удирдах газрыг олон жил удирдсан туршлагатай ахмад ажилтан Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат Б.Пүрэвжавын удирдлагаар Японы Саппоро хотын усан хангамжийн системийг үзэж танилцах хамтран ажиллах боломж нөхцөлийг судлах зорилгоор очиж ажиллаад ирлээ.



Саппоро хот нь Японы уулархаг хэсэгт хамаарах учир уулын цэнгэг гол элбэгтэй юм. Иймд уулын ундарга сайтай голууд дээр Далан суваг / 80-1174 өндөр / барьж Усан сан байгуулан / сэтгүүлийн зураг / түүнээсээ “Усан цахилгаан станц” ажиллуулан өөрийн хэрэгцээний цахилгааныг үйлдвэрлэхийн зэрэгцээ хотынхоо Усан хангамжийг хамт шийдвэрлэсэн нь сонирхолтой анхаарч үзэх шийдэл байлаа. Ус түгээх шугамыг авто замын доогуур байрлуулан 40 жилийн хугацаатай ашиглах нормтой сайжруулсан ширмэн хоолойгоор хийдэг байна. Усны алдагдал нь маш бага 2,9% байна.

Өөр нэг зүйл нь албан ёсны уулзалт яриаг маш нарийн төлөвлөж зохион байгуулахын зэрэгцээ зочиддоо ихээхэн хүндэтгэл үзүүлж хандах юм. Нэг жишээ дурдахад уулзалт ярилцлагад хэн хэн хэдэн удаа оролцох ямар байршлаар суух зэргийг урьдчилан төлөвлөсөн байлаа. Энэ нь маш сайхан санагдсан.

Саппоро хотын усан хангамжийн системтэй бүрэн танилцсан. Гадаргын усыг маш өндөр технологээр цэвэршүүлдэг, хяналтын системтэй, шугамын усыг шууд хэрэглэж болох ба хэрэглэгчдэд хүргэдэг байна. Энэ хотын Ус ашиглалтын байгууллагын хүмүүс Улаанбаатарт ирж ажиллаж зөвлөгөө өгч байсан. Дахин ирж ажиллах хүсэлтэй хүмүүс олон байсан.

Нөгөө нэг зүйл нь Саппоро хотын усан хангамжийн компани нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Японы Жайка төсөлд “ сургалт сурталчилгаа” явуулах төслийг санаачлан Японы Засгийн Газартаа өргөн бариад байгаа юм байна. Хэрэв энэ төсөл нь дэмжигдвэл санал тавьсан улс орны хотуудын мэргэжил нэгт хүмүүстэй хамтран ажиллах хүсэлтэй байгаа тухайгаа бидэнд хэлсэн.

Япон орны хувьд хот байгуулалт нь маш нарийн төлөвлөгдсөн ногоон байгууламж, зам талбай, хотын тохижилт нь гайхамшигтай. Энэ том хотуудад машин замаар дохиогүй, түгжирсэн гудамж харсангүй. Төрийн





маш сайн хатуу бодлоготой юм. Банк болгон мөнгө солихгүй солих банк нь нилээд бичиг цаас бүрдүүлэх юм. Хүндрэлтэй тал нь Од мич дээр баримжаа авах боломжгүй юм. Хэт өндөр барилгууд нь алсын барааг хааж байна. Бүтээн байгуулалт хөгжил, үйлчилгээ нь гайхамшигтай байлаа.

Мөн бид Япон Токио хот, Нарито хоттой танилцаж маш гайхалтай хөгжилтэй танилцлаа.



Япон орны аяны сэтгэгдэл бичсэн: Дархан-Уул аймгийн Дархан Ус Суваг ХК-ийн ЗУХ-ийн дарга Х. Бааст



# “БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, СУРГУУЛЬ, ӨРХИЙН ТҮВШИНД УСНЫ АЮУЛГҮЙ ХЭРЭГЛЭЭ, БАТАЛГААТАЙ ХАДГАЛАЛТ” ОРОН НУТГИЙН СУРГАГЧ БАГШ НАРЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЯВУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

Сургалт явуулсан огноо: 2014.04.01-2014.04.03  
Сургалт явуулсан газар: Хөвсгөл аймаг, Мөрөн хот,

## ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

**СУРГАЛТЫН ЗОРИЛГО:** Сургууль, өрхийн түвшинд усыг халдваргүйжүүлэх, баталгаатай хадгалах талаар сургуулийн бага ангийн суралцагчид болон өрхийн ойлголтыг нэмэгдүүлж, усны аюулгүй хэрэглээг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах орон нутгийн сургагч багш нарыг сургаж чадавхжуулах

Сургалтыг явуулахаар төслийг ивээн тэтгэгч байгууллага болох НҮБ-ын хүүхдийн сангийн ажилтан, Азийн сангийн ажилтан, ДЭМБ-ын чиглэлээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах сургагч багшаар бэлтгэгдсэн багш нар оролцож байгаа тухай танилцуулга хийгдлээ.

Сургалтанд төсөл хэрэгжиж байгаа Хөвсгөл аймгийн 12 сум тус бүрээс удирдах ажилтан -1 (Засаг дарга эсвэл ИТХ-ын даргын аль нэг), бага ангийн багш -1; нийгмийн эрүүл мэндийн ажилтан-1; Сүмбэр баг-1; Зүрх баг-1; Бүрэнхаан баг-1 хүн тус тус оролцсон. Үүнээс гадна аймгийн ЗДТГ, ЭМГ, МХГ-ын ажилтнууд болон Ус хангамжийн байгууллагын инженерүүд, “Далай ээж нийгэмлэг” ТББ, НҮБ-ийн Хүүхдийн сангийн орон нутаг дахь зохицуулагч зэрэг **нийт 47** хүн оролцлоо.

Бүртгэл зохион байгуулалтын ажлыг аймаг дахь “Хөвсгөл далай ээж нийгэмлэг” ТББ хариуцан явууллаа. Сургалтыг зохион байгуулахаар АНУ-ын Азийн сангийн дэд суурин төлөөлөгч Тирза Тэниссэний баталсан хөтөлбөрийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### 2014 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 1-НИЙ ӨДРИЙН СУРГАЛТ

- Сургалтыг нээж Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын дарга, аймгийн Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн ахлагч н.Төмөрбаатар үг хэлэв.
- Сургалтын зорилго хөтөлбөр, хүлээгдэж буй үр дүнгийн талаар Азийн сангийн хөтөлбөрийн ажилтан Ч. Эрдэнэчимэг товч танилцуулга хийсэн.
- Усны эх үүсвэр, хамгаалалт, усны бохирдол, сургууль өрхийн түвшинд уснаас үүдэлтэй эрүүл мэндийн асуудлууд, усны аюулгүй хэрэглээ сэдвийн дор Ханх, Тариалан, Ренчинлхүмбэ,

Цагааннуур, Арбулаг, Галт, Бүрэнтогтох, Цагаан-Үүр, Цагаан-Уул, Улаан-Уул зэрэг сумдын удирдлагууд болон Зүрх багийн төлөөлөгч нар танилцуулга хийж илтгэл тавилаа.

- Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш Б. Пүрэвжав Сургууль өрхийн түвшинд усны халдваргүйжүүлэлт, аюулгүй хадгалалтын байдалд хийсэн суурь судалгааны дүгнэлтийн талаар товч танилцуулга хийж Усны эх үүсвэр хамгаалалт, бүсийн дэглэмийн талаар сургалт явууллаа.



- Ундны усны чанарын хяналт шинжилгээний арга, усны бохирдолд үнэлгээ хийх хурдавчилсан арга зэргээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш Ц. Болормаа онолын хичээл зааж дадлагын ажил хийлгэлээ.






- Устай холбоотой эрүүл мэндийн байдал, уснаас шалтгаалан үүсэх халдварт өвчнүүд сэдвээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш С. Бумаа хичээл зааж оролцогсдыг баг болгон ажиллуулж баг тус бүрээс ахлагчаар нь илтгэл тавиулан хэлэлцүүлээ.



- Цэцэрлэг сургуулийн байгууллагын усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах шаардлага, өрхийн түвшинд усыг цэвэршүүлэх, тунгаах, шүүх, халдваргүйжүүлэх чиглэлээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш Б. Пүрэвжав хичээл зааж дадлагын ажил хийлгэлээ.




- Өрхийн түвшинд ус цэвэршүүлэх, тунгаах, шүүх, халдваргүйжүүлэх ажлын чиглэлээр Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш Б. Пүрэвжав хичээл зааж дадлагын ажил хийлгэлээ. Үүнд: Химийн бодис болон халдваргүйжүүлэгч хэрэглэгчгүйгээр өрхийн түвшинд усыг цэвэршүүлэх зориулалттай бортогот мембран шүүлтүүрийг хэрхэн хэрэглэх талаар зөвлөгөө өгсөн бөгөөд уг шүүлтүүрийг 12 сум, 3 багт жишиг болгон тарааж өгсөн.
- Эхний өдрийн сургалтаар өгөгдсөн мэдээллүүдийг үндэслэн чөлөөт асуулт хариултын хэлбэрээр ярилцлага явуулж хүмүүсийн санал сэтгэгдлийг сонсон тулгамдсан болон сонирхсон асуултаудад хариулт өгөх арга хэмжээг зохион байгууллаа.

### 2014 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 2-НЫ ӨДРИЙН СУРГАЛТ

- Өмнөх өдрүүдэд заасан хичээлийн сэдвүүдийн мэдлэгийг бататгах зорилгоор Азийн сангийн хөтөлбөрийн ажилтан Ч. Эрдэнэчимэг “АХА” хэлбэрийн асуулт хариулт бүхий тэмцээнийг явуулан багуудад оноо өгч байр эзлүүлэн дүгнэлээ.
- Өрхийн ундны усыг зөөвөрлөх, аюулгүй хадгалах чиглэлээр Усны аюулгүй байдлын сургагч багш Ц. Болормаа, ус хадгалах савны талаар Усны аюулгүй байдлын сургагч багш Б. Пүрэвжав нар мэдээлэл хийж сургалт явууллаа. Дараах асуултын дагуу 5 багт хувааж багаар ажиллуулсан баг тус бүр ярисаны дараа нийтээр хэлэлцсэн. Үүнд:
- Усыг авах явцад ус хэрхэн бохирддог вэ? (гол мөрөн, худгаас)



- Усыг зөөвөрлөх явцад ус хэрхэн бохирдох бэ? Усыг хэрхэн зөв зөөвөрлөх вэ?
- Усыг хадгалах явцад ус хэрхэн бохирдох бэ? Усыг хэрхэн зөв хадгалах вэ?
- Усыг зөөвөрлөх, хадгалах савны шаардлага
- Хүүхдийн ус уух савыг хэрхэн цэвэрлэх дараалал.





Багаар ажилласны дараа багш Б. Пүрэвжав дараах 4 байдлаар оролцогчдыг идэвхижүүлэн хүүхдийн ус уух сав, өрхийн түвшинд ус хадгалах сав, хүүхдийн ус уух савыг хэрхэн угаах болон гар угаах саван, сав угаах шингэнүүдийн талаар тайлбарлан заав.

1. Эдгээр савласан ус болон хүүхдийн ус уух савнуудаас та бүхэн сонголт хийнэ үү, яагаад энэ савыг сонгосноо тайлбарлана уу?



2. Эдгээр ус хадгалах савнуудаас та бүхэн сонголт хийнэ үү, яагаад энэ савыг сонгосноо тайлбарлана уу?





3. Эдгээр гар угаах саван, угаагч шингэнүүдээс та бүхэн сонголт хийнэ үү, яагаад үүнийг сонгосноо тайлбарлана уу?



4. Та хэрхэн сав угаадаг вэ, сав угаах дарааллын дагуу хүүхдийн ус уух савыг угааж үзүүлнэ үү?

- Сургуулийн орчны усны чанарыг сайжруулах дэд бүтцийг хөгжүүлэх, чиглэлээр сургагч багш Б. Пүрэвжав хичээл зааж хөдөө орон нутагт ус хангамжийн инженерийн байгууламжийн овор багатай төхөөрөмжүүдийг хэрхэн сонгох авах талаар мэргэжлийн зөвлөгөө өглөө.
- Жижиг суурин газар буюу сумдад Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар Усны аюулгүй байдлын сургагч багш Б. Пүрэвжав, С. Бумаа, Ц. Болормаа нар алхам тус бүрээр хичээл заан товч ойлголт өглөө.

- Орон нутагт өрхийн сургалтыг хэрхэн явуулах талаар Азийн сангийн хөтөлбөрийн ажилтан Ч. Эрдэнэчимэг танилцуулга хийсэн бөгөөд өрхийн сургалтыг зохион явуулах хуваарийг “Хөвсгөл далай ээж нийгэмлэг” ТББ-ын тэргүүн Ж. Оюумаа танилцууллаа.
- Нийт оролцогчдод сургалтын гарын авлагын эхний хувилбарыг тараан өгч сургалтын дараа сургалтын чанарын үр дүнг тодорхойлох дүгнэлтийн хуудсыг бөглүүлэн, тараан өгсөн гарын авлагуудад оруулах өөрчлөлтийн талаар санал авлаа.

Сургалттай холбоотой туршилтын хэрэгсэл, усны чанарын шинжилгээний хяналт шинжилгээний тоног төхөөрөмж бүхий хайрцаг зэргийг 12 сум, 3 багт гардуулан өгч оролцсон сургагч багш нарт “Сургагч багш” сертификатыг олголоо.



- Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний сургагч багш Б. Пүрэвжаваас сургалтанд оролцогчдод гарын авлага болох ном, сэтгүүл, зурагт хуудсыг гардуулан өгч ажлын амжилт хүслээ. Өгсөн номын жагсаалтыг хавсаргав.





Нийт сургалтанд оролцогчид дурсгалын зураг авахууллаа.



#### 2014 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 3-НЫ ӨДРИЙН СУРГАЛТ

Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр сум суурин газарт болон аймгийн төвд хэрхэн явуулах талаар төсөлд хамрагдаж байгаа сумдын удирдлагууд болон Хөвсгөл аймгийн усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийнхэнтэй хийх уулзалт ярилцлагын ажлыг зохион байгууллаа.



Уулзалт ярилцлагыг аймгийн ЭМГ-ын дарга Л. Дамдинсүрэн нээж үг хэлсэн бөгөөд аймаг орон нутгаас хүсэлт болгосны дагуу уг сургалтыг зохион байгуулж байгаа НҮБ-ын хүүхдийн сан, Азийн сан, сургалт явуулж буй сургагч багш нарт талархал илэрхийллээ.



Мөн эхний 2 өдөрт зохион байгуулсан сургалтын ажлын чанар үр дүнгийн талаар НҮБ-ын хүүхдийн сангийн ажилтан Батнасан, ЭМГ-ын хэлтсийн дарга Лхагвасүрэн нар үг хэлж талархал илэрхийллээ (Хэлсэн үгийг хавсаргав).

Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах сургалтыг үдээс өмнө нийт оролцогчдод жижиг суурин газар буюу сумдад 6 алхамаар, үдээс хойш хот суурин газар буюу аймгийн төвд 11 үе шатаар хэрхэн яаж явуулах талаар ДЭМБ-аас боловсруулсан зөвлөмжийн дагуу хичээл зааж оролцогсдыг баг болгон ажиллуулж хийсэн ажлынх нь талаар илтгэл тавиуллаа. Үүнд: Усны аюулгүй байдлын баг бүрдүүлэх, ус хангамжийн тогтолцооны зураглал зуруулах, эрсдлийг тооцох гэсэн 3 сэдвээр 3 удаа багаар ажиллуулсан.



#### 2014 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 4-НИЙ ӨДӨР

Сургалт явуулсан багийн бүрэлдэхүүн Хөвсгөл аймгийн Мөрөн хотын ус хангамжийн системийн байгууллагуудын тогтолцоо, удирдлага зохион байгуулалт, лабораториудын үйл ажиллагаатай газар дээр нь явж танилцан санал солилцлоо. Аймгийн төвийн төвлөрсөн болон гэр хорооллын усан хангамжийн асуудал хариуцсан "Хөвсгөл Ус чандмань" ХХК, "Хөвсгөл УСНААК" зэрэг газрууд болон Цэвэр усны 2-р өргөгч насосны станцын ажиллагаатай танилцан цэвэр усны лаборатори байгуулахаар бэлтгэж байгаа байдал, Мэргэжлийн хяналтын газарт ундны цэвэр усыг хэрхэн шинжилж байгаатай танилцан цаашид анхаарах асуудлын талаар холбогдох мэргэжилтнүүдэд зөвлөгөө өглөө.

ТАЙЛАН БИЧСЭН: УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАГЧ БАГШ  
С. БУМАА Ц. БОЛОРМАА



# “НААУБАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОГДСОН “ЧАНДМАНЬ-ЭРДНИЙН ЭЗЭД 2014” АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УЛСЫН УРАЛДАА”-НЫ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ



Ажил мэргэжлийн ур чадварыг сонгон шалгаруулах уламжлалт улсын уралдааныг “Дархан Ус Суваг” ХКнь БХТөв, УБ хотын ОСНААУГазартай хамтран 2014 оны 06 сарын 26 - 28-ны өдрүүдэд Дархан хотод амжилттай зохион байгууллаа.

Ажил мэргэжлийн Улсын уралдааны нээлтийн ажиллагаа “Дархан -50” цогцолборт болж БХБЯамны Барилгын Хөгжлийн Төвийн дарга Б Баярсайхан, Дархан-Уул аймгийн ЗДТГазрын ХБХ-ийн дарга С Баясгалан, ЗДТГазрын дэргэдэх захирагчийн ААбаны дарга Б Батжаргал, Дархан сумын Засаг дарга Б Азжаргал, “Дархан Ус Суваг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Батбаяр, УБ ОСНААУГазрын дэд захирал, ерөнхий инженер М Дашзэвэг, УБ Ус Сувгийн Удирдах Газрын ерөнхий инженер Д Эрдэнэбат, Хот Суурины УХАТАҮйлчилгээг Зохицуулах Зөвлөлийн Эрх Зүйн Мэдээлэл Захиргааны Албаны дарга Б Доржбат, “Мөнх Од Цацрал” ХХК захирал Ю.Таванжин зэрэг орон нутгийн төлөөлөгчид оролцлоо.



Зорилго: НААБайгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, салбарын мэргэжилтэй ажилтнуудын ажилын ур чадварыг дээшлүүлэх, ажлын туршлагыг харилцан солилцуулах хэрэглэгчдийн шугам сүлжээний ашиглалтын түвшин сайжруулахад тэмцээний зорилго байлаа.

Уралдаанд нийт 9 баг оролцсон.ҮҮНД:

- 1.УБ хотын ОСНААУГазар 1-р баг
- 2.УБ хотын ОСНААУГазар 2-р баг
- 3.Хувийн хэвшлийн ОСНААХөгжлийн Төв
- 4.Сэлэнгэ аймаг “Урсгал-Ус” ХХК
- 5.Хөтөл “Гавшгай ус” ХХК
6. “Дулаан Шарын гол” ТӨХК
- 7.“Дархан Ус Суваг” ХК 1-р баг
- 8.“Дархан Ус Суваг” ХК 2-р баг
- 9.УБ хот УСУГ-ын ОСААЛба

Төлөвлөсөн ажлын дагуу зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулан, нээлтийн арга хэмжээг “Дархан 50” цогцолборт хийж, нийт баг хамт олонд ХХАА-ны зааварчилга өгч ажилласан. Тэмцээний хугацаанд баг тамирчид, удирдлага зохион байгуулалтын хувьд сахилга дэг журамтай, осол авааргүй амжилттай ажилласан болно.



Тэмцээнд оролцсон баг тамирчдыг байр эзлүүлэн удирдамжид заасны дагуу 1,2,3-р байр, тусгай байр, хувийн амжилтаар шилдэг гагнуурчин, шилдэг сантехникч шалгаруулан шагнаж урамшууллаа.

Тэмцээн нь: УБ хотын ОСНААУГазрын болон орон нутгийн мэргэжил нэгт байгууллагуудын ажилчдын ажиллаж байгаа байдал ур чадварыг биечлэн үзэж, туршлага судлан орон сууцны подволуудын шугам хоолойг хэрхэн ажлын байр бэлтгэж, ажлыг хурдан хугацаанд ур чадварын өндөр түвшинд хийж гүйцэтгэж байгааг үзэж, харилцан туршлага солилцож, хамтран ажиллаж суралцаж, бас уралдаж цаашид өөрсдийнхөө ажилд дүгнэлт хийж, санамж дүгнэлт авсан үр өгөөжтэй ажил боллоо гэж дүгнэлээ.

7 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг ажиллав. Шүүгчид мэрэгжлийн ур чадвар, ажил гүйцэтгэсэн хугацаа, гүйцэтгэлийн чанар, шинэ дэвшилтэт техник технологи ашиглаж байгаа байдал, ур чадвар, хугацаа зэрэг 10 үзүүлэлтээр 100 онооны системээр шүүсэн.

Багийн тэмцээний 6 сарын 27-ны эхний өдөр Хээтэй хорооллын 4.1 байр, Шинэ хорооллын 20 байр, Хуучин хорооллын 32.34-р байруудын нийт 9 блокийг сугалаагаар сонгож, багууд тус байруудын усан хангамжийн хуучин шугам хоолойг буулгаж, шинээр угсралт, холболтын ажлыг бүрэн хийж дуусган хүлээлгэж өгсөн.

Дараагийн өдөр нь 6 сарын 28-нд 4.1 байранд туршлага солилцох хамтарсан ажиллагааг явуулахын тулд 9 багаас буулгалтын 1 баг, угсралтын 1 баг зохион байгуулж ажилласан. Мөн хийж буй ажилбаруудад гагнуурчин болон засварчны хувь хүний ур чадварыг шалгах тэмцээнийг зохион байгуулав.



Тэмцээнд оролцсон баг тамирчдыг байр эзлүүлэн удирдамжид заасны дагуу 1,2,3-р байр, тусгай байр, хувийн амжилтаар шилдэг гагнуурчин, шилдэг сантехникч шалгаруулан шагнаж урамшууллаа.



1-р байр: УБ хотын ОСНААУГазар 1-р баг



2-р байр :УБ хотын ОСНААУГазар 2-р баг



Шилдэг засварчнаар  
"Дулаан Шарын гол" ТӨХК –ийн  
ЗАСВАРЧИН  
С.Бямбацогт

Шилдэг гагнуурчин  
"Дулаан Шарын гол"  
ТӨХК –ийн  
ГАГНУУРЧИН  
Х.Мейрамгуль

3-р байр: Хувийн хэвшлийн ОСНААХөгжлийн Төв



Тусгай байр:  
Сэлэнгэ аймаг "Урсгал-Ус" ХХК

Ирэх 2015 онд тустэмцээнийг Хувийн хэвшлийн ОСНААХөгжлийн Төв зохион байгуулахаар боллоо.

Ерөнхий зохион байгуулагч: Ерөнхий инженер Д Эрдэнэчулуун



## ДОРНОГОВЬ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ЗҮҮН БҮСИЙН НААБАЙГУУЛЛАГУУДЫН АЖИЛ МЭРГЭЖИЛ, СПОРТЫН VIII НААДМЫН ТАЙЛАН



Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний байгууллагуудын ажил мэргэжлийн онцлог, амжилт бүтээл, ур чадварыг олон нийтэд сурталчлах, харилцан туршлага солилцох, мэргэжил нэгт байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж хөгжүүлэх, ажилтнуудынхаа ажил мэргэжлийн болон спортын ур чадварыг сорих зорилгоор 2014 оны 05 дугаар сарын 23-наас 25-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд хотноо Зүүн бүсийн НААБ-дын ажил мэргэжил, спортын VIII наадмыг амжилттай зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болон зохиогдож ирсэн энэ удаагийн наадамд Багануур, Налайх, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь аймгийн баг тамирчид авхаалж самбаа, хурд хүчээ сорьлоо.

Зүүн бүсийн НААБ-дын VIII наадам ажил мэргэжлийн, спортын гэсэн 2 хэлбэрээр явагдсан бөгөөд ажил мэргэжлийн буухиа тэмцээнд аймаг тус бүрээс ИТА-1, гагнуурчин-1, сантехникийн засварчин-1, цахилгаанчин-1, жолооч-1-ийг тус тус хамруулж чиглэл тус бүрээр даалгавар гүйцэтгэсэн нь өмнөх жилүүдийнхээс шинэлэг, онцлог арга хэмжээ боллоо.

Спортын тэмцээнийг нийт 4 төрлөөр зохион байгуулсан бөгөөд үүнд:

1. Элсний хөл бөмбөг

2. Шагайн харваа

3. Шатар

4. Олс таталтын төрлүүд багтсан болно.

Тэмцээн тус бүрээр багийн болон ганцаарчилсан төрлөөр байр эзлүүлж медаль, өргөмжлөлөөр шагнасан ба бүх тэмцээний нийлбэр дүнгээр багаар нь байр эзлүүллээ.

Багийн нийлбэр дүнгээр:

Тэргүүн байрт Б. Лхагва захиралтай Дорноговь аймгийн "Чандмань-Илч" ХХК-ийн баг тамирчид, Дэд байрт Борхүү даргатай Хэнтий аймгийн "Хэнтий-Ус" ХХК-ийн баг тамирчид,

Гутгаар байрт Жаргалсайхан даргатай Багануур дүүргийн "Багануур-Ус" ААТНӨҮГазрын баг тамирчид шалгарлаа.

Ажил мэргэжил, спортын төрлүүдээр авхаалж самбаа, хүч тамир сорьсоноос гадна Дорноговь аймгийн байгалийн болон түүхийн дурсгалт газрууд болох Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан Хамрын хийд, 108 агуй, Энергийн төв, Хан Баянзүрх хайрхантай танилцуулах тойрон аялал зохион байгууллаа.

Зүүн бүсийн НААБ-дын уламжлалт наадмын Шилжин явах тугийг Алтансүх захиралтай Сүхбаатар аймгийн "Дөрвөлж" ХХКомпанид хүлээлгэн өглөө.

Танилцуулга бичсэн: Хүний нөөцийн менежер Б. Эрдэнэчимэг



Ажил мэргэжлийн тэмцээн /гагнуурчид/



“Багануур-Ус” ХХК- ийн тамирчид



Ажил мэргэжлийн тэмцээн /сантехникийн холболт/



“Дөрвөлж” ХХК- ийн тамирчид



Олс таталтын тэмцээн



“Хэнтий-Ус” ХХК- ийн тамирчид



“Хэнтий-Ус” ХХК-ийн тамирчид



Багийн нийлбэр дүнгээр Тэргүүн байрт шалгарсан Дорноговь аймгийн “Чандмань- Илч” ХХК- ийн баг тамирчид



Багийн нийлбэр дүнгээр Дэд байрт шалгарсан Хэнтий аймгийн “Хэнтий-Ус” ХХК- ийн баг тамирчид



Багийн нийлбэр дүнгээр Гутгаар байрт шалгарсан Багануур дүүргийн “Багануур-Ус” ХХК- ийн баг тамирчид



Хаалтын ажиллагаа



Шилжин явах тугийг Сүхбаатар аймгийн “ДӨРВӨЛЖ” ХХК-д хүлээлгэн өгч байгаа нь

Дорноговь аймгийн «Чандмань Илч» ХХК



## ХАНГАЙН БҮСИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН УРЛАГ, СПОРТЫН ТЭМЦЭЭН

2014.06.17 Булган сум

Хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дунд зохион байгуулагдах урлаг спортын тэмцээнийг байгууллагын захирлын тушаалаар томилогдсон 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулаж явууллаа.

Тэмцээний удирдамжийг зохион байгуулах комиссын зүгээс боловсруулан захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2014 оны 05-р сарын 14-ны өдрөөс эхлэн хангайн бүсийн нийт 6 аймгийн НАА-н байгууллагууд руу хүргүүлсэн.

Хангайн бүсийн нийтийн аж ахуйн байгууллагуудын дунд зохион байгуулагдах урлаг спортын тэмцээний гол зорилго нь нийтийн аж ахуйн байгууллагуудын ажиллагсадын ажлын уялдаа холбоо, туршлага солилцох, танилцах, бие бялдарыг чийгрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажлын алжаал, стрессыг тайлахад оршино. Тэмцээн уралдаан 2014 оны 06-р сарын 05-ны өдрөөс эхлэн 2014 оны 06-р сарын 08-ны өдрүүдэд Булган аймгийн Булган суманд болсон.

Тэмцээнд

1. Булган аймаг-“Булган- Мээж” ХХК
2. Орхон аймаг- “Эрдэнэт-Ус” дулаан түгээх сүлжээ ОНӨХК
3. Өвөрхангай аймаг- “Онги-Ус” ОНӨХК
4. Дундговь аймаг-“Дундговь Ус” ОНӨХК
5. Баянхонгор аймаг- “Чандмань Баянхонгор” ХК
6. Архангай аймаг – “Ундрага” ХХК
7. Хөвсгөл аймаг- “УСНААК” ОНӨХК зэрэг нийт хангайн бүсийн 7 аймаг оролцсон.

Тэмцээн гар бөмбөг, шатар эрэгтэй, эмэгтэй, теннис эрэгтэй, эмэгтэй, гоцлол дуу эрэгтэй, эмэгтэй, хос дуу гэсэн төрлүүдээр явагдсан.

2014 оны 06-р сарын 05-ны өдөр аймгийн зочид, баг тамирчдыг хүлээн авч амрах газарт

нь байрлуулан 06-р сарын 06-ны өдөр болох тэмцээний техникийн зөвлөгөөнийг баг тамирчдын төлөөлөл болон арга хэмжээг зохион байгуулах комисс болон тэмцээнийг шүүн явуулах шүүгч нарын хүрээнд явуулан тэмцээн бүрийг тойргийн журмаар явуулахаар тогтсон.

2014 оны 06-р сарын 06-ны өглөө тэмцээний нээлт эхлэн Дундговь, Архангайн тоглолтоор эхэлсэн. Гар бөмбөгийн тэмцээнтэй зэрэг теннис болон шатрын тэмцээн эхэлсэн. Тухайн өдрөө гар бөмбөгийн тэмцээний 14 тоглолт явагдаж, теннисний тэмцээн аваргуудаа шалгаруулсан. Тэмцээний орой урлагын бага наадам явагдан төрөл төрлөөр аваргуудаа шалгаруулан “Булган-Мээж” ХХК-ны зүгээс ирсэн баг тамирчиддаа зориулж урлагын тоглолт хүргэсэн. Ийнхүү тэмцээний нэг өдөр өндөрлөж баг тамирчид амрах байрандаа очиж байрласан.

2014 оны 06-р сарын 07-ны өдөр тэмцээний FINAL-ийн тоглолтууд явагдаж аваргуудаа шалгаруулсан. Тэмцээн дууссаны дараа баг тамирчид, байгууллагын дарга нарыг Булган хоттой танилцуулж аймгийн төв талбай Цогтхунтайжийн талбайд дурсгалын зургаа татуулсан. Ийнхүү оройн арга хэмжээ хүлээн авалтын эхэлж Булган аймгийн Хөгжимт жүжгийн театраас урлагын тоглолтыг баг тамирчдад зориулан хүргэж тэмцээний шагналаа гардуулсан.

2014 оны 06-р сарын 08-ны өдөр баг тамирчдыг үдэх үйл ажиллагаа эхлэн Булган нутгийн байгалийн үзэсгэлэнт газар Уран тогоо ууланд гаргаж хорхог хийж өгөн үдэж гаргасан.

Ийнхүү Хангайн бүсийн НАА-н байгууллагуудын дунд зохион байгуулагдсан урлаг, спортын арга хэмжээ 4 өдрийн турш зохион байгуулалттай эмх цэгцтэй болж өнгөрсөн. Баг тамирчид болон ирсэн зочид өндөр сэтгэгдэлтэйгээр буцсан.





### ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийтийн аж ахуйн байгууллагуудын ажиллагсадын ажлын уялдаа холбоо, туршлага солилцох, танилцах, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажлын ачаалал, стрессыг тайлахад тэмцээний зорилго оршино.

Тэмцээн 2014 оны 06-р сарын 05-ны өдрөөс 2014 оны 06-р сарын 08-ны өдрүүдэд Булган аймгийн булган суманд болж өнгөрлөө.

### ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ АЙМГУУД

- Булган аймаг- "Булган- Мээж" ХХК
- Орхон аймаг- "Эрдэнэ Ус" дулаан түгээх сүлжээ ОНӨХК
- Өвөрхангай аймаг- "Онги Ус суваг" ОНӨХК
- Дундговь аймаг- "Дундговь Ус" ОНӨХК
- Баянхонгор аймаг- "Чандмань Баянхонгор" ХК
- Архангай аймаг- "Ундрага Ус" ХК
- Хөвсгөл аймаг- "УСНААК" ОНӨХК гэсэн нийт 7 аймгийн баг тамирчид оролцсон.

### ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ

- Тэмцээн гар бөмбөг, ширээний теннис эрэгтэй, эмэгтэй, шатар эрэгтэй, эмэгтэй гэсэн төрлүүдээр явагдсан. Мөн урлагийн эрэгтэй, эмэгтэй гоцлол дуу, дуэт дуу гэсэн төрлөөр баг тамирчид өрсөлдөн аваргуудаа тодруулсан.





## ХАНГАЙН БҮСИЙН НАА-Н БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН УРЛАГ, СПОРТЫН ТЭМЦЭЭНД ШАГНАЛ АВСАН БАГ, ТАМИРЧДЫН НЭРС

№	Баг, тамирчдын нэрс	Аймгийн нэр	Тэмцээний төрөл	Байр
1	Д.Ганболд	Өвөрхангай		1-р байр
2	Ц.Баатар	Архангай	Шатар /эрэгтэй /	2-р байр
3	М.Ганхуяг	Дундговь		3-р байр
4	Х.Пүрэвдорж	Орхон		1-р байр
5	Р.Энхмаа	Дундговь	Шатар /эмэгтэй/	2-р байр
6	И.Бат-Очир	Өвөрхангай		3-р байр
7	С.Самбуудагва	Орхон		1-р байр
8	Д.Бямбацогт	Булган	Теннис /эрэгтэй/	2-р байр
9	П.Бямбатогтох	Баянхонгор		3-р байр
10	Д.Наранцэцэг	Баянхонгор		1-р байр
11	Д.Наранчимэг	Булган	Теннис /эмэгтэй/	2-р байр
12	Л.Отгонцэцэг	Орхон		3-р байр
13	Б.Мөнхбаяр	Орхон		1-р байр
14	Л.Ханбогд	Өвөрхангай	Гоцлол дуу /эрэгтэй /	2-р байр
15	П.Бямбатогтох	Баянхонгор		3-р байр
16	Д.Эрдэнэгэрэл	Баянхонгор		1-р байр
17	Д.Мягмаржаргал	Орхон	Гоцлол дуу /эмэгтэй /	2-р байр
18	Л.Наранцэцэг	Булган		3-р байр
19	Д.Түвшинбаяр	Булган	Хос дуу	1-р байр
20	Ц.Нэргүй			
21	М.Тэмүүжин	Архангай	Хос дуу	2-р байр
22	Алтанчимэг			
23	П.Бямбатогтох	Баянхонгор	Хос дуу	3-р байр
24	Д.Эрдэнэгэрэл	Орхон		1-р байр
25	Эрдэнэт- Ус ДТС ОНӨХК	Баянхонгор	Гар бөмбөг	2-р байр
26	"Чандмань Баянхонгор " ХК	Булган		3-р байр
27	"Булган- Мээж"ХХК	Орхон	Багийн нэгдсэн дүнгээр	Тэргүүн байр
28	Эрдэнэт- Ус ДТС ОНӨХК	Баянхонгор		Дэд байр
29	"Чандмань Баянхонгор " ХК	Булган		Гутгаар байр
30	"Булган- Мээж"ХХК			





## ТЭМЦЭЭНИЙ АВАРГУУД



## Шатар /эрэгтэй/

- Нэгдүгээр байр. Д.Ганболд- Өвөрхангай аймаг
- Хоёрдугаар байр-Ц.Баатар-Архангай аймаг
- Гуравдугаар байр-М.Ганхуяг- Дундговь аймаг

## Шатар /эмэгтэй/

- Нэгдүгээр байр. Х.Пүрэвдорж- Орхон аймаг
- Хоёрдугаар байр-Р.Энхмаа- Дундговь аймаг
- Гуравдугаар байр-И.Бат-Очир- Өвөрхангай аймаг



## Теннис /эрэгтэй/

- Нэгдүгээр байр. С.Самбуудагва - Орхон аймаг
- Хоёрдугаар байр-Д.Бямбацогт –Булган аймаг
- Гуравдугаар байр-П.Бямбатогтох- Баянхонгор аймаг

## Теннис /эмэгтэй/

- Нэгдүгээр байр. Д.Наранцэцэг- Баянхонгор аймаг
- Хоёрдугаар байр-Д.Наранчимэг- Булган аймаг
- Гуравдугаар байр-Л.Отгонцэцэг - Орхон аймаг



## Гоцлол дуу /эрэгтэй/

- Нэгдүгээр байр. Б.Мөнхбаяр - Орхон аймаг
- Хоёрдугаар байр-Л.Ханбогд –Өвөрхангай аймаг
- Гуравдугаар байр-П.Бямбатогтох- Баянхонгор аймаг

## Гоцлол дуу /эмэгтэй/

- Нэгдүгээр байр. Д.Эрдэнэгэрэл- Баянхонгор аймаг
- Хоёрдугаар байр-Д.Мягмаржаргал- Орхон аймаг
- Гуравдугаар байр-Л.Наранцэцэг - Булган аймаг

## Дуэт дуу

- Нэгдүгээр байр. Д.Түвшинбаяр, Ц.Нэргүй - Булган аймаг
- Хоёрдугаар байр-М.Тэмүүжин, Алтанчимэг – Архангай аймаг
- Гуравдугаар байр-П.Бямбатогтох, Д.Эрдэнэгэрэл - Баянхонгор аймаг



## Гар бөмбөг

- Нэгдүгээр байр. “Эрдэнэт Ус” ДТС ОНӨХК - Орхон аймаг
- Хоёрдугаар байр-“Чандмань Баянхонгор” ХК – Баянхонгор аймаг
- Гуравдугаар байр- “Булган-Мээж” ХХК- Булган аймаг

Тэмцээн ийнхүү 4 өдөр үргэлжлэн явагдсан бөгөөд тэмцээний нийлбэр багийн дүнгээр Орхон аймгийн “Эрдэнэт Ус” ДТС ОНӨХК нэгдүгээр байр, Баянхонгор аймгийн “Чандмань Баянхонгор” хоёрдугаар байр, Булган аймгийн “Булган Мээж” ХХК гуравдугаар байр тус тус эзэлсэн байна.



**БУЛГАН АЙМАГ “БУЛГАН-МЭЭЖ” ХХК-НЫ БАГ ТАМИРЧИД**



**ОРХОН АЙМГИЙН “ЭРДЭНЭТ УС” ДТС ОНӨХК-НЫ БАГ ТАМИРЧИД**





**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН “ОНГИ УС СУВАГ” ОНӨХК-НЫ БАГ ТАМИРЧИД**



**ДУНДГОВЬ АЙМАГ “ДУНДГОВЬ УС” ОНӨХК-НЫ ХАМТ ОЛОН**



**БАЯНХОНГОР АЙМАГ “ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР” ХК-НЫ ХАМТ ОЛОН**





## АРХАНГАЙ АЙМГИЙН “УНДРАГА УС” ХХК-НЫ БАГ ТАМИРЧИД



## ХАНГАЙН БҮСИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТ ОЛОН





## ТӨВИЙН БҮСИЙН ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Төвийн бүсийн тэмцээнийг УБ хот Хувийн – ОСНАА-н Хөгжлийн Төвөөс 2014 оны 6-р сарын 6,7-ны өдлүүдэд Хил Хамгаалахын Ерөнхий Газрын Зааланд Гар бөмбөг, Теннис, Шатар, Биллиард, Урлагийн төрлүүдээр амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнд:

1. Барилга хот байгуулалтын яам
2. Барилгын хөгжлийн төв
3. “Төв Чандмань” ДЭХГ
4. “Дархан Ус Суваг” ХК
5. Зүүн Хараа “Цант Орхон” ХХК
6. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар
7. Х-ОСНАА-н Хөгжлийн Төвийн баг тамирчид оролцлоо.

2014 оны 6-р сарын 6-нд Сүнжин гранд рестораны урлагын зааланд багуудын мэндчилгээ, урлагын номерийн шалгаруулалт халуун дулаан орчинд дуутай, шүлэгтэй, жүжигтэй, бүжигтэй болж өндөрлөлөө.

УСУГ-ын баг тамирчид урлагт 1-рт шалгарч багтаа оноо нэмлээ.

Удаах байранд “Төв чандмань” ДЭХГ, “Дархан ус суваг” ХХК нар шалгарлаа.

2014 оны 6-р сарын 7-ны өдөр спортын төрлүүдийн тэмцээн эхэлсэн.

Нээлтэнд БХТөвийн дэд захирал Ч.Отгончулуун, БХТөвийн ОСНАА-н Хэлтсийн дарга Цэдэндамба, МНААҮХолбооны Гүйцэтгэх захирал Б.Пүрэвжав, УСУГ-ын дарга Үнэн, Х-ОСНАА-н Хөгжлийн төвийн удирдах зөвлөлийн дарга Б.Туул, Зөвлөх С.Сүхээ, Гүйцэтгэх захирал Ж.Дэлгэрмэнд, ОСНАА-н Хувийн хэвшлийн компаниудын захиралууд байлцлаа.

Тэмцээний төрлүүд маш өрсөлдөөнтэй явагдаж шилдгүүд тодорлоо.

Гар бөмбөгт: 1-р байрт УСУГ-ын Эрэгтэй баг тамирчид

1-р байрт УСУГ-ын Эмэгтэй баг тамирчид

2-р байрт “ Дархан Ус Суваг” ХК-ний Эрэгтэй баг тамирчид

2-р байрт “ Дархан Ус Суваг” ХК-ний Эмэгтэй баг тамирчид

3-р байрт Х-ОСНАА-н Хөгжлийн Төвийн Эрэгтэй баг тамирчид





3-р байрт Х-ОСНАА-н Хөгжлийн Төвийн Эмэгтэй баг тамирчид

Теннис: 1-р байрт УСУГ-ын Эрэгтэй тамирчин С. Өлзийбаатар

1-р байрт “Төв Чандмань” ДЭХГ Эмэгтэй тамирчин Пүрэвсүрэн

2-р байрт “Дархан ус суваг” ХК-ний Эрэгтэй тамирчин Алдаржав

2-р байрт УСУГ-ын Эмэгтэй тамирчин Жаргалсайхан

3-р байрт “Төв Чандмань” ДЭХГ Эрэгтэй тамирчин Г.Цогтсайхан

3-р байрт Зүүн Хараа “Цант Орхон”ХХК-ний Эмэгтэй тамирчин Ганзул

Шатар: 1-р байрт эрэгтэй “Дархан ус суваг”ХК Т.Хүрэлчулуун

1-р байрт эмэгтэй УСУГ –ын Алтанцэцэг

2-р байрт эрэгтэй УСУГ-ын Ш,Энх-Амгалан

2-р байрт эмэгтэй Төв Чандмань ДЭХГ Мөнхбат

3-р байрт эрэгтэй БХБЯам Л.Болд

3-р байрт эмэгтэй Дархан ус суваг”ХК-ний Содгэрэл

Биллиард: 1-р байрт БХТөвийн дэд захирал Ч.Отгончулуун

2-р байрт “Дархан ус суваг” ХК Захирал Р.Эрдэнэбаяр

3-р байрт “Төв Чандмань” ДЭХГазрын Дарга Г.Цогтсайхан

Багаараа 1-р байрт УСУГ-ын баг Шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байрт “Дархан ус суваг” ХК баг Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байрт “Төв Чандмань” ДЭХГ баг Өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.

2015 оны Төвийн бүсийн тэмцээнийг “Дархан ус суваг” ХК зохион байгууллахаа албан ёсоор мэдэгдлээ.

Тэмцээний хаалтын ажиллагаа Сүнжин гранд ресторанд болж МНААҮХолбооны Тэргүүн УИХ-ын гишүүн Ж.Батсуурь ирж тамирчдад баяр хүргэлээ.







## **БАРУУН БҮСИЙН НААУ-НИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН УУЛЗАЛТ ТЭМЦЭЭН БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ**

Монгол улсад НААУ-ний салбар үүсч хөгжсөний 83жилийн ойн арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий аймагт Баруун бүсийн НАА-н байгууллагуудын уулзалт тэмцээнийг 2014оны 6-р сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсан ба уг тэмцээнд Завхан аймгийн “Амь-Ус”Трейд ХХКомпаний-13, Говь-Алтай аймгийн “Ундрага-Алтай” ОНӨААТҮГазрын-12, Увс аймгийн “Чандмань-Увс”ХХКомпаний-14, Ховд аймгийн “Шим-Ус”ОНӨААТҮГазрын -23, Баян-Өлгий аймгийн “СУАТ”ХХКомпаний -13 нийтдээ 75 тамирчид ирж оролцоод 5 төрлийн тэмцээнээр

уралдаж багийн нийт оноогоор Ховд аймгийн “Шим-Ус”ОНӨААТҮГазар 1 байр эзэлж шилжин явах цом өргөмжлөл, мөнгөн шагналаар, 2 байрыг Завхан аймгийн “Амь-Ус”Трейд ХХкомпани эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар, 3 байрыг Говь-Алтай аймгийн “Ундрага-Алтай” ОНӨААТҮГазар эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар тус тус шагнагдсан.Энэхүү үйл ажиллагааг Баян-Өлгий аймгийн “СУАТ”ХХкомпаний хамт олон зохион байгуулсан. Энэ тэмцээнд оролцсон байгууллагууд маш өндөр сэтгэлтэйгээр буцаж дараа жил Ховд аймагт уулзах ерөөл тавин мордоцгоолоо.



## СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БАЙНА

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 7.141.1-д “Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр”-ийг 100 хүртэл суманд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Энэ хүрээнд Монгол Улсын энэ оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийг Архангай аймгийн Тариат, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Булган аймгийн Хутга-Өндөр, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Өвөрхангай аймгийн Богд, Дорнод аймгийн Баян-Уул, Дундговь аймгийн Өлзийт, Завхан аймгийн Тосонцэнгэл, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Төв аймгийн Лүн, Увс аймгийн Тэс, Ховд аймгийн Зэрэг, Хэнтий аймгийн Биндэр, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумдад хэрэгжүүлэх ажлыг эхлүүлжээ.

БХБЯ нийт 16 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг тухайн аймаг орон нутгийн холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, хуулийн дагуу тендерийг зарласан байна. Тус төслийн хүрээнд 11 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж, 20 гүний худаг, 100-250 мЗ/хоног багтаамжтай 15

усан сан, цэвэр усны гол болон салбар 56.3 км шугам, бохир усны гол болон салбар 48,8 км шугам, дулааны гол болон салбар 40.3 км шугам, гадна цахилгааны 50,4 км шугам, 100-250 мЗ/хоног хүчин чадалтай 16 цэвэрлэх байгууламж, 3-5 мВт-ын дулааны станц барьж байгуулахаар төлөвлөжээ.

Энэхүү төсөл бүрэн хэрэгжсэнээр төсөлд хамрагдсан сумдын 65.1 мянган хүн эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хангагдаж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ариутгах татуургын шугамд холбогдохын зэрэгцээ төвлөрсөн дулаан хангамжтай, тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцөл бүрдэх юм. Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх явцыг эрчимжүүлэх зорилгоор:

-Төслийн зураг төслийг боловсруулах талаар 2014 оны 8/835-8/849 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн

-БХБ-ын сайдын 2014 оны 01 тоот албан даалгаврыг хүргүүлсэн

-Сумдад баригдах 100, 150, 250 мЗ/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төслийг бэлэн болгоод байна.

-Яамны газар, хэлтсийн дарга нарыг сумдад хувиарлан хөрөнгө оруулалтын ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байна.

Б.Тогтох



## 1000 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ АЖЛЫН ЯВЦ ИЙМ БАЙНА

УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймаг бүрд 1000 айлын орон сууц” төсөл хэрэгжүүлэхээр болсон билээ. УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 8 дүүрэгт 110171 айлын, хөдөө орон нутагт 22240 айлын орон сууц барихаар төлөвлөгдсөн. Дээрх хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд улсын хэмжээнд 2010 онд 9899 айлын, 2011 онд 11349 айлын, 2012 онд 11453 айлын, 2013 онд 20300 айлын орон сууц /үүнээс орон нутагт 5360 айлын орон сууц/ баригдаж ашиглалтад орсон байна.



Ипотекийн хөтөлбөр хэрэгжээд жил болж байна. Энэ хугацаанд банкууд нийт 37438 иргэнд нэг их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгож, 520.5 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлжээ. Монголбанк орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр зээл олгоход зориулж 1.5 их наяд төгрөгийг арилжааны банкуудад жилийн өмнө байршуулсан. Үүний 51.3 хувь нь 2013 оны эцэст шинээр орон сууцны ипотекийн зээл болж гарсан байна.

Аймгийн төвүүдэд баригдах орон сууцны хотхон, хорооллуудын төлөвлөлтийн ажлын явц:

- “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Аймгийн төвийг хот болгон хөгжүүлэх”, “Аймаг бүрд 1000 айлын орон сууц барих” зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу аймгийн төвүүдэд баригдах цогцолбор орон сууцны хотхон, хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

- Өнгөрсөн оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн 143.5 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймгийн төв Арвайхээр, Булган аймгийн төв Булган хотуудад баригдах орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

- Энэ онд улсын төсвийн хөрөнгөөр Говьсүмбэр аймгийн Чойр, Ховд аймгийн Ховд, Өмнөговь аймгийн Даланзадгад, Баян-Өлгий аймгийн Өлгий хотуудын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж байна. Энэхүү ажлын хүрээнд

тухайн аймгийн төвд баригдах 1000 айлын орон сууцны хотхон, хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хамтатган хийгдэж байна. Мөн энэ онд улсын төсвийн 364.6 сая төгрөгийн санхүүжилтээр Дорнод аймгийн төв Чойбалсан, Завхан аймгийн төв Улиастай, Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотуудад баригдах орон сууцны хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна.

Аймаг бүрд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын явцын талаар:

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “21 аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам, сүлжээ, 2013-2015 он, 62.0 тэрбум төгрөг”, мөн 2014 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан “Дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 2014-2015 он, 5.6 тэр бум төгрөг”, “Инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум, 2014-2015 он, 4.5 тэр бум төгрөг” төсөл, арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдэх 27 ажлаас 13 ажлыг эхлүүлсэн, 2014 онд 14 ажлыг эхлүүлэхээр тендерийг зарлаад байна.

Аймаг бүрд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын явц дараах байдалтай байна. Үүнд:

1. Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Орхон, Сүхбаатар, Төв аймгуудын төвд баригдах 1000 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн.

2. Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгуудын инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын тендер шалгаруулалт явагдаж байна. Завхан аймгийн “ХХ1 зуун” орон сууцны хорооллын зураг төсөв хийгдсэн боловч 2014 оны төсөвт 00 дүнтэйгээр тусгагдсан. Хөрөнгийн эх үүсвэрийг 2014 онд шийдвэрлэх шаардлагатай.

3. Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Дорнод, Увс, Ховд аймгуудад 1000 айлын орон сууцны дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгийг шийдвэрлэх шаардлагатай байгаа болно

4. Үүнээс Говьсүмбэр, Дундговь аймгуудад хийгдэх ажлын зураг төсөв бэлэн боловч угсралтын хөрөнгө шийдээгүйгээс ажил эхлээгүй байна. Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд аймгуудад хийгдэх 1000 айлын гадна ИШС-ний зураг төслийг боловсруулах ажлын тендерийг зарлаад байна.

5. Аймгийн төвүүдийн цэвэрлэх байгууламжийн хувьд:

- Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Орхон, Дорнод, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Ховд аймгуудын цэвэрлэх байгууламжийн асуудал шийдвэрлэгдсэн.

- Баян-өлгий, Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгуудын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Б.Баяр



## V ЦАХИЛГААН СТАНЦ 2017 ОНД АШИГЛАЛТАД ОРНО

450 МВт-ын хүчин чадал бүхий "V цахилгаан станц"-ын Концессын гэрээг үзэглэлээ. Нийслэлийн өсөн нэмэгдэж буй дулаан, цахилгааны хэрэгцээг хангах "мега"төсөл ийн олон жилийн дараа хэрэгжихээр боллоо. Францын "GDF Suez", Японы "Sojitz", Өмнөд Солонгосын "Posco Energy" Монголын "Newcom" группын хамтарсан "International Power" консорциум "V цахилгаан станц"-ын концесс олгох сонгон шалгаруулалтад тэнцэж, эрх авчээ.

Концесс эзэмшигч "International Power" консорциум нэг жилийн хугацаанд хөрөнгө оруулалтаа шийдвэрлэн, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ, Газар ашиглах гэрээ, Ус ашиглах гэрээг Монгол Улсын төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай тус тус хийснээр концессын гэрээ хүчин төгөлдөр болж, үүний дараа станцын барилга угсралтын ажил эхэлнэ.

Гэрээг төр-хувийн хэвшлийн түншлэл буюу концессын БАРИХ - АШИГЛАХ - ШИЛЖҮҮЛЭХ нөхцөлөөр байгуулж буй бөгөөд концесс эзэмшигч нь "V цахилгаан станц"-ыг гурван жилийн хугацаанд барьж, удаах 25 жилд нь ашигласны дараа Монгол Улсын төрд үнэ төлбөргүй шилжүүлэх юм.

Станцын хүчин чадлын хувьд цахилгаан 450 МВт, дулаан 587 МВт. Байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөө хамгийн бага CFB /circulating fluidized bed/ технологи ашиглах юм. Ингэснээр гэр хорооллын хүн амыг нэгдсэн халаалт бүхий орон сууцны хороололд шилжүүлэх суурьшуулах боломж бүрдэх аж.

Станцын усны хэрэглээ нь III цахилгаан станцтай харьцуулахад зургаа дахин бага байх гэнэ. Төслийг хэрэгжүүлэхэд нийтдээ 650 ажлын байр шинээр бий болох урьдчилсан тооцоо гарчээ. Станц ашиглалтад орсноор 300 орчим монгол ажилчин тогтмол ажилтай байх юм.

Төслийн нийт өртөг нь 1.2 тэрбум ам.доллар бөгөөд тус зардлыг "International Power" консорциум гаргах юм. Одоогийн байдлаар албан бус, харилцан ойлголцлын хүрээнд 950 сая ам.долларыг босгоод байгаа. V цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажил ирэх оны долдугаар сарын 1-нээс эхэлж, 2017 онд ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа юм.

V цахилгаан станцыг III, IV цахилгаан станцуудтай харьцуулахад шинэ технологи нэвтэрч байгаа учраас ашиглаж байгаа нүүрсний зарцуулалт нь харьцангуй бага байх аж.

Б.Тогтох



## НОГООН ХӨГЖИЛ ӨӨД



Монгол Улс Ногоон хөгжлийн үзэл баримтлалтай боллоо. Энэ оны зургадугаар сарын 13-нд УИХ-ын чуулганы хуралдаанаар “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын төслийг баталж, Ногоон хөгжлийн бодлого хоёр үе шаттай хэрэгжихээр боллоо. Эхний үе шат буюу Ногоон хөгжлийн үндсийг тавих үе 2014-2020 он бол Ногоон хөгжилд шилжих хоёр дахь үе 2021-2030 он.

Ногоон хөгжлийн бодлого нь цаашдаа Монголын хөгжлийн тулгуур бодлого болох аж. Эдийн засгийн өсөлт нь зайлшгүй байдлаар байгаль орчны доройтлыг дагуулах учиртай гэж өнөөгийн хүн төрөлхтөн үзэхээ нэгэнт больсон. Технологийн дэвшлийн түвшин, ногоон хөгжлийн үзэл баримтлал нь эдийн засгийн өсөлтийг хангахдаа байгальд ээлтэй, хариуцлагатай аргаар нөөцийг ашиглаж хүрээлэн байгаа орчноо хамгаалах юм. Ингэснээр ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэн экологийн тэнцвэртэй, аюулгүй орчинд амьдрах боломжийг бодит үйл хэрэг болгон хувиргах аж.

Дэлхий нийтэд тулгараад буй уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, хүн амын хурдацтай өсөлт, хэрэглээ, үйлчилгээний хэт өсөлт, байгалийн нөөцийн хомсдол нь дэлхийн “тусгаар тогтнол”-д эрсдэл учруулах болсон. Өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний экологийн үл мөрийг тооцоолж үзэхэд энэ хандлагаар цааш хөгжвөл 2030 он гэхэд дэлхийн нөөц боломжоос хоёр дахин давахаар байна. Иймд дэлхийн улс орон, иргэн бүр өөрийн ахуй амьдрал, үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв маягийг эрс өөрчилж байгальд ээлтэй, “ногоон” хэв загварт шилжих шаардлагатай болж байна.

Жил бүр дэлхийн хүн ам 1.3 тэрбум тонн буюу нийт үйлдвэрлэж буй хүнснийхээ гуравны нэгийг хаяж байна. Барууны өндөр хөгжилтэй орнуудад жилд 220 сая тонн хоол хаядаг аж. Энэхүү хаягдал нь Африкийн Сахарын бүсийн орнуудын үйлдвэрлэж байгаа хүнсний хэмжээтэй /230 сая тонн/ тэнцэж байгаа юм. Хоолны хаягдлыг булж устгадгаас метан хий ялгаруулж, улмаар хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг аж. Энэ нь дэлхий нийтийн өмнө тулгамдаж асуудлын нэг болоод байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд Б.Тулга “Улс орон бүр өөрсдийн хөгжлийн чиг хандлагаа хэмнэлттэй ашиглалт, үр дүнтэй үйлдвэрлэлд хандуулж шинэчилж байна. НҮБ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтын хугацаа ирэх онд дуусч байгаа. Залгаад Тогтвортой хөгжлийн бодлогыг тодорхойлж буй энэ үед манайх Ногоон хөгжлийн бодлогоо баталлаа. Монгол Улс ногоон хөгжлийн замаар хөгжих бололцоог хууль эрх зүйн орчин олгож байна. Эхлээд хөгжье, дараа нь цэвэрлэе гэсэн уламжлалт хандлага хэдийнэ хоцрогдсон. Харин хөгжье, хөгжихдөө хамгийн зөв замаар явъя гэсэн шинэ хандлага бий болсон” гэв.

Манай улсын хувьд газар нутгийн дийлэнх хэсэг нь харьцангуй байгалийн унаган төрхөө хадгалсан. Түүнчлэн байгалийн арвин нөөц баялаг, газар зүйн байршил, байгаль орчиндоо зохицон амьдрах чадвар, соёл, уламжлалын том давуу талтай. Үүнийгээ ашиглах замаар ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэх боломжтойг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын зөвлөх, доктор Т.Чулуун онцолж байсан. Нөгөө талаар ядуурлын түвшин, орлогын тэгш бус хуваарилалт, байгалийн нөөцөд



тулгуурласан эдийн засгийн бүтэц, эрчим хүч болон бусад нөөц баялгийн үр ашиггүй, үрэлгэн хэрэглээ, техник технологийн хоцрогдол, уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий эмзэг байдал зэрэг нь бидэнд томоохон сорилт, бэрхшээл болж буй.

Ногоон хөгжлийн бодлого нь, -Нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зохистой ашиглах

- Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн салбарын бодлого, төлөвлөлтийг хийх,
- Цэвэр дэвшилтэт технологийг дэмжих,
- Ногоо эдийн засгийн өсөлтийг бий болгоход иргэдийн оролцоог хангах,
- Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх,
- Ил тод, хариуцлагатай, хяналттай байх гэсэн дээрх зарчмыг баримтлах аж. Харин Монгол Улс ногоон хөгжлийг хангахад зургаан стратегийн зорилтыг хэрэгжүүлэх юм.

1. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ. Энэ хүрээнд эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгох замаар эрчим хүчний үр ашгийг 2030 он гэхэд 20 хувь нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах аж. Мөн барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулахаар үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлжээ.
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. Энэ хүрээнд цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2020 онд нийт нутаг дэвсгэрийн 25 хувь, 2030 онд 30 –аас доошгүй хувьд хүргэж, хамгаалалтын тогтвортой санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх аж. Мөн ойжуулах ажлыг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайг 2030 онд нийт газар нутгийн есөн хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингэлтийг нэмэгдүүлэх ажлыг хийх юм.
3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Энэхүү зорилтод хүрэхийн тулд ДНБ-ий хоёроос доошгүй хувийг жил бүр ногоон хөгжилд зарцуулж, нэгж бүтээгдэхүүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах,

бүтээмжийг дээшүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх аж. Мөн Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ авахад зарцуулахаар үйл ажиллагааны чиглэлд тусгасан байна.

4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ. Энэхүү зорилт нь Олон улсын жишигт нийцсэн чанартай боловсролыг эх орондоо эзэмшиж, өрсөлдөх чадвартай, мэргэшсэн чадварлаг ажиллах хүчинтэй болж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхээр замаар биелэх юм.
5. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно. Уг зорилтод хүрэх үүднээс Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд ДНБ-ий хоёр хувь, 2030 онд гурван хувьд хүргэх аж.
6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ. Энэхүү зорилтын хүрээнд хэд хэдэн ажлыг хийхээр төлөвлөжээ. Тухайлбал, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20, 2030 онд 40 хувь тус тус бууруулах юм байна. Үүнээс гадна хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” жижиг хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх юм.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Хишигжаргал “Ногоон хөгжлийн баримт бичиг нь ганцхан Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хэрэгжүүлэх асуудал биш салбар дундын зохицуулалтыг хангасан урт хугацааны бодлогын баримт бичиг. Байгалийн нөөцөд тулгуурласан эдийн засагтай манай улс цаашид байгалийн нөөцөө урт хугацаанд тогтвортой ашиглаж, үр өгөөжийг нь ард иргэддээ тэгш хүртээхийн тулд зайлшгүй байгалийн нөөцөө үр ашигтай хэмнэлттэй ашиглах замаар байгалийн нөөцдөө эргүүлээд хөрөнгө оруулах гэсэн бодлогын үзэл баримтлал бүх байгалийн нөөцөд тулгуурласан салбаруудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ёстой гол зарчим” гэв.

Б.Баяртогтох



# НОГООН ХӨГЖИЛ-ХЭМНЭЛТТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ



## НОГООН ХӨГЖИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Энэхүү өгүүллийн зорилго бол ногоон хөгжил гэж юу болохыг тайлбарлаж танилцуулахад оршино. Ногоон хөгжил бол Монголчуудад тун ойр энгийн ойлголт юм. Дулаан, цахилгаан, ус, хоол, хувцсаа хэмнэх нь өрх гэрийн эдийн засагт ч ашигтай. Манай нүүдлийн соёл иргэншил ч материаллаг бус, хэмнэлттэй, дахин ашигладаг, хог хаягдалгүй амьдралын хэв маягт суурилсан байдаг. Иймээс Монгол Улс нүүдлийн уламжлалт соёл иргэншил дээрээ суурилж, үр ашиг өндөртэй орчин үеийн технологиор үйлдвэрлэлээ

дэмжээд, ногоон соёл иргэншил рүү шилжих бүрэн боломжтой.

“Монголын өнөө болон хойч үеийнхний сайн сайхан амьдрах баталгаа – амьдралыг тэтгэх тогтолцоог найдвартай хамгаалж, тогтвортой хөгжихийг ногоон хөгжил гэнэ.”

Хөгжил бол хүний сайн сайхан, аз жаргалтай амьдралын төлөө л байх ёстой. Харин хүний сайн сайхан, аз жаргалтай амьдрахын эх сурвалж бол байгаль орчин билээ. Цэвэр орчин (ус, агаар, хөрс) болон эрүүл экосистем бол бидний амьдралыг тэтгэх тогтолцоо юм. Хоол хүнс, ноос ноолуур, мод, эм зэрэг нь экосистемийн бүтээгдэхүүн байдаг. Амарч алжаалаа тайлахдаа ч бид экосистемийнхээ үйлчилгээг хүртдэг. Ус, агаар, хөрсийг цэвэршүүлэх үйлчилгээг мөн л экосистем үзүүлдэг. Иймээс экосистемийн бүтээгдэхүүн болон үйлчилгээ нь хүний амьдралыг тэтгэх амин дэм юм.

Эдийн засгаа хүний хөгжлийн төлөө өсгөж, хүний үйл ажиллагаа нь байгаль орчноо доройтуулахгүй, харин улам сэргээн сайжруулах үйлдлийг ногоон хөгжил гэж хураангуйлж болно. Ялангуяа, ирээдүй хойч үе, үр хүүхдийнхээ сайн сайхны төлөө бид байгаль орчноо хамгаалах үүргийг хүлээж байгаа билээ. Энэ утгаараа ногоон хөгжил бол үнэндээ тогтвортой хөгжил гэсэн үг юм. Өнөө үеийнхэн хэрэгцээгээ хангахдаа, ирээдүй үедээ хэрэгцээгээ хангах боломжийг өвлөн үлдээх зорилготой үе үеийн тэгш байдал нь тогтвортой хөгжлийн үндэс билээ. Иймээс үр хүүхэд болон хойч үеэ ирээдүйд сайн сайхан амьдраасай хэмээх хүсэл эрмэлзэлд ногоон буюу тогтвортой хөгжлийн үзэл санаа бүрэн оршдог. Дашрамд дурьдахад, ногоон хөгжлийн үзэл санааг нийтээрээ ойлгон талархан хүлээж аваад байна. Одоогоор Архангай, Өвөрхангай, Ховд, Булган болон Хэнтийн аймгууд ногоон хөгжлийнхөө бодлогын баримт бичгийн эхийг боловсруулаад байгаа билээ.

## ГАДААД НӨХЦӨЛ

2012 оны 6 дугаар сард буюу 20 жилийн дараа Бразил улсын Рио де Жанейро хотноо дахин зохион байгуулсан НҮБ-ын тогтвортой хөгжлийн хурлаас өнөө болон хойч үеийнхэнд тогтвортой ирээдүйг баталгаажуулахын тулд эдийн засаг, нийгэм болон байгаль орчны харилцан уялдаа, нөлөөллийг цогцоор нь авч үзэх шаардлагатай байгааг дахин онцолсон билээ. Дэлхийн улс орон бүр өөрийн үндэсний онцлогт тохирсон хөгжлийн алсын хараа, арга загвар, хандлагатай хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ёстойг онцолсон юм. Гэвч ногоон эдийн засгийг тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах улмаар арилгах хэрэгслийн нэг болгохыг зөвлөсөн (“Бидний хүсч буй ирээдүй”, НҮБ-ын тогтвортой хөгжлийн хурлын үндсэн баримт бичиг, 2012, “The Future We Want”). Эдийн



засаг, нийгэм, байгаль орчны гурван хүчин зүйлийг нэгтгэн цогц байдлаар хэрэгжүүлэх чадавхитай, тогтвортой хөгжилд хөтлөх засаглалыг бүх салбар, түвшинд бэхжүүлэх шаардлагатайг мөн тус баримт бичигт дурьджээ.

Хүний үйл ажиллагаа дэлхийн тогтолцоонд нөлөөлөх болсоноор хүн төрөлхтөн Антропоцен хэмээх геологийн шинэ эринд орсоныг нийтээр хүлээн зөвшөөрөх болов. Ялангуяа монгол тооллын нэг эрин болох сүүлийн 60 жилд хүний үйл ажиллагаа эрс хурдатгалтайгаар өөрчлөгдлөө. Уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйлийн устаж буй хурдац, азотын эргэлт гэсэн байгаль орчны үзүүлэлтүүдээр дэлхийн тогтолцоо аюулгүй оршин тогтнох хил хязгаараас хэдийнээ даван гарсан болохыг эрдэмтэд тогтоогоод байна. Агаар мандал дахь хүлэмжийн хий ихэссэнээс улбаатай дэлхийн дулаарлын эрч саарахгүй байгаа тул уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал шинээр урган гарч ирч буй сорилуудын нэг болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрлөө.

Дэлхий дээрхи бүх үйл явц энэ эрчээрээ явбал 2030 онд бидэнд 2 дэлхий шаардагдана гэсэн тооцоо ч гарчээ. Энэ бүхэн ганцхан цэнхэр гариг дээр аж төрж буй хүн төрөлхтний өмнө “орших, эс оршихийн” хариуцлагаа ухамсарлан, хамтын хүчээр тулгамдаж буй эрсдлээ даван туулахаас өөр гарцгүй байгааг ухаарууллаа. Монгол Улсын Засгийн газар өөрийн үүрэг хариуцлагаа үүрэхийн зэрэгцээ олон улсын хамтын ажиллагааг ногоон хөгжлийн хөдөлгөгч хүч болгохоор чармайн ажиллаж байна.

Үүний дагуу НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр (UNEP), НҮБ-ийн Сургалт, судалгааны хүрээлэн (UNITAR), НҮБ-ийн Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO) болон Олон Улсын хөдөлмөрийн байгууллага (ILO) хамтран “Ногоон эдийн засгийн төлөөхи түншлэл” (Partnership for Action on Green Economy буюу PAGE) хөтөлбөрийг санаачилсан болно. Тус хөтөлбөр нь 2020 он гэхэд Дэлхийн 30 улс орныг загвар ногоон эдийн засагтай болоход тусалж хамтран ажиллах зорилготой юм. Монгол Улс тус хөтөлбөрт хамрагдах анхны орноор сонгогдож, хамтран ажиллаж эхлээд байна. Тэгш хүртээмжтэй ногоон эдийн засаг хүн-байгальд ээлтэй төдийгүй эдийн засгийн өсөлтийг хурдасгах болохтойг харуулах нь уг хөтөлбөрийн нэгэн зорилго юм.

Дэлхийн хэмжээнд тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн талаар маш олон арга хэмжээ зохион байгуулагдаж, нэг ёсны байгаль орчныхоо төлөө эвлэлдэн нэгдэх шинэ давалгаа үүсчээ. Манай зүүн хойд азийн бүс нутаг тус давалгааны торгон үзүүрт манлайлж явна. Тухайлбал, Япон улс “Бага нүүрстөрөгч бүхий хөгжлийн түншлэл”, БНСУ-д “Ногоон өсөлт”, Хятад “эко соёл иргэншил”, Казакстанд “Ногоон гүүр” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байгааг энэ дашрамд дурьдах нь зүйтэй болов уу. Япон Улсын Засгийн Газар “Бага нүүрстөрөгч бүхий хөгжлийн түншлэлийн” анхны гэрээгээ Монгол Улстай энэ оны эхээр байгуулсан билээ.

Мянганы Хөгжлийн Зорилгууд дуусах 2015 оноос хойш Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг боловсруулж хэрэгжүүлэхээр НҮБ-ын тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаас шийдвэрлэсэн юм. Дэлхий даяар энэ чиглэлээр өргөн хэлэлцүүлэг өрнөж, ядуурлыг бүх үзүүлэлтээр нь арилгах, тэгш байдлыг хангах зэрэг асуудлууд анхаарлын төвд байна. Эдгээр дэлхийн зорилтууд дээр монгол хүний сайн сайхан амьдрахад шаардлагатай зорилтуудыг нэмж оруулан, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэх шаардлагатай юм. 2030 онд хүрэх Ногоон хөгжлийн үзэл баримтлал нь Монгол Улсын онцлогт тохирсон тогтвортой хөгжлийн байж болох зорилтуудад суурилсан болно.

### ДОТООД НӨХЦӨЛ

2012 оны шинэчлэлийн Засгийн газар ногоон хөгжлийн суурийг тавьж, “Ногоон соёл иргэншил” үзэл баримтлал, хөтөлбөр боловсруулан, загваруудыг бий болгох зорилтыг мөрийн хөтөлбөртөө оруулсан юм. 2030 онд хүртэлхи ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөрөө батлан хэрэгжүүлж эхэлснээр Монгол Улс хөгжлийн хандлагаа эрс шинэчилж, тогтвортой хөгжлийн замаар замнах болно.

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засаг бүхий орон болох шилжилтийг өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хийж, ардчилал, эрх чөлөө, чөлөөт зах зээлийн эдийн засагтай болох талаар амжилтад хүрсэн. Монгол Улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийд тэргүүлж эхлэн, уламжлалт соёл иргэншлээ хадгалсаар мэдээллийн технологийн эрин үед шилжин орлоо. Энэ бүхэн Монгол Улсад сэргэн хөгжих алтан боломжийг нээж байгаа билээ.

Эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд тэргүүлж эхэлсэн боловч олон хэлбэршилгүй буюу дан ганц уул уурхайн орлогоор өссөн тул эдийн засаг ч тогтворгүй (2012 онд дэлхийн өрсөлдөх чадварын индексээр 142 орноос 96, 2013 онд 144 орноос 93-р байранд тус тус яваа), ядуурлын түвшин өндөр хэвээр (Мянганы хөгжлийн зорилтуудаас 2015-д ядуурлыг 2 дахин бууруулах гэсэн зорилт хэрэгжих магадлал хамгийн бага байгаа), хүний хөгжил, ялангуяа дундаж наслалт, боловсролоор дорвитой ахиц гарахгүй хэвээр (2011 онд хүний хөгжлийн индексээр 187 орноос 110-д, 2012 онд хүний хөгжлийн индексээр 187 орноос 108-д тус тус яваа) байгаа төдийгүй Улаанбаатар хот агаарын бохирдлоор дэлхийд тэргүүлж, усны бохирдол, газрын доройтол хэтэрсэн тул байгаль орчин нь ч тогтворгүй болжээ. Үүнээс нэгтгэн дүгнэвэл, Монгол Улс өнгөрсөн 20 гаруй жилд тогтвортой хөгжлийн үзүүлэлтээр ухарсан байна.

Засгийн газар Монгол улсаа шинэчлэн хөгжүүлэх ногоон хөгжлийн хэтийн зорилгоо дэвшүүлж, бодлогын баримт бичгээ боловсруулж хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн бариад байгаа юм.



### ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Уур амьсгалд зохицсон хөгжил, ногоон эдийн засаг, тогтвортой хөгжилд хүрэх засаглал, тэгш байдал болон ядуурал зэрэг НҮБ-ын тогтвортой хөгжлийн хурлын үндсэн баримт бичиг “Бидний хүсч буй ирээдүй”-д заасан салбар дундын гол чиглэлүүдээр Монгол Улсын ногоон хөгжлийн стратегийг дэвшүүлж байгаа болно. Харин Монголынхоо өвөрмөц онцлогийг тусгах үүднээс “соёл ба өв” гэсэн чиглэлийг ногоон хөгжлийн стратегид нэмж орууллаа.

Монгол орныг өөр хоорондоо харилцан үйлчлэлцэх байгаль орчин, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын гэсэн таван бүрэлдхүүн хэсэгтэй цогц тогтолцоо гэж авч үзэв. Монголчууд системийн сэтгэлгээтэй ард түмэн билээ. Монгол ардын эмнэлэгт бие махбодийг нөхөр ба дайсан, эцэг ба хүү гэсэн харилцан үйлчлэл бүхий таван цул эрхтэнтэй цогц тогтолцоо хэмээн үздэг. Аль нэг эрхтэн өвдвөл дайсан эрхтэндээ халгаатай тул эрүүл байхын тулд эрхтэн бүрийг эрүүл байлгах шаардлагатай. Энэ зүйрлэлээр бол Монгол улс байгаль орчин, нийгэм, эдийн засаг, улс төр болон соёлоо аль алийг эрүүл байлгаж, дархлаагаа хадгалж гэмээнэ тогтвортой оршин тогтнох юм.

### УУР АМЬСГАЛД ЗОХИЦСОН ХӨГЖИЛ

Манай орны хувьд уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөгжлийн асуудал амин чухал болохыг харуулсан зарим нэг судалгааны үр дүн гараад байна. Япон-Монголын эрдэмтэд цэвдэг хайлалтын судалгааг Туул галын сав газарт хийжээ. Хавар цэвдэг гэсэхдээ ургамлын ургаж эхлэхэд хэрэгцээт чийгийг өгдөг байж. Гэтэл Налайх орчимд хийсэн цэвдгийн судалгааны дүн дэлхийн дулаарлын үр дагавар болох цэвдэг хайлалтын улмаас энэ зүй тогтол алга болж байгаа ноцтой үр дүн гарчээ. Болзошгүй сөрөг үр дагавруудыг дурьдвал, ургамлын ургаж эхлэх хугацаа оройтож хавар хуурайшин, экосистем доройтох улмаар цөлжих, бэлчээрийн мал аж ахуй улам эмзэг болох, цэвдгийн гэсэлтээр тэжээгдэх голын урсац багасах зэрэг болно. Эдгээр судалгааны дүн уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар ямар их ноцтой болохыг харуулж байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицол, ногоон хөгжлийн бодлогыг хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахтай харилцан уялдуулбал Монголд болон дэлхийд аль алинд нь үр ашигтай болох тул дасан зохицох технологи нэврүүлэхэд олон улсын санхүүжилтыг олох магадлал ихсэж, хамтын ажиллагаа илүү үр дүнтэй болох нь ойлгомжтой. Тухайлбал, сэргээгдэх эрчим хүчээр Монголын нөхцөлд ажиллах хөргөгчийг шинээр зохион бүтээж, малынхаа тоог бэлчээрийнхээ даацад тааруулан, ялангуяа зудын нөхцөлд, цөөлөөд махаа хадгалахад тус “шинэ” хөргөгчийг ашигласанаар зудад алдах малын тоо цөөрөх төдийгүй бэлчээрийн экосистем ч сайжрах, эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд аль алинд нь ээлтэй ногоон хөгжлийн төслийг БОНХЯ нь Япон улстай хамтран хэрэгжүүлэхээр оруулаад байна.

### НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛЭЭС НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ РҮҮ

Үндэсний байгаль, соёлын өв газруудыг бий болгож, ногоон соёл иргэншлийн хөгжлийн бүс болгон хөгжүүлэх саналыг ногоон хөгжлийн үзэл баримтлалд дэвшүүлж байгаа юм. Тухайлбал, Алтайн нуруу, Их нууруудын хотгорыг нүүдлийн соёл иргэншлийн өлгий-үндэсний байгаль-соёлын хосолмол өв газар, Бурхан Халдун болон Онон-Балжийн сав газрыг тулгар төрийн үндэсний өв газар, цагаан зээр бүхий хялганат хээрийн байгалын үндэсний өв, их говийн байгалын үндэсний өв, Хөвсгөл нуурын орчмын нутгийг цаатан соёл иргэншлийн өв газар болгон “тамгалж”, ногоон технологиор баяжуулан хөгжүүлсэнээр Монгол орон ногоон байгаль-соёл-түүхийн өвөрмөц брэнд орон болно.

Төв азийн нүүдлийн соёл иргэншлийн өв монголд л үлджээ. Үүнийгээ хөгжлийн давуу тал болгох бололцоо байна. Тухайлбал, байгаль, соёлын аялал жуулчлал, органик мах сүү зэрэг хүнс, ноос ноолуур, оёдол сүлжмэлийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлээд ногоон хөгжил рүү шат ахих бүрэн боломж буй.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ ЗАСАГЛАЛ

Ногоон хөгжлийн энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд бүх шатны төр, засгийн байгууллагын салбар дундын уялдаа, зохицуулалтыг сайжруулан, ил тод, хариуцлагатай, хяналттай “засаглал”-ыг төлөвшүүлнэ.

Иргэдийн оролцоог өрнүүлэх, тогтвортой хөгжил, байгаль орчны албан бус боловсролыг дээшлүүлэх, байгаль, нийгмийн хариуцлагатай компанийг хөгжүүлэх, эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд аль алинд нь ээлтэй шийдлийг эн тэргүүнд хэрэгжүүлэх, нийгмийн уламжлалт өв, нутаг усныхны албан бус сүлжээг бэхжүүлэх зэрэг тогтвортой хөгжилд хүрэх засаглалыг бий болгох нь шинэчлэлийн засгийн газрын зорилго юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Том төрөөс ухаалаг төр рүү” сэдвээр хийсэн үндэсний зөвлөлдөх уулзалт энэ зорилгыг улам тод томруун болголоо. Монгол Улсын хөгжлийн хэмжиж болохуйц, хүрч болохуйц, ойлгомжтой, оновчтой зорилтууд дэвшүүлж, хэрэгжилт болон хяналтын тухай хууль гаргах санаачлагыг Ерөнхийлөгч дэвшүүлэв.

Монгол Улсын Засгийн Газрын Улсын Их Хуралд өргөн бариад буй ногоон хөгжлийн үзэл баримтлал нь дээрхи 5 чиглэлээр 8 зорилго, 40 хэмжиж болохуйц, хүрч болохуйц, ойлгомжтой, оновчтой зорилтуудтай юм. Эдгээр салбар дундын зорилтуудыг хэрэгжүүлэхэд, Монгол Улсын тогтвортой буюу ногоон хөгжлийг манлайлах ухаалаг “нэг” төр хэрэгтэй байгаа юм.

Доктор Т. ЧУЛУУН  
/Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын Зөвлөх/



Empowered lives.  
Resilient nations.

## МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХ, ОРОН НУТГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ:

### ХӨДӨӨГИЙН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖ ТӨСӨЛ- МОН/13/302

#### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Үндэсний Мянганы хөгжлийн зорилтуудын Зорилго 7-ын “Байгаль орчны тогтвортой байдлыг хангах” Зорилт 16-д 1990 оны суурь мэдээлэлд үндэслэн 2015 оны түвшинд Баталгаат ундны ус хангамжгүй хүн амын эзлэх хувийг 40%-д, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг 60,8 %-д хүргэж бууруулах зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэйгээр 2012 онд хийгдсэн судалгаагаар томоохон хотуудыг тооцохгүйгээр хөдөөгийн баталгаат ус хангамжийн хүртээмж дундажаар 58%, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж 22%-тай байна. Хэрвээ аймгийн төвүүдийг тооцохгүй бол энэ тоо нь бүр бага гарах юм.

Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн чиглэлээр бодлого гаргаж, хэрэгжилтийг хангах үүрэг, хариуцлага бүхий яам, агентлагийн удирдлагын дээд түвшинд байсангүй. Шинэчлэлийн Засгийн газар 2012 онд байгуулагдсанаар Барилга, хот байгуулалтын яам сумын төвүүдийг оролцуулан хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж байна.

НҮБХХ нь энэхүү салбарт техникийн туслалцаа үзүүлэх, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдралтай иргэдийг дэмжсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой. Үүнд бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийг сумдад барьж, байгуулах, цаашид төслийн хэрэгжилтийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг тогтвортой авч явахад шаардагдах орон нутгийн удирдлагын чадавхийг сайжруулахад үзүүлэх дэмжлэгийг нэгтгэх зэрэгт НҮБХХ ихээхэн туршлагатай юм.

#### ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА САНХҮҮЖИЛТ

Хэрэгжүүлэгч байгууллага: Барилга, хот байгуулалтын яам

Хугацаа: 2013 оны 4 сараас 2014 оны 12 сар хүртэл

Санхүүжүүлэгч байгууллага: БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/  
Төсөвт өртөг: 2,250,000 ам.доллар



#### ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Хөдөөгийн хүн амын унд-ахуйн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн удирдлагын чадавхийг бэхжүүлж Монгол Улсын МХЗ-ын 7 дугаар Зорилгод хүрэхэд дэмжлэг үзүүлэх гол зорилготой.

Төслийн хэрэгжилтийн хүрээнд дараах үр дүн гарна. Үүнд:

1. Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хяналт, бодлогын зохицуулалт, санхүүжилтийн механизм, үйлчилгээний хүртээмж сайжирна;
2. Орон нутгийн байгууллагуудын чадавхи бэхжиж, үйлчилгээний хүртээмж сайжирна;
3. Сонгогдсон аймгуудын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ өргөжинө



МХЗ-д хүрэх, орон нутгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэх нь

### ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

#### ТӨСЛИЙН ҮР АШГИЙГ ШУУД ХҮРТЭЖ БҮЙ БҮЛГҮҮД:

Төсөлд хамрагдаж буй 4 аймгийн 8 сумдын нийт 21,800 оршин суугчид


#### ТӨСЛИЙН ҮР АШГИЙГ ШУУД БУСААР ХҮРТЭЖ БҮЙ БҮЛГҮҮД:

Төсөлд хамрагдаж буй аймаг, сумдад байнга оршин суудаггүй иргэд

#### ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ СУМД

1. Булган аймгийн Бүрэгхангай, Тэшиг сумд,
2. Дундговь аймгийн Гурвансайхан, Дэлгэрцогт сумд,
3. Өвөрхангай аймгийн Баянгол, Сант сумд,
4. Төв аймгийн Бүрэн сум, Зуунмод сумын

Зүүндэлгэрийн 4-р баг



#### Баталгаат ундны ус хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувь

Аймаг	Сумын нэр	Ус хангамжийн байгууламж	Ариун цэврийн байгууламж	Сумын хн амын тоо
1. Булган	Бүрэгхангай	34.84	90.39	2540
	Тэшиг	61.26	81.03	3424
2. Дундговь	Гурвансайхан	54.76	84.56	2146
	Дэлгэрцогт	56.21	87.03	1591
3. Өвөрхангай	Баянгол	78.18	92.67	3967
	Сант	52.84	90.46	3349
4. Төв	Бүрэн	50.97	93.44	3012
	Зуунмод сумын 4-р Баг			1700
Дундаж дүн:		55.58	88.51	21729
2015 оны зорилт		40.0%	60.0%	-

#### Төсөлд хамрагдаж буй сумдын мэдээлэл /2013 он/

Аймаг	Сум	Сумын хн амын тоо	Сумын төвийн хн амын тоо ба өрхийн тоо	Ус хангамжийн эх үүсвэр (гүний худаг)-ийн тоо	Аймаг, орон нутгаас нэмэлт санхүүжүүлтийн хэмжээ /сая ₮/
1. Булган	1. Бүрэгхангай	2540	835/228	4(усны ундага, чанар сайн)	100/100
	2.Тэшиг	3424	1072/396	6 (усны ундага, чанар сайн)	100/сум шийдээгүй
2.Өвөрхангай	3. Баянгол	3967	729/208	5(усны чанар, ундага сайн)	3Т батлагдсаны дараа шийднэ
	4.Сант	3349	676/198	5 (усны ундага, чанар сайн)	3Т батлагдсаны дараа шийднэ
3.Дундговь	5. Дэлгэрцогт	1591	510/176	2 (усны нөвчийн судалгаа хийгдээгүй)	200/200
	6. Гурвансайхан	2146	503/198	6 (усны ундага, чанар муу)	200/200
4.Төв	7. Бүрэн	3012	478/174	2 (ундага, чанар сайн)	50/40+(10)
	8. Зуунмод сумын 4-р Баг	1700	1300/366	1(ус сайн)	50/25
		21729	6103/1844		500/365 +(10)




МХЗ-д хүрэх, орон нутгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэх нь

Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж төслийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар авна уу.

Монгол Улс, Улаанбаатар хот-15171, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж,  
 Барилгын хөгжлийн төв, 2-р байр, 204 тоот  
 И-мэйл: unwatsan@watsan.mn  
 Утас/Факс: +976-77110109



# БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ



Орчуулсан: О.Эрдэнэбаатар  
Б.Пүрэвжав

Хянан тохиолдуулсан: Л.Эрдэнэтуяа  
Ө.Цэдэндамба

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр тухайлбал, бохир ус цэвэрлэж зайлуулах ажлын ач холбогдол өндөр байгаа боловч бохир зайлуулах системийн тухай дэлгэрэнгүй ном ховор байна. Иймээс бохир ус зайлуулах системийн тухай хамгийн сүүлийн үеийн ололтыг тусгасан ном гаргахаар бид зориглон ажилласан юм.

## УДИРТГАЛ

Цэнгэг усны эх үүсвэрийн ойролцоо хүмүүсийг сууришуулж, үйлдвэрийн объектууд байгуулж, унд, ариун цэвэр, үйлдвэр, хөдөө аж ахуйн зорилгоор уг эх үүсвэрээс ус ашиглаж байжээ. Хүн усыг ашиглах /хэрэглэх/ явцад ус өөрийн байгалийн унаган чанараа өөрчилдөг бөгөөд нэлээд тохиолдолд ариун цэврийн хувьд аюултай болдог. Үйлдвэрийн газрууд, хотын инженерийн байгууламжийн хөгжилтэй уялдан тусгай гидротехникийн байгууламж хэрэглэж, бохирдуулсан усны урсгалыг зайлуулах зохион байгуулалтын арга хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон юм.

Байгалийн түүхий эд болох цэнгэг усны ач холбогдол одоо цагт байнга өсөж байна. Усыг үйлдвэр болон ахуйд хэрэглэхэд минераль / эрдэс/, органик гаралтай бодисоор бохирдуулдаг. Тийм усыг бохирдсон ус /сточная вода/ гэж нэрлэдэг ажээ.

Бохир усны үүслээс хамааран бохир усан дотор хортой бодис юмуу мөн янз бүрийн халдварт өвчин үүсгэгч агуулсан байж болзошгүй юм. Үйлдвэрийн газар, хотын усны аж ахуйн систем нь өөрийн урсгалын ба даралттай хоолой, үүссэн тунадас, усыг зайлуулах, цэвэрлэх, халдваргүйжүүлж, ашиглахыг хэрэгжүүлдэг бусад тусгай байгууламжийн орчин үеийн комплексээр тоноглогдсон болно.

Тийм комплексийг ус зайлуулах систем гэнэ. Ус зайлуулах систем нь түүнчлэн бороо, тундасны хайлсан усыг зайлуулж цэвэрлэнэ. Ус зайлуулах систем байгуулснаар хот, суурин газрын хүн амын /иргэдийн/ орон сууц – ахуйн хэвийн нөхцөл хангагдаж, байгалийн хүрээлэн буй орчин сайн түвшинд хадгалагдах юм.

## ХЭСЭГ I

### УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ

#### УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

##### 1.1 БОХИР УС, ТҮҮНИЙ ТОВЧ ШИНЖ ЧАНАР

Бохир ус гэдэг нь хүн цэнгэг усыг үйлдвэр ба ахуйн хэрэглээнд ашигласны дараа физик – химийн шинж чанар нь өөрчлөгдсөн зайлуулах шаардлагатай болсон ус юм.

Үүслээр нь бохир усыг ахуйн, үйлдвэрийн, хур тундасны гэж ангилж болно.

**Ахуйн бохир ус** нь орон сууц, албан газар, нийтийн эзэмшлийн барилга /угаалга, халуун ус г.м/ , түүнчлэн үйлдвэрийн газрын ахуйн барилгуудад бий болно. Энэ бохир ус сантехникийн хэрэгсэлүүд / угаагуур, тосгуур,



суултуур, шалан дээрх сараалж, ванн зэрэг / - ээс ус зайлуулах сүлжээнд орж ирдэг. Энэ усны үүсч бий болох тухай онцлогийг бид сайн мэднэ.

**Үйлдвэрийн бохир ус** янз бүрийн бараа, материал, хүнсний зүйл, бүтээгдэхүүн гэх зэрэг зүйл үйлдвэрлэх явцад үүсдэг. Ашиглагдсан технологийн уусмалууд, эх уусмалууд, тогоо савны үлдэгдэлүүд, технологийн болон угаалгын ус, хөргөлтийн систем, вакуум насос, барометрийн конденсаторын ус, уурхайн ба карьерийн ус, үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж угаасан ус, химийн ус цэвэрлэгээний ус, мөн түүнчлэн хийн хэлбэртэй хаягдал цэвэрлэх буюу хөргөхөөс гарсан, хатуу хаягдлыг цэвэрлэх, эсвэл зөөвөрлөхөд хэрэглэсэн ус үүнд хамаарна.

**Хур тундасны бохир ус** суурин газрын хүн суурьшсан хэсэг, үйлдвэрийн газрын орчинд бороо орох, цас хайлах, явцад үүснэ. Энэ усыг борооны буюу аадар борооны гэж ихэвчлэн нэрэлдэг бөгөөд ихэнх тохиолдолд хамгийн их /тооцооны/ зарцуулалт аадар ширүүн борооны үед үүсдэг тул ингэж нэрлэжээ.

**Бохир усны үндсэн шинж чанар** бол л / с, / с, - оор хэмжигддэг бохир усны хэмжээ, мг / л, - аар хэмжигддэг бохир усан доторхи бохирдлын өтгөрөл тодорхойлдог, бохирдлын төрөл/хольц/, тэдгээрийн /хольцын/ агууламж юм. Бохир усны бас нэг чухал шинж бол тэдгээрийн жигд /жигд бус/ үүсэж, ус зайлуулах системд жигд орох байдал юм. Үүнийг ерөнхийдөө жилийн хоногийн цагаар системд бохир ус орох жигд бус байдлаар тодорхойлно. Энэ шинж байдлыг ус зайлуулах системийн төсөл боловсруулахдаа харгалздаг.

Ахуйн бохир усан дотор эрдэс болон органик гаралтай бохирдол агуулагдаж байдаг. Тэдгээрийн аль аль нь бохир усанд шууд ууссан юмуу коллоид байдалд оршино. Шинжилгээний үед цаасан шүүлтүүрт баригдаж үлдсэн уусаагүй бохирдлын хэсгийг тоорог бодис /взвешенное вещество/ гэнэ. Хамгийн аюултай нь органик гаралтай бохирдол юм. Ахуйн бохир усан дотор органик гаралтай тоорог бодис дунджаар 100 – 300 мг / л байдаг. Уусмал байдалд орших органик бохирдлын агууламжийг хүчилтөрөгч доторхи биохимийн хэрэгцээ / БХХ /, хүчилтөрөгч доторхи химийн хэрэгцээ / ХХХ / -

ний хэмжээгээр үнэлэнэ. Ахуйн бохир усны БХХ 100 – 400 мг/л, ХХХ 150 – 600 мг/л байх бөгөөд үүнийг нэлээд их бохирдсон гэж үнэлэх болно. Түүнийг хадгалавал 12 – 24 цагийн дотор ялзарч муудах чадвартай / усны температур 20 байхад/.

Хот доторхи 1 га талбайн ахуйн бохир усны зарцуулалт дунджаар 0,3 – 2 л/с (хувийн зарцуулалт) буюу 10 000 – 60 000 байна. Бохир ус нь ус зайлуулах сүлжээ рүү жилийн хоног, хоногийн цагаар харьцангуй жигд бус орно. Шөнийг бодвол өдөрт усны зарцуулалт их байх ба хоногийн цагаар 2 – 5 дахин ялгаатай байдаг.

Жилийн доторхи хоногуудын ахуйн усны зарцуулалт тун бага 1,1 – 1,2 дахин зөрүүтэй хэлбэлздэг байна.

Аж үйлдвэрийн янз бүрийн салбарын үйлдвэрийн бохир ус янз бүрийн бохирдол агуулдаг. Тэдгээрийн бохирдлын өтгөрөл мөн л янз бүр байна. Жишээ болгож үйлдвэрийн зарим салбарын бохир усны шинж төрхийг доор гаргав.

Целлюлоз - цаасны заводын бохир усан дотор 400 – 2000 мг/л тоорог бодис байдаг. Үүний ихэнх нь модны үртэс, целлюлоз юм. Сульфатын заводын нийт бохир усан доторхи БХХ 100 – 200 мг/л, сульфит 0,8 – 2 г/л байна.

Хар металлын заводын тодорхой цехүүдийн бохир усан дотор органик биш тоорог бодис 0,2 – 5 мг/л, төмрийн хаг 0,3 – 2 г/л, фенол 0,7 – 1 г/л, давирхай, масло 0,2 – 1,8 г/л байдаг.

Нэхмэлийн үйлдвэрийн бохир усанд тоорог бодис 250 – 400 мг/л, угаагч бодис 50 – 120 мг/л, БХХ 300 – 350 мг/л – т хүрдэг ажээ.

Хүнд үйлдвэрийн усанд эрдэсийн гаралтай, харин хүнсний болон хөнгөн үйлдвэрүүдийн усанд органик гаралтай бохирдол зонхилон агуулагддаг байна. Янз бүрийн салбарын үйлдвэрээс зайлуулж байгаа бохир усны үүслийн жигд байдал, тоо хэмжээ маш олон янз байна.

Борооны усанд усдаггүй эрдсийн хольц их байдаг ба харин түүнчлэн органик гаралтай бохирдол ч тохиолдоно. Борооны усны БХХ 50 – 60 мг/л – т ч хүрдэг. Усан санг бохирдуудлаг нэгэн гол эх үүсвэр бол борооны ус болохыг судалгаагаар тогтоожээ. Хотын газар нутгийн



1 га талбайн борооны усны зарцуулалт 150 л/с (жилд 1 удаа) - аас 300 л/с (10 жилд 1 удаа) – эд хүрдэг байна. Энэ нь ахуйн бохир усны зарцуулалтаас 50 – 300 дахин их байгааг харуулж байна. Гэсэн ч 1 га талбайн нийт борооны усны жилийн зарцуулалт 1500 – 3000 шоо метрт хүрч ахуйн бохир усныхаас 5 – 30 дахин бага байдаг. Борооны ус тун жигд бус үүсдэг (унадаг). Түүний зарцуулалт тэгээс (хуурай жилд) хамгийн их буюу 300 л/с (эрчимтэй үер болсон улиралд) – д хүрнэ.

“Хотын бохир ус” гэсэн ойлголтыг хангалттай сайн хэрэглэдэг. Ахуйн болон үйлдвэрийн бохир усны хольцыг ингэж нэрлэдэг байна. Бодит амьдрал дээр цэвэр хэлбэрийн ахуйн бохир ус байдаггүй. Хотоос ирж байгаа бохир усан дотор үйлдвэрийн бохир усны шинжтэй бохирдол ( нефьтийн бүтээгдэхүүн, хүчил, шүлт, давс г.м) байнга агуулсан байдаг. Хотын бохир усыг зайлуулж цэвэрлэх асуудал шийдвэрлэхдээ үүнийг заавал тусгах хэрэгтэй.

Дээр дурьдсан бүх бохир усанд зөвшөөрөгдөх хязгаараас ихээхэн давсан өтгөрөлтэй янз бүрийн бохир бодис агуулагдаж байдаг тул заавал цэвэрлэж ил усан санд зайлуулах шаардлага тавигддаг юм.

Бохир усны бохирдлын зэрэг янз бүр байдаг мөн түүний үүссэн байдал нь зураг төсөл боловсруулахдаа тэдгээрийг нийлүүлэх юмуу эсвэл салангад системээр зайлуулах, нийлүүлэх юмуу эсвэл салгаж цэвэрлэх асуудлыг оновчтой зөв сонгож шийдвэрлэхэд хүргэж байгаа юм.

Бохир усны шинж чанар, бүтэцийг IV хэсгийн 8 дугаар бүлэгт үзэх болно.


Бохир усны физикийн загвар нь шингэн – хатуу гэсэн хоёр фазтай систем бөгөөд ус цэвэрлэгээний ямар ч технологи хатуу фазыг салгаж авах зорилготой болно. Термодинамикийн хуулиар ус амархан бохирддог боловч энэ үйл явц энерги бараг зарцуулахгүй явагддаг байна. Харин ус цэвэрлэх явцыг мэдэгдэхүйц хувийн энерги зарцуулалтаар янз бүрийн нарийн төвөгтэй үйл явц ашиглан хэрэгжүүлдэг ажээ. Шингэн – хатуу - гийн систем бол бохир ус цэвэрлэхийн тулд нэн хэрэгтэй далд энерги илэрхийлсэн энтропия юм. Хэдий чинээн бохирдол өндөр, элдэв төрлийн бүтэцтэй

(разнородность состава) бол төдий хэмжээгээр энтропия өндөр, ус цэвэрлэх энергийн зардал их байна.

Бохир усны бохирдолын элдэв олон төрөл ба системийн энергийн байдал өөрчлөгдөхөд диссипаци явагдаж байгаа үзэгдэлүүдээс болж бохир усыг зуун хувь цэвэрлэх бололцоогүй учир **өтгөрлийн зөвшөөрөгдөх хязгаарын** утгаар түүнийг (цэвэрлэгээг) тогтооно (ӨЗХ).

## 1. 2. УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМИЙН ҮНДСЭН ЭЛЕМЕНТҮҮД

Суурин газрын ус зайлуулах системийг боловсруулахдаа 1:5 000 – 1:20 000 масштабтай, 1 – 2 м - ийн хэвтээ чиг (горизонталь) бүхий хороолол, зам тэмдэглэсэн хотын ерөнхий төлөвлөгөөний зураг, үйлдвэрийн газрын ус зайлуулах систем бол 0,5 – 1 м хэвтээ чигтэй 1:1 000 – 5 000 масштабтай ерөнхий төлөвлөгөөний зураг дээр боловсруулна.



**Зураг. 1. 1. Хотын ус зайлуулах ерөнхий бүдүүвч:** ДНС – дүүргийн насосны станц; ГНС – гол насосны станц; ЦБ -- цэвэрлэх байгууламж; ҮГ - үйлдвэрийн газар; 1 – хотын хил; 2 – ус зайлуулах гадна сүлжээ; 3 – аадар тавилуур; 4 – дюкер; 5 – цэвэрлэсэн бохир усны гаргалгаа; 7 – усан хагалбар.


Зураг.1.1 дээр хотын ус зайлуулах ерөнхий бүдүүвч үзүүлэв. Доорхи үндсэн элементүүдээс ус зайлуулалт бүрдэж байна:

1. сан - техникийн төхөөрөмжөөр тоноглогдсон барилга дотор ус зайлуулах сүлжээ; хороолол доторх ус зайлуулах сүлжээ;
2. 26 ус зайлуулах гадна сүлжээ;



3. тохируулга – аварийн нөөц сан (резервуар);
4. тусгай зориулалтын байгууламжууд;
5. насосны станц, түрэлттэй хоолой;
6. бохир ус цэвэрлэх станц;
7. бохир усны цэвэрлээгүй аварийн урсгалын гаргалгаа (выпуск).

Зураг. 1. 2 дээр орон сууцны дотоод ус зайлуулах сүлжээний бүдүүвч үзүүлэв. Энэ нь бохир ус тосч авах тоноглол (сантехникийн хэрэгслүүд), ус зайлуулах босоо, хэвтээ хоолойноос тогтсон дотоод ус зайлуулах сүлжээ, барилгаас ус гаргах хоолойноос бүрдэнэ.



**Зураг. 1. 2. Орон сууцны барилгын доторхи ус зайлуулах бүдүүвч:** 1 – ариун цэврийн хэрэгслүүд; 2 – сифон (усан хаалтуур); 3 -- ус зайлуулах шугам; 4 – босоо шугам; 5 – гаргалгаа.


Зайлуулах шугамын хоолойг ус өөрийн урсгалаар явах нөхцөл хангаж босоо хоолой руу хазайсан хэвгийтэй тавина. Босоо хоолойг эгц босоо тавина: түүний дээд хэсэг ашиглалтгүй дээвэр дээр 0,3 м, ашигладаг дээвэр дээр

3 м, налуу дээвэр дээр 0,5 м өндөр байна. Гаргалгаа гэдэг нь босоо хоолойноос хороолол доторхи ус зайлуулах сүлжээний үзлэгийн худаг хүртэлх хоолойн хэсэг юм. Түүнийг ус зайлуулах шугамтай адил мөн л хэвгийтэй тавина.

Доторхи ус зайлуулах сүлжээг хэсэгчилсэн дүүрэлттэйгээр тооцох ба бүр бохир усны хамгийн их зарцуулалтын (тооцоот) үед ч хагас дүүрэлттэй байхаар тооцдог.

Хотын болон үйлдвэрийн гадна ус зайлуулах сүлжээг салхилуулах үүргийг доторхи ус зайлуулах сүлжээ давхар гүйцэтгэнэ. Ажиллагааны хэвийн нөхцөлтэй үед босоо шугамаар хий сорогдож гарна. Тасалгаанд хий оруулахгүйн тулд ариун цэврийн хэрэгсэл доор сифон (гидравлик хаалтуур) тавьдаг. Сифон нь гогцоорсон хоолой бөгөөд дотор нь 8 – 10 см өндөр усан бөглөө байнга байдаг. Заримдаа ариун цэврийн хэрэгслийн бүрэлдэхүүнд сифон орсон байдаг. Хоолойг шалгаж, цэвэрлэхэд зориулж ревиз тавьдаг. Барилга бүр хэд хэдэн босоо шугамтай байх ба баригын давхар бүр дээр нэгтгэсэн ариун цэврийн хэрэгслүүдэд холбогдно.

Үйлдвэрийн бохир усыг барилгаас зайлуулахын тулд мөн л доторхи ус зайлуулах сүлжээг барина. Харьцангуй их хэмжээний зарцуулалттай ус зайлуулах болбол далд сувган сүлжээ байгуулдаг (нэгдүгээр давхарт).




**Зураг. 1. 3. Борооны усны дотуурхи системийн бүдүүвч:** а -- үйлдвэрийн барилга;



б – хавтгай дээвэртэй орон сууцны браилга; в – налуу дээвэртэй орон сууцны барилга; 1 – цэвэрлэгээ хийх төхөөрөмж; 2 – босоо шугам; 3 – буландаж нугалсан хоолой; 4 – борооны ус тосох воронка; 5 – усан хаалт; 6 – ил гаргалгаа; 7 – борооны усны хоолой; 8 – ховил; 9 – борооны ус ордог сараалжтай худаг; 10 – газар доорхи гаргалгаа; 11 -- үзлэгийн худаг.

Зураг. 1. 3 дээр борооны ус тосож авах, зайлуулах доторхи сүлжээний бүдүүвчийг үзүүлэв. Барилгын дээврийг борооны ус цуглуулж, зайлуулан борооны усны сүлжээнд нийлүүлэх шаардлагыг тооцож хийнэ. Хэрэв дээвэр төвөгтэй хэлбэртэй ( зураг.1. 3, а) юмуу хавтгай (зураг. 1. 3, б) бол хоолойг барилга дотор тавьдаг. Дээвэр дээр тавьсан борооны усны воронкоор дамжуулж дотоод сүлжээ рүү борооны ус хүлээн авна.

Усыг барилгаас гаргаж хорооллын ус зайлуулах сүлжээнд хийх юмуу эсвэл газрын гадаргуу дээр хаяна. Гадаргуу дээр ил хаях тохиолдолд дээврээс буусан ус хорооллын барилгажаагүй хэсгийн борооны устай нийлж замын ховилоор урсаж дараа нь хороолол доторхи ус зайлуулах сүлжээтэй холбогдсон борооны ус хүлээн авах тусгай байгууламж (дождеприемник) - д орно. Намхавтар барилгын налуу дээврээс борооны усыг тусгай борооны усны хоолойгоор зайлуулж, харин дараа нь замын ховилоор дамжуулан борооны ус тосож авдаг байгууламжид хийнэ (зураг. 3, в). Хороолол доторхи ус зайлуулах сүлжээ бол газар доор тавьсан хоолойн систем юм (зураг. 1. 4). Барилгын ойролцоо барилгаас гарсан гаргалгааны төгсгөлүүдийн үзлэгийн худаг хооронд, газрын гадаргуун хэвгийтэй давхардсан чиглэлд хороолол доторхи ус зайлуулах сүлжээний чиглэл (трассировка) - ийг тогтооно. Түүнийг гадна (гудамжны) сүлжээтэй холболтын салаа хоолойгоор холбоно. Хоолой бага зэрэг дүүрэлттэй, өөрийн урсгалтай (түрэлтгүй) байхаар хоолойн хороолол доторхи сүлжээний тооцоо хийнэ.



Зураг. 1. 4. Хороолол доторхи ус зайлуулах сүлжээний бүдүүвч: 1 – хороолол доторхи сүлжээний хоолой; 2 -- үзлэгийн худаг; 3 – гудамжны сүлжээ; 4 – холболтын салаа; XX – хяналтын худаг.

Хороолол доторхи сүлжээнээс гудамжны сүлжээ хүртэлх хэсэг дээр хороолол дотор улаан шугамаас (хорооллын хилээс) 1 - 1,5 м зайд хяналтын худаг (XX) байгуулна. Цэвэрлэх байгууламж, гадна ус зайлуулах сүлжээний ашиглалт хариуцсан мэргэжлийн байгууллагаас ус зайлуулах сүлжээг зөв ашиглаж байгаа эсэх, хороолол доторхи сүлжээний ажиллагааг хянахад уг хяналтын худаг (XX) ашиглана.

Үйлдвэр дээр мөн ийм сүлжээ байгуулна. Түүнийг завод доторхи (талбай доторхи) сүлжээ гэнэ.

Заримдаа гудамжны гэдэг гадна ус зайлуулах сүлжээ бол усны хөдөлгөөний чиглэл дагуу хэвгийтэй газар доорхи хоолойн систем юм. Тооцооны нөхцөл (тооцоот зарцуулалт) – ийн үед хоолой бүрэн юмуу хэсэгчилсэн дүүрэлттэй, шингэний өөрийн хөдөлгөөнтэй (түрэлтгүй) байхаар энэ системийн тооцоо хийнэ. Хоолой тавих гүнийг багасгах зорилгоор газрын гадаргуун хэвгийтэй нэг зүгт сүлжээний чиглэл (трассировка) тогтооно.



Ус зайлуулах сүлжээний бүдүүвч боловсруулахдаа аливаа объектыг ус зайлуулах бассейнд хуваадаг (зураг. 1. 1 – ийг үзнэ үү). Ус зайлуулах бассейн гэдэг нь объектын хил, ус хагалбарын шугамаар хязгаарлагдсан, ус зайлуулалтанд хамрагдсан объектын нутаг дэвгэрийн хэсэг юм. Гадна ус зайлуулах сүлжээг гудамжны сүлжээ, ус зайлуулах бассейны коллектор, гол (главный) коллектор гэж хувааж болно.

Гудамжны сүлжээ гэдэг нь хорооллын гадна хүрээний хэсэг (газрын рельефээр доод талаас нь) юмуу бүтэн хүрээгээр нь тавьсан хоолой юм.

Ус зайлуулах бассейны коллектор бол ус зайлуулах нийт бассейны юмуу түүний аль нэг хэсгээс ус авч зайлуулах зорилготой хоолой болно.

Харин гол коллектор бол ус зайлуултанд хамрагдаж байгаа объектын нийт буюу зарим хэсгээс ус авч зайлуулах зорилготой хоолой юм. Энэхүү гол коллектороор усыг насосны станцад юмуу цэвэрлэх байгууламжид хүргэнэ.

Хоолойд үзлэг хийх, гэмтлээс сэрэмжлэх болон засварын ажил явуулахын тулд ус зайлуулах сүлжээн дээр үзлэгийн худаг буюу камер хийж тавьсан байдаг. Өөрийн урсгалтай хоолой байгалийн ямар нэгэн саад (гол, гуу жалга г.м) , газар доорхи байгууламжтай огтлолцох газарт штольни буюу эстакад (гүүр) барьдаг. Заримдаа огтлолыг дюкер хэлбэрээр гүйцэтгэнэ. Ус зайлуулах сүлжээнд борооны ус авахын тулд борооны ус тосогчийг барих ба түүний бүтээц үзлэгийн худгийн бүтээцтэй адил боловч дээд хэсэг нь ус орох сараалжаар таглагдсан байдаг.

Зураг 1 .1 дээр үзүүлсэн бүдүүвчээр ус зайлуулалтад хамрагдсан объект бүх төрлийн, тухайлбал ахуйн, үйлдвэрийн, борооны бохир ус зайлуулах үүрэг бүхий сүлжээтэй байна. Эрчимтэй үерийн улиралд сүлжээн доторхи бохир усны хольцын бохирдол буурна. Энэ нь бохир усны зарим хэсгийг цэвэрлэхгүйгээр усан санд хаях боломжийг олгож байна. Голын эрэг дагуу тавьсан коллектор дээр ус хаяхын тулд аадар тавилуур (ливнеспуск) гэдэг тусгай байгууламж тавина.

Аварийн болон тохируулагч нөөцийн сан

(резервуар) бол хамгийн их бохир ус ирж байгаа үед түүнийг хуримтлуулах явдлыг хангах тусгай тоногдосон эзэлхүүн юм.

Нөөцийн сангаас ус татах, хаях ажиллагааг өөрийн урсгалтай бохир усны ирц буурсан үед юмуу насосны станц ашиглаж явуулна.

Тэгш газарт хоолой тавих гүн түүний уртаас хамааран нэмэгддэг. Хоолойг 7 – 8 м гүнд ил аргаар тавихад хундрэлтэй тул хоолой тавих барилгын далд арга хэрэглэх юмуу эсвэл бохир усыг дамжуулан шахах ажиллагааг хэрэгжүүлэх болно.

**Байрын насосны станцыг** нэг юмуу хэсэг барилгын усыг өргөж, дамжуулан шахахад ашиглана.

Ус зайлуулах бүтэн бассейны юмуу түүний хэсгийн бохир усыг дамжуулан шахахад **дүүргийн насосны станц** ашиглана.

**Гол насосны станцаар** нийт объектын юмуу түүний хэсгийн бохир усыг цэвэрлэх станц руу дамжуулан шахна. Ус зайлуулах байгууламжийн ажиллагааны найдвартай байдлыг дээшлүүлэхийн тулд түрэлттэй хоолойн 2 шугам тавина.

Цэвэрлэх станц гэдэг нь бохир ус цэвэрлэж, тундас боловсруулах зориулалтын байгууламжийн комплекс болно. Ус цэвэрлэгээний механик (элс баригч, сараалж, I тунгаагч), биохими (аэротенк, биофильтр, II тунгаагч), физик – химийн аргаар уснаас бохирдол ялгана. Бохир ус боловсруулах төгсгөлийн шат нь ил усан санд хаяхаас өмнө голдуу халдваргүйжүүлэх явдал юм. Бохир ус цэвэрлэх станцын байгууламжийн зураг төсөл боловсруулахдаа усны өөрийн хөдөлгөөнтэй байхаар тусгах хэрэгтэй.

Үйлдвэрийн гадна байрласан ус зайлуулах байгууламжийг гадна талбайн байгууламж гэж нэрлэдэг. Ус зайлуулах бүх элементүүд харилцан уялдаатай ажиллана. Иймд тундас боловсруулах, бохир ус цэвэрлэх, ус зайлуулах технологид тусгай арга хэмжээг боловсруулж найдваржилтын шаардлагатай зэрэг хангасан байгууламжийн хөгжил, зураг төсөл хэрэгжүүлнэ.

/Үргэлжлэлийг дараагийн дугаараас/



Эруул мэндээ хамгаалцгаая!

# ТАНЫ УНДНЫ УС

## ТАНЫ ӨВЧЛӨЛД НӨЛӨӨЛДӨГ БОЛОВ УУ?

Таны хэрэглэж буй ус тань крантны, савласан, эсвэл шүүсэн ус бол дээрхи хариулт ТИЙМ. Яагаад гэвэл эдгээр уснууд хүчиллэг найрлагатай. Гэтэл бидний биед шүлтлэг ус хэрэгтэй.



4. Хүчтэй Кангэн ус: Жимс ногоо болон бусад зүйлсийг цэвэрлэх;
  5. Хүчтэй хүчиллэг ус: Ариутгалын зориулалттай, бактерийг устгах;
- Кангэн Ус нь ионжуулсан, шүлтлэг, хүчилтөрөгчөөр баялаг, жижиг молекулийн бүтэцтэй, амьд ус бөгөөд таны биеийн шингэний дутагдалыг нөхөн өгч эд эсээс элдэв хорт бодисийг шахан зайлуулах чадвартай.

### ШҮЛТЛЭГ УС

Хүний бие шүлтлэг бүтэцтэй байдаг. Өнөөдөр бидний хэрэглэж байгаа хоол хүнс болон ахуйн хэрэглээний эд зүйлс нь та бидний бие организмыг хүчиллэг болгож байгаагаас үүдэн элдэв өвчин эмгэг (хорт хавдар, үе мөч болон чихрийн өвчин гэх мэт) ихсэж байна. Тэгвэл Кангэн ус нь хүний биеийн шүлтлэгийн хэмжээг хэвийн байлгах хамгийн чухал бөгөөд маш энгийн бүтээгдэхүүн юм.

### АНТИ-ОКСИДАНТ

Өдөр тутам хүний биед гадны ямар нэгэн нөлөө, хоол хүнсээ боловсруулах болон эрүүл мэндийн шалтгаанаас болж исэлдэлт ба чөлөөт радикал (эд эс хос цэнэгийнхээ нэгийг алдахыг чөлөөт радикал гэнэ) ихсэж үүнээс үүдэн хөгшрөлт хурдасч элдэв өвчин эмгэг ихсэх болсон. Кангэн ус нь чөлөөт электроноор маш баялаг бөгөөд энэ нь чөлөөт радикалыг саармагжуулан зогсоох хүчтэй үйлчилгээтэй хамгийн хүчирхэг бүтээгдэхүүн юм.

### МИКРО-КЛАСТЕР БҮЮУ МОЛЕКУЛЫН БАГЦЛАЛ

Энгийн усны молекулын багцлал нь 15-20 мөн түүнээс ч дээш байх тохиолдол бий. Тэгвэл Кангэн ус нь 5-6 молекулын багцлалтай учир амьд организмын эд эсийн гүнд нэвтрэн орж шингэний хангамжийг сайжруулснаар бодисын солилцоог дээд зэрэгт хүргэж өгдгөөрөө онцлог юм.

## ДЭЛХИЙН ХАМГИЙН САЙН, ШҮЛТЛЭГ КАНГЭН УСТАЙ ТАНИЛЦАЦГААЯ!

- Таны биеийн шүлтлэгийн тэнцвэрийг сэргээн аливаа өвчний эх үүсвэр болсон хүчиллэг хорт бодис хуримтлагдахаас урьдчилан сэргийлнэ.
- Биеийн дархлааны системийг хүчтэй болгон өгдөг хүчирхэг анти-оксидант юм.
- Шингэний дутагдлыг нөхөж бодисын солилцоог сайжруулж биеийн эрч хүч энерги нэмэгдүүлнэ.

### 5 ТӨРЛИЙН УС ГАРГАНА

1. Кангэн ус: Уух болон хоол хүнсээ болгох;
2. Цэвэр ус: Эм уух болон нялх хүүхдийн тэжээл найруулах;
3. Гоо сайхны ус: Арьсийг чангалах болон арьсны элдэв үрэвслийг дарах;

Хэрэглэний усаа сольж амьдралын хэв маягаа өөрчилцгөөе!



Энгийн усны Молекулын багцлал 15-20 молекул

Кангэн усны Молекулын багцлал 5-6 Молекул

## ХҮЧИЛ НЬ ӨВЧНИЙ ЭХ ҮҮСВЭР БОЛДОГ

Бидний бие шүлтлэг бүтэцтэй байдаг. Хүчил нь хоолыг боловсруулахын тулд ходоодонд үүсч бий болно. Иймээс ходоодноос бусад биеийн аль ч хэсэгт илүү хүчиллэг байх ёсгүй.

### ХҮЧИЛШИЛ

Хүний биеийн хүчил хэт ихсэх нь дараах өвчнийг бий болгоно:

- Эрт хөгширөх
- Гормоны тэнцвэржилт алдагдах
- Төрөл бүрийн хорт хавдар үүсэх
- Цусны даралт ихсэх
- Дархлаа буурах
- Зүрхний шигдээс
- Харвалт өгөх
- Холестерол ихсэх
- Сахарын өвчин үүсэх
- Түрүү булчирхай томрох

## УСНЫ ТӨРӨЛ ҮНЭХЭЭР НӨЛӨӨЛӨХ ҮҮ?

Тэгэлгүй яахав. Крантны ус нь найрлагандаа химийн бодисыг агуулдаг. Зөвхөн шүлтлэг ус нь биеийн хорыг гадагшлуулах хүчтэй нөлөөтэй. Шүлтлэг ус нь шингэний дутагдлыг нөхөх хамгийн үр дүнтэй арга. Мөн биеийн шүлтлэгийг болон чөлөөт радикалыг тэнцвэржүүлнэ.

## ШҮЛТЛЭГ УСЫГ ЯАГААД ЗААВАЛ УУХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Ус нь бидний биеийг бүтээж байдаг сая сая эсийн хамгийн чухал шим тэжээл болдог. Бидний биеийн бүтцийн 75%, тархины 85% уснаас бүрддэг. Биеийн тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд тодорхой хэмжээний шүлтлэг усыг өдөр тутам заавал уух ёстой байдаг нь таны эрүүл байхын үндсэн түлхүүр юм.



Кангэн ус танд  
ямар ач тусыг өгөх  
вэ?

“Хүчиллэг хүчилтөрөгчөөр дутмаг орчинд хорт хавдрын эд эс урган төлжиж томорч байдаг. Шүлтлэг хүчилтөрөгчөөр баялаг орчинд оршин тогтож чаддаггүй.”

Энэ нээлтээрээ Германы эрдэмтэн Отто Варбург 1931 онд Нобелийн шагнал хүртсэн.



2003 онд Петер Агре,

Родерик Мак Киннон хоёр өөрсдийн тэргүүлэх “Усан Суваг” нээлтээрээ Нобелын шагнал хүртсэн. Энэ нээлт нь ус эд эсээр орж гарах механизм бөгөөд энэ нь эрүүл мэндэд өндөр ач холбогдолтой. Маш олон өвчин эмгэг нь эд эсийн усны муу солилцооноос үүдэлтэй.



“Бидний бие махбодид болж байгаа бүх зүйлс нь биохимийн урвалаас бий болдог. Биохимийн урвал явагдахын тулд шингэн хэрэгтэй бөгөөд энэ нь ус юм. Тэгэхээр ус хүний бие организмд маш чухал хэрэгтэй. Тийм учраас бид биеийн шигнэнийг байнга хангаж байх хэрэгтэй.”

Доктор Тим МакНайт

КАНГЭН УСЫГ ЭЛДЭВ ЗАРДАЛ ГАРГАЛГҮЙГЭЭР ГЭРТЭЭ ӨӨРСДӨӨ БҮТЭЭЖ ӨДӨР ТУТМЫН ХЭРЭГЛЭЭ БОЛГОЖ ГЭР БҮЛИЙНХЭЭ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛЦГААЯ!

Тэгвэл Enagic Leveluk цахилгааны аргаар ионжуулсан ус гаргадаг төхөөрөмж нь танай гэр бүлд маш хялбар аргаар олон төрлийн pH - тэй сайн чанарын ус гаргаж өдөр тутмынхаа амьдралд өөр өөр зорилгоор хэрэглэх боломжыг олгож байгаа юм.

Кангэн усны Leveluk төхөөрөмжийг Японы Эрүүл Мэндийн Яамнаас эмнэлгийн тоног төхөөрөмж гэж баталсан.



# G E E P I L

CONSTRUCTION & MINING LLC

- Ажлын сайн гүйцэтгэл
- Тэсвэрлэлтийн чанарын сайжруулалт
- Ажлын ургэлжлэх хугацааг тус тус 20% хэмнэнэ.


# HELIX™

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тодорхойлолт: "Helix" бичил арматур нь богино урттайгаар тайрсан, тус бүрдээ эрчилсэн мушгиатай, ган төмөр утас юм. Түүнийг бетон зуурмаг, шохойн зуурмаг болон бусад нийлмэл материалыг хүчитгэхэд ашиглах зориулалттай.

## C4 Тэслэх Туршилт

Уламжлалт аргаар зангидсан арматур бүхий төмөр бетон хийц (зүүн гар талын фото зураг) ба Helix-ийн бичил арматур бүхий төмөр бетон хийцэд (баруун гар талын фото зураг) бат бэхийг шалгах тэслэх туршилт үйлдсэний дараах үр дүнг зургаар харуулав.



- Хэрэглээ:
- Барилгын хана
- Барилгын шал
- Барилгын суурь
- Дам нуруу /Багана
- Гудамж /Зам
- Цацмал бетон
- Арматур
- Угсармал бетон орлуулах


## Шинж чанар:

Суналтын хүч:  
хамгийн бага 1700 Н/  
мм<sup>2</sup> (хамгийн бага  
246.000 psi)

Материал: өндөр  
карбонт ган утас

Бүрээс:

Электоролизийн  
аргаар цайраар бүрсэн.



**REBAR MESH**  
Only **HELIX™** in the mix!



Арматур ба арматурын ган торны оронд HELIX micro-fiber-ийг сонгож төмөр бетон бүтээцийг хийх болсон 10 шалтгаан:

1. HELIX нь суурилуулалтын алдааг засдаг.

Бичил-туйванг төмөр бетон бүтээцэд хэрэглэхээр үйлдвэрлэж эхэлсэн цагаас хойш HELIX нь туйвангийн оновчгүй суурилуулалтаас үүддэг алдааг арилгахыг зорьсон юм. Тухайлбал, уламжлалт арматурыг буруу байрлуулбал бетон бүтээцийн үр ашигтай бат бэхийн үзүүлэлт 50% -иар буурдаг. Мөн туйванг байрлуулахад хэрэглэдэг тулгуур хөлийг ("chairs") ашиглах шаардлагагүй болсноор бетон цутгамлын бат бэхийг сулруулдаг тулгуур хөлний нөлөө үгүй болох юм.

2. HELIX нь бетон хэсгийн бат бэхийг 40% -иар нэмэгдүүлдэг.

Helix нь арматурын уяа, зангилааны хэрэглээг бууруулж, шилжилтийн бат бэхийг нэмэгдүүлдэг ба бетон цутгамлыг аль ч чиглэлд гагнан бэхэлж өгдгөөрөө давуу талтай.

3. HELIX нь бетон цутгамлын энерги шингээх чадварыг 200% -иар нэмэгдүүлдэг.

Helix нь газар хөдлөлтийг тэсвэрлэх, их ачааллыг даах зэрэг бетоны бат бэх, тэсвэрлэх хугацааны үзүүлэлтийг сайжруулдаг.



#### 4. HELIX нь хагарлыг маш сайн хянах шинж чанартай.

Helix нь, бетон хийцэд хагарал үүссэн тохиолдолд түүнийг хэт томруулалгүйгээр нягт бөгөөд бичил хэмжээнд барьж байх зориулалттай бүтээгдсэн.

#### 5. HELIX нь илүү аюулгүй буюу хэсэгчилсэн бэхлэх систем юм.

Зэвэнд бүхэлдээ идэгдсэнээс тухайн систем бүрмөсөн эрсдэлд орохоос Helix сэргийлж чадна. Үүний эсрэгээр, уламжлалт арматуран бэхлэгээ нь үргэлжээрээ холбогдсон байдгийн улмаас цахилгаан дамжуулдаг байна.

#### 6. HELIX нь ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг дэмждэг.

Helix –ийг ашиглаж эхэлснээр уламжлалт аргаар арматурын ган төмрийг хэрчих, суурилуулах, татах, сунгах, өргөх, сараалж торны дээр асгах, унагах гэх мэт зөвөрлөлтийн үе явцад тохиолддог бэртэл гэмтлийг бууруулдаг.

#### 7. HELIX-ийг электролизийн аргаар цинкээр бүрсэн.

Стандарт арматурын ган туйван, ган тор нь бүрээсгүй байдаг. Харин Helix нь зэврээх үзэгдлийг 3 дахин удаан тэсвэрлэдэг болох нь мөстөлтийн эсрэг туршилтаар нотлогдсон байна.

#### 8. HELIX нь барилга угсралтын ажлын үргэлжлэх хугацааг бодитойгоор богиносгож чаддаг.

Helix –ийг хэрэглэснээр арматурын үе тавих, уях, зангидах, болон тэдгээрийг хянаж шалгах цаг хугацааг хэмнэхээс гадна ихэнх тохиолдолд маш шигүү байрлалтай туйвангуудын хооронд хоосон орон зай үүсэх, түүнийг соруулж авах арга ажиллагааг халж хөнгөвчилдөг.

#### 9. HELIX нь бэхлэгээний зардлыг доод тал нь 20% -иар бууруулдаг.

Helix –ийг хэрэглэснээр хаягдал төмөр, тулгуур хөл, холбогч гангийн хэмжээг бууруулахын зэрэгцээгээр хүний хөдөлмөр оролцсон ган туйван, ган торыг суурилуулах, байрлуулах арга ажиллагааг халдаг.

#### 10. HELIX нь LEED (Leadership in Energy and Environmental Design = Эрчим хүч, Байгаль орчинд ээлтэй загварын манлайлал = ЭХБОЭЗМ) зорилтыг хангахад тусална.

Helix –ийг 50% -ийн дахин боловсруулсан гангаар хийдэг ба бүрэн хэмжээгээр ашиглагддаг учраас ачааны автомашин, сэрээт ачигч, краны хаягдал үлэмж хэмжээгээр буурч байна.

#### Баталгаажуулалт

“Helix micro-rebar 5–25 -ийг төмөр бетон хийц дахь арматур болон төмөр торны оронд хэрэглэж болох хувилбараар олон улсын стандартчлалын ISO –ийн 65 –р удирдамжид 2014 оны 02 сарын 20 -ны өдөр үнэлэгдэж тусгагдсан. Ийнхүү ISO – оор дэлхийд гэрчлэгдсэн “Helix micro-rebar” нь төмөр бетон хийц дахь арматуран бүтээгдэхүүний хэрэглээг дуусгавар болгох онцлогтой бүтээгдэхүүн бөгөөд бетоны арматурчлалын анхан шатны хэрэглээнд, ханын цутгалтанд хэрэглэж болно гэж заажээ.

IAPMO Uniform ES- ийн ER 279- өөр батлагдаж, ISO- оор гэрчлэгдсэн Helix- ийг дэлхийн 99 оронд хэрэглэж эхлээд байна. Архитекторууд, дизайнерууд, захиалагч, гуйцэтгэгч нар албан ёсны норм ба дүрэмийн дагуу Helix- ийг хэрэглэх боломжтой юм.

Америкийн Материал ба Сорил Шинжилгээний Нийгэмлэгээс (ASTM) шалгагдаж, баталгаажсан. “ASTM A820” буюу Төмөр бетонд хийцэд зориулагдсан ган арматур стандартад тэнцэж, зөвшөөрөгдсөн.

#### Үнэлгээний Тайлан

IAPMO Uniform ES, Тайлангийн No: 0279  
Гаргасан: 05/2013, Хянагдсан: 02/14/2014  
Хүчинтэй: 05/2014

Дүрслэл: Helix 5-25 – Бичил арматур нь хвйтэн аргаар боловсруулагдсан.

Суналтын хвч- 1800 Мра +/- 100 Мра ба 3 g/ m2 цинкан бүрмэлтэй.

Урт: 25 мм +/- 0.004 мм

Диаметр: 0.5 мм +/- 0.02 мм

Хөндлөн огтлолийн талбай нь 0.196 мм2

Helix Бичил арматур нь 360°- ийн мушигралтай Helix 5-25 – Бичил арматур нь 10 кг, 22.5 кг-

аар савлагдсан

Хэвийн жин 28 өдөрт шахалтийн байх өтгөрөл хатуулаг (хвч) – 20.66 Мра

#### Helix – ийн орцын хэмжээ

А анги: Хагаралын хяналт ба хөнгөн ачаалал.

Min: 6 кг/ м3

Max: 40 кг/ м3

Энэ ангид энгийн бүтээцэд зориулагдсан зуурмагийн төрөл хамаарагдана.

В анги: Бүтээцийн бага арматурчлал.

Min: 6 кг/ м3

Max: 40 кг/ м3

Энэ ангид Helix нь хөрсөн дээр тулгууралсан бүтээцийн ул болон суурийн, арматурын бүтээцийг орлоно.

С анги:

Min: 9 кг/ м3

Max: 40 кг/ м3




Helix нь бусад бvх төрлийн бетоны болон, тулгуургүй горизонтал алгаслалын арматурын бүтээцийг орлоно.

Cs анги:


Min: 12 кг/м3

Max: 40 кг/м3


Шугаман бус хавтангийн дизайны арматурчлалыг орлоно.



Helix- ийн ангиудын сонголтыг харуулсан ХVСНЭГТ.



Helix- ийн хүчний тогтвортой байдал ба суналтын зохицолын диаграмм.



**Pensmore Харш**  
**Ангилал:** дулаалгат тусгай хэлбэрт бетон (ICF)  
**Байршил:** Highlandville, MO  
**Хэрэглээ:** дулаалгат тусгай хэлбэрт бетонон хана, хөрсөн дээрх цутгамал хавтан, суурь  
**Хэмжигдэхүүн:** 6,960 м2  
**Орц:** хана: 18 kgs/м3, дээвэр: 25 kgs/м3  
 Pensmore- ийн харш нь 6,970 м2. Энэ харш нь хамгийн хүчтэй шуурга болох EF-5 Tornado- г эсэргүйцэх чадвартайгаар төлөвлөгдөж хийгдсэн.



**Steel Technologies LLC**  
**Ангилал:** үйлдвэрлэл/үйлчилгээ  
**Байршил:** Celaya, Mexico  
**Хэрэглээ:** гадна хөрсөн дээрх цутгамал хавтан  
**Хэмжигдэхүүн:** 40,000 м2  
**Орц:** 18 kgs/м3  
 гадна бетонон талбайд Helix-ийг ашигласан.



**James Madison University Football Stadium**  
**Ангилал:** үйлчилгээ  
**Байршил:** Harrisonburg, VA  
**Хэрэглээ:** гадна хөрсөн дээрх цутгамал хавтан, SOMD, дээд хэсэг, шатлалууд  
**Хэмжигдэхүүн:** 2,200 м3  
**Орц:** олон янзийн





**Pier 57 Ferris Wheel**

Ангилал: дэд бүтэц  
Байршил: Seattle, WA  
Хэрэглээ: хөлөг онгоцны зогсоолын суурь.  
Хэмжигдэхүүн: 748 м<sup>3</sup>  
Орц: 15 kgs/m<sup>3</sup> & 19 kgs/m<sup>3</sup>  
Энэ хөлөг онгоцны зогсоолын суурийг хийхэд Helix-ийг ашигласан.



**Fairmont Village**

Ангилал: орон сууцны хороолол  
Байршил: Grand Junction, CO  
Хэрэглээ: дулаалгат тусгай хэлбэрт бетонон хана  
Хэмжигдэхүүн: 6,100 м<sup>3</sup>  
Орц: 18 kgs/m<sup>3</sup>



**Fort Lee Virginia, North Range**

Ангилал: цэргийн зориулалт  
Байршил: Ft. Lee, Virginia  
Хэрэглээ: хүнд гадаргуугийн хучилт  
Хэмжигдэхүүн: 6,500 м<sup>2</sup>  
Орц: 9 kgs/m<sup>3</sup>



**Цутгамал Хоолой**

Ангилал: үйлдвэрлэл/үйлчилгээ  
Байршил: Flint, Michigan  
Хэрэглээ: Урьдчилан цутгасан цутгамал хийц  
Орц: 3 kgs/m<sup>3</sup>  
Хуурай цутгамал бетонон хоолой; ASTM ачаалалын шалгалтыг давлаа.



**Michigan State University**

Ангилал: үйлдвэрлэл/үйлчилгээ  
Байршил: East Lansing, Michigan  
Хэрэглээ: хөрсөн дээрх цутгамал хавтан/SOMD  
Хэмжигдэхүүн: 6,970 м<sup>2</sup>  
Орц: 6-21 kgs/m<sup>3</sup>  
National Superconducting Cyclotron Laboratory  
(Цөмийн физикийн лаборатор)



**Helen DeVos Children's Hospital**

Ангилал: үйлдвэрлэл/үйлчилгээ  
Байршил: Grand Rapids, Michigan  
Хэрэглээ: SOMD  
Хэмжигдэхүүн: 11,150 м<sup>2</sup>  
Орц: 5 kgs/m<sup>3</sup>  
Энэ эмнэлэгийн шалыг хийхэд Helix-ийг ашигласан.





**Shotcrete Tunnel**  
Ангилал: Shotcrete  
Байршил: Mazatlan Mexico  
Хэрэглээ: Туннель



**Helix Бичил Арматур:**  
**Зовхон ХВЧИТГЭГЧ БОЛДОГ**

*Helix Бичил арматурийг бусад арматуруудтай харьцуулалт*

Томор бетон зуурмагийн хүчин зүйлүүд	Түгээмэл		Fiber- (Үйлдвэрийн аргаар бэлдсэн хамгийн холимог нэгдэл)				HELIX 5-35
	Тор	Арматур	Микро сентетик	Макро сентетик	1 Инч ган торлон I/II	2 Инч ган торлон I/II	
Бэхлэгээ	Good	Good	Poor	Poor	Good	Good	Excellent
Барьцалдах	Good	Good	Good	Good	Good	Good	Excellent
Угсрах үнэлгээ	Poor	Poor	Excellent	Good	Good	Good	Excellent
Уян хатан байдал	Poor	Poor	Poor	Good	Good	Good	Excellent
Эцсийн гүйцэтгэл	Excellent	Excellent	Excellent	Good	Excellent	Poor	Excellent
Цохилтонд Тэсвэрлэх	Poor	Poor	Poor	Good	Excellent	Good	Excellent
Шэрхэглэлийн Тоо	Poor	Poor	Excellent	Good	Excellent	Good	Excellent
Гадагш тэмүүлэх хүч	Poor	Good	Poor	Poor	Good	Good	Excellent
Хондлон огтлолын хүч	Poor	Good	Poor	Good	Excellent	Good	Excellent
Тарлал нуралтын эсэргүүцэл	Poor	Poor	Excellent	Good	Excellent	Good	Excellent
Бүтэцийн зуурмагийн хэрэглээ	Poor	Excellent	Poor	Poor	Good	Good	Excellent
Температур Шалгуур	Good	Good	Poor	Poor	Excellent	Excellent	Excellent
Угсрах бэлдэх хугацаа	Poor	Poor	Excellent	Good	Good	Good	Excellent
Сунгалтийн ашиг	Poor	Good	Poor	Poor	Good	Good	Excellent

**Бэхлэгээ**

Бетон зуурмаг нь мушгиралтыг шууд дагах онцлогтой учир, Helix- ийн бэхлэгээнд маш сайн байдаг.

**Ажлийн гүйцэтгэлийн зардал**

Helix- ийг хольж хутгах машины нэмэгдэл болон тээвэрлэлтийн ажлын гүйцэтгэлийн зардал нь бусад томорлог fiber- аас 3 дахин бага байдаг.

**Уян хатан байдал**

Бетоны сунгалтын модулийг багасгаж, гузайлтын тэсвэрлэлтийг ихэсгэдэг уян хатан байдал нь Helix –ийг зөвхөн ДЭЛХИЙН АРМАТУР болгосон.

**Эцсийн гүйцэтгэл**

Helix нь хэмжээ, жин, өвөрмөц хэлбэр жингээсээ хамаарч бусад fiber- ийг бодвол эцсийн гүйцэтгэл тэгшилгээ маш сайн байдаг.

**Шэрхэглэлийн Тоо**

2- оос 4 хуртэл түгээмэл арматуртай харицуулахад Helix нь 1 м3 ярд бетон- д 11,500 ордог.

**Цохилтонд Тэсвэрлэх**

Helix- ийн бетоны квадрат инч бурт жигд тархсан байдал нь, цохилтын тэсвэрлэлтэнд онц сайн байдаг.

**Гадагш тэмүүлэх хүч**

Helix- ийн, бетонд байхдаа тогтвортой байх үеэс эрчлээс нь тайлагдтал гадагшлах хүч бусад ган fiber- аас 3 дахин их байдаг.

**Хондлон огтлолын хүч**

Helix нь бетоны огтлолын бүх чиглэлд нэмэлт зардалгүйгээр хондлон огтлолын хүчийг уусгэдэг.

**Таралт нуралтын эсэргүүцэл**

Helix нь бетоны квадрат инч бурт 100% тархсан байдаг нь түүний нуралтаас хамгаалсан эсэргүүцэл болдог.

**Бүтэцийн зуурмагийн хэрэглээ**

ACI 318 хэсэг 1.4 заалтын дагуу хэрэглээний тооцоо ба бүрэн гүйцэд хийсэн шалгалт нь Helix – ийн аюулгүй байдлыг хангасан.

**Температурын Шалгуур**

Helix нь бетон дахь температурын өөрчлөлтийг хянахаар нотлогдсон нүүрстөрөгчийн гангаар хийгдсэн байна.


**Угсрах бэлдэх хугацаа**

Helix нь хэвшсэн арматурын ажлийн хөлсийг бүрэн угуй болгох бөгөөд мөн түүнд ган fiber- аас 3 дахин бага орц ордог.

**Сунгалтийн ашиг**

Helix нь 6% - ийн хэрэгтэй эд зүйлсээр хангагддаг бөгөөд , өөр 6% - ийг мушгиралт тайлагдахад зориулдаг.

**Хаанаас авах бэ?**



USA: +001 5713323442

MNG: +976 88115280

MNG: +976 99916295



## УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУУРЬ ХУРААМЖИЙГ МОНГОЛД АНХ УДАА НЭВТРҮҮЛЛЭЭ



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ч.Эрдэнэчимэгтэй ярилцлаа.

**-Танай байгууллагын сонин сайхнаас сонсох гэсэн юм. Энэ онд төлөвлөж байсан ажлууд хэчнээн хувьтай хэрэгжиж байна вэ?**

-Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл байгуулагдаад хоёр жил болж байна. Бид энэ жил олз омогтой байна. Хоёр жилийн турш шаргуу хөөцөлдсөн ажлын үр дүн гарч, усны үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх, үнэ тарифыг шинээр мөрдүүлэх ажил маань үндсэндээ биелэлээ олоод байна. Улаанбаатар хотыг усаар хангадаг томоохон байгууллага бол УСУГ. Мөн орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын харьяа контор болон хувийн компаниуд, орон сууцны усан хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын үнэ тарифын асуудлыг шийдвэрлэлээ. Монголд анх удаа усны үйлчилгээний суурь хураамжийг нэвтрүүлж, үнэ тарифын тогтолцоонд шинэчлэл хийлээ. Үүнээс гадна нийслэлтэй ойролцоо байдаг Төв аймаг, Налайх, Багануур дүүргийн үнэ тарифыг шийдлээ.

**-Усны үйлчилгээний суурь хураамжийг шинэчлэх зайлшгүй шаардлага байсан уу?**

-Манай салбарт ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий 120 гаруй байгууллага, аж ахуйн нэгж 24 цагийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Зохицуулах зөвлөл өнгөрсөн сард хуралдаж, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай зөвшилцөж, орон сууц, үйлдвэр, аж ахуйн нэгжийн усны үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх шийдвэр гаргасан. Өнөөгийн бодит хэрэглээ болон цэвэр, бохир усны үйлчилгээний өртөг зардлыг хянаж үзсэний үндсэн дээр зардлаа нөхөж, хэрэглэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор энэхүү алхмыг хийсэн. Улаанбаатар хотод орон сууцны цэвэр усны төлбөр 1 л ус 48 мөнгө, бохир усны төлбөр 24 мөнгө байхаар тогтоосон. Мөн хэрэглэгчийг усаар тасралтгүй хангаж, 24 цаг бэлэн байлгахад шаардагдах зардлыг нөхөх, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах зорилгоор усны суурь хураамжийг нэвтрүүлэхээр болсон.

**-Орон сууцны өрх сард хэдий хэмжээний төлбөрийг төлөхөөр байгаа вэ?**

-Усны суурь хураамжийг Улаанбаатар хотын орон сууцны нэг өрх сардаа 2500 төгрөг төлөхөөр тогтоосон бөгөөд энэ нь хоногт 83 төгрөг, Багануур, Налайх, Төв аймагт 1800 төгрөг буюу хоногт 60 төгрөг болж байгаа юм. Харин үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр усны тариф Улаанбаатар хотод 91 мөнгөөс 1.2 төгрөг, бохир усны тариф 60 мөнгөөс 1.5 төгрөг болж нэмэгдсэн. Усны үйлчилгээний үнэ тариф улс төрөөс ихээхэн хамааралтай явж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, усны үйлчилгээний үнэ тарифыг нэг түвшинд удаан барьснаас салбарын байгууллагууд хүнд байдалд ороод байгаа. Тиймээс алдагдлын хэмжээг бууруулах, зарим газар алдагдлыг бүрэн нөхөх хэмжээнд үнэ тарифыг тогтоолгож чадлаа. Удахгүй үлдсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагын үнэ тарифын асуудлыг шийдвэрлүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байна.

**-Үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр усны тариф нэмэгдсэн үү?**

-Үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр усны тариф мөн адил өөрчлөгдсөн байгаа. Нийслэлд 91 мөнгөөс 1.2 төгрөг, бохир усны тариф 60 мөнгөөс 1.5 төгрөг, Налайх дүүрэгт 1.67-1.8 төгрөг, бохир ус 1.2-1.3 төгрөг, Багануурын цэвэр, бохир усны тариф 1.15-1.2 төгрөг, Төв аймгийнх 1.83-2.28 төгрөг болж нэмэгдсэн. Усны үйлчилгээний үнэ сүүлийн 4-9 жилд өөрчлөгдөөгүй, тогтвортой байсан. Энэ нь салбарын хэвийн үйл ажиллагаа болон үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх



болсон. Манай зүгээс тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааны өртөг, зардлыг хянаж, үйлчилгээний чанарт хяналт тавьж ажиллаж байна.

**-Усны үйлчилгээний үнэ тарифыг аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд хэрхэн хүлээн авсан бэ?**

-Нийгэмд усны үнэ цэнэ, түүний хэмнэлтийн талаар эерэг уур амьсгал бүрдсэн байна. Иргэд бараг үнэгүй шахам ус хэрэглэж байсан, цэвэр ус гэдэг тийм хязгааргүй нөөцтэй, дуусашгүй зүйл биш, цаашдаа ундны цэвэр усыг газрын гүнээс авдаг нь хумигдах нь гэсэн ойлголт бий болсон. Тиймээс энэхүү хязгаарлагдмал нөөцөө зөв зохистой хэрэглэе гэсэн хандлага олон нийтийн дунд байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч байгаа сэтгэгдэл, санал асуулгын дүнгээс зөв хөрс бүрдэж байгааг харж болно. Иргэд, олон нийтийн зүгээс усны үнэ хямд байгаа, цаашдаа нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн санал ирж байгаа. Бидний зүгээс нийгэмд хандсан усны үнэ цэнийг танин мэдүүлэх сурталчилгааг нэлээд эрчимтэй хийсэн. Энэ сурталчилгааны үр дүнд олон нийтийн дунд нийгэмд зөв ойлголт бий боллоо. Иймд усны үнэ тарифыг шинэчлэх шийдвэр гарсны дараа эсэргүүцэл, үл ойлголцол харьцангуй гайгүй байсан. Ганц нэг буруу ойлголт байсныг тухайн үед нь хэвлэл мэдээллээр залруулж байна.

**-Хүүхдүүдэд хандсан усаа ариг гамтай хэрэглэх талаарх сургалт, сурталчилгаа нэлээд идэвхтэй байна уу гэж харж байгаа. Үүний үр дүн ч гараад эхэлсэн байх.**

-Олон байгууллага нийгмийн сайн сайхны төлөө ажиллаж байна. Өнгөрсөн жил Усны үндэсний хорооноос Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад усны талаар хичээл заасан. Түүний үргэлжлэл болгож энэ жил манай байгууллага Дэлхийн усны өдрийг тохиолдуулан "Усны ухаалаг хэрэглээ ба усны хэмнэлт" гэсэн сэдвээр 40 минутын хичээлийн хөтөлбөрийг сурагчдын насны онцлогт нь тохируулан боловсруулж, Нийслэлийн 200 гаруй ерөнхий боловсролын сургуулийн 171 мянга гаруй бага, дунд, ахлах ангийн сурагчдад тус хичээлийг заасан. Энэхүү ажил уламжлал болон тогтож байна. Мөн Францын Эй Сй Эф байгууллага болон Нийтийн аж ахуйн холбооноос ч гэсэн сургалт сурталчилгааны ажлыг нэлээд идэвхтэй зохион байгуулж байгаа.

**-Усны үйлчилгээний суурь хураамж Азийн болон дэлхийн бусад орнуудад хэр өргөн хүрээтэй нэвтэрсэн байдаг вэ. Манай улс нэлээд хожуу үнэ тарифын шинэчлэл хийсэн үү?**

-Манай орны хувьд нэлээн хожуу буюу оройтож усны үйлчилгээний суурь хураамжийг нэвтрүүлж байна гэж хэлж болно. Ази болон дэлхийн ихэнх хөгжингүй орнууд суурь хураамжийг өөрсдийн онцлогт тааруулан харилцан адилгүй хэрэгжүүлж байна. Усны үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэхэд нэлээд хэмжээний зардал гардаг. Нэг

талаар үнэ тарифыг энэ зардлаа нөхөх хэмжээнд тогтоох ёстой. Гэхдээ энэ нь хэрэглэгчдэд төлж болохуйц, хүлээн зөвшөөрөгдсөн үнэ байх учиртай. Өөрөөр хэлбэл, хоёр талын тэнцвэрт байдлыг хангасан үнэ тариф гэсэн үг. Тиймээс үнэ тариф тооцоо судалгаатай, тодорхой бодлоготой байх ёстой. Усны хэрэглээнээс хамаарсан шаталсан тариф ихэнх орнуудад хэрэгжиж байна. Тухайлбал, орлоготой багатай иргэдэд зориулсан тариф байх жишээтэй.

**-Олон улсын жишгээр үнэ тарифыг тогтооходоо ямар шалгуурыг үндэслэж байна вэ?**

-Үнэ тарифын зөв бүтцийг олж тогтоох нь чухал. Олон улсад үнэ тарифын бүтэц олон жилийн турш хэрэгжээд ирсэн байна. Тиймээс тодорхой хэмжээнд гольдрилоо олсон байдаг. Ихэнхдээ усны суурь үйлчилгээг үзүүлж байгаа тухайн байгууллага гаргаж буй тогтмол зардлаа нөхөх хэмжээнд үнэ тарифыг тогтоосон байдаг. Шаталсан үнэ тарифын бүтэц ихэнх орнуудад хэрэгжиж байна. Манай улсын хувьд үнэ тарифын бүтцийг улам сайжруулах шаардлагатай. Бүтэц зөв бүрдээд ирэхээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд өртөг зардлаа нөхөх хэмжээнд хүрнэ. Ингэснээр энэ салбар санхүүгийн чадвартай болно. Хэрэглэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлж чадна. Аж ахуйн нэгж, байгууллагууд технологийн шинэчлэл хийж, шугам хоолойгоо сайжруулах эдийн засгийн боломж бүрдэх юм.

**-Шинэ үнэ мөрдөх болсноор алдагдал хэчнээн хувиар багасах тойм тооцоо байгаа вэ. Тухайлбал, бодит өөрчлөлт аль байгууллагад гарахаар байна вэ?**

-УСУГ-ын хувьд өнгөрсөн онд 11 тэрбум гаруй төгрөгийн алдагдалтай ажилласан. Энэ онд алдагдал буураад үндсэндээ 70 хувийг нь бүрэн нөхөх хэмжээнд хүрнэ. Цаашдаа байгууллагуудад өртөг зардлаа бууруулах асуудлыг нэлээн өндөр хэмжээнд тавина. Өөрөөр хэлбэл, өртөг зардлыг нь хянана гэсэн үг. Тодорхой хэмжээгээр алдагдал буураад ирэхээр алдагдалгүй ажиллах боломж бүрдэх юм. Ингэснээр элэгдлээ бүрэн байгуулж засвар үйлчилгээндээ хөрөнгө хуримтлуулна.

**-Ашигтай ажиллах нь гэж ойлгож болох уу?**

-Ашиг гэж харахаас илүү гарах ёстой зардлаа бүрэн нөхөж ажиллах юм. Манай салбарт хөрөнгө мөнгөний хомсдол байгаа. Тиймээс алдагдал багасч, хуримтлал бий болсноор тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадамжтай болох юм. Өөрөөр хэлбэл, орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа тэтгэх хэмжээнд очих нь чухал байгаа. Энэ салбар нийтийн чухал үйлчилгээний нэг хэсэг. Тиймээс бидний ажил үйлс нийгмийн чухал ач холбогдолтой төдийгүй хариуцлага өндөртэй юм. Удахгүй төсөв, гадаадын төсөл, хөтөлбөр гэхгүйгээр өөрийн хөрөнгө оруулалтаар тодорхой ажлыг бие даан хийх чадамжтай болно гэдэгт итгэж байна.

**-Ярилцсанд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье.**

Б.Баяртогтох



## ҮНЭТ ЗҮЙЛИЙН ХУРААНГУЙ БОЛ МОНГОЛОО АВЧ ҮЛДЭХ

-Олс байхад сур хэрэггүй гэсэн үзэл суртал байгаагаас үнэт зүйл саармагжих аюулд орсон Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, Хөгжмийн зохиолч Н.Жанцанноровтой уулзаж ярилцлаа.

**-XXI-зууны монголчуудын үнэт зүйл юу вэ?**

-Монголчууд тийм үнэт зүйлийг эрхэмлэх ёстой гэж таах боломжгүй. Гэхдээ төсөөлөх хэрэгтэй. Ингэж төсөөлөхийн тулд өнөөдөр ямар болсон, өчигдөр ямар байсныг сайн судалж харах ёстой. Эдийн засаг үнэт зүйлийн тодорхойлогч нь гэхээс илүү үнэт зүйлийг тогтоох эсэх тухай асуудал дээр эдийн засгийн асуудал байгаа юм. Өөрөөр хэлбэл, үнэт зүйл нь эдийн засгийн хөшүүрэггүйгээр дархлаажих, уламжлагдах асуудал хүнд. Заримдаа байгаа үнэт зүйлийг уламжилж болохоос гадна эдийн засгийн аргаар бий болгодог ч байж мэдэх.

**-Үнэт зүйлийг эдийн засгийн аргаар бүтээх боломжтой гэж үү?**

-Манайх дөрвөн толгой, таван хошуу малтай. Хонь ямаа хоёр нэг бэлчээртэй. Монгол хүний хувьд мал гэдэг үнэт зүйлийн хүрээнд ярьж болох асуудал. Монголчууд энэ үнэт зүйлээ авч ирэхдээ ямар хошуу мал нь сүргийн бүтцэд хэр хэмжээтэй байх вэ гэдгийг мянга мянган жилээр тогтоож ирсэн. Адуу, үхэр төдий, хонь ямаа тэд гээд. Харин сүүлийн жилүүдэд мал тооллогоор сүргийн бүтцэд ямаа бараг тал хувийг нь эзэлж байна. Уг нь сүргийн бүтцэд ямаа 10-15 хувийг эзэлж байсан байж магадгүй. Гэтэл ямааны ноолуур үнэтэй болоод явчихсан. Нэг кг нь 80 мянган төгрөгтэй тэнцээд ирсэн. Зах зээлийн нийгэмд энэ нь өрхийн эдийн засагтай шууд холбоотой. Тиймээс дээрх үнэт зүйлийн чиглэл өөрчлөгдөөд ямааны тоо толгой олширсон. Яагаад гэвэл ямаа ашигтай болсон учраас ямааны сүргийн бүтэц дотор эзлэх хэмжээ өссөн. Хоёр жилийн өмнө хонь өсөхгүй байсан. Өнгөрсөн жилийн тооллогоор хонины тоо толгой өссөн байна лээ. Яагаад өссөн гэхээр кг хонины ноос тутамд төрөөс 2000 төгрөгийн урамшуулал олгож эхэлсэн. Үүнээс болоод хонины тоо толгой өссөн байх жишээтэй.

**-Эдийн засгийн бодлогоор үнэт зүйлсээ дэмжих асуудлыг та хөндлөө. Энэ тухайд илүү дэлгэрэнгүй хариулт өгөхгүй юу?**

-Аливаа үнэт зүйлийг өөрчлөх боломж эдийн засагт байна. Өчигдөр, өнөөдрийн үнэт зүйлийн тухай өмнө нь би хэлсэн. Нөгөө талаар үнэт зүйлийг өөрчилдөг бас нэг зүйл нь үзэл суртал. Бид өнгөрсөн зууны 1930-аад оноос өмнө бурхны шашинтай байсан. Гэхдээ энэ нь мухар сүсэг байсан байж магадгүй. Дараа нь шашны эсрэг үзэл суртал, ухуулга хүчтэй явж, маш олон лам нар хар болохын зэрэгцээ зарим нь хороогдсон. Бурхны шашныг шүтэхийг хүртэл хатуу хориглосон



байдаг. Ингээд шашингүй 40, 50 жил болсон. Энэ нь шашин хүний оршихуйн нарийн үнэт зүйлүүдийг хадгалж байсан юм байна гэдгийг ухаараагүй байсан үе юм уу даа. Харин 1990 оноос эргээд бурхны шашныг сэргээж эхэлсэн. Бурхан номоо шүтэх болсон чинь түүнийгээ хэрхэн хэрэглэдэг соёлоо алга болгосон байсан. Одоо шашин сэргэж байгаа юм шиг мөртлөө үнэн чанартаа шашнаа ч хүн хэрэглэж чадахгүй, шашин нь ч хүнд хэрэг болохгүй. Ингээд үнэт зүйл бүдгэрсэн. Шашинтай мөн адил уламжлалт арга ухаан ч заримдаа зөрчилдөж байна. Олс байхад сур хэрэггүй гэсэн үзэл суртал байгаагаас үнэт зүйл саармагжих аюулд орсон.

**-Манайд үзэл суртал одоо бий юу?**

-Аливаа нийгэм үнэт зүйлээ хадгалж хамгаалж, өв тэгш байя гэвэл дээрх хоёр асуудалд болгоомжтой хандах ёстой гэдэг нь мэдрэгдэж байна. Одоо үзэл сурталын асуудал зөөлөрч, хүчтэй давалгаа үүсэх нь гайгүй болсон. Үзэл суртлаас болоод үнэт зүйл өөрчлөгдөх байх гэсэн болгоомжлол одоохондоо төрөхгүй байна. Гэхдээ дэлхий бөөрөнхий. Ямар ч бодлого хэзээ ч юм ороод ирэхийг үгүйсгэх аргагүй. Саяхан л бүрэн эрхт байсан Украин өнөөдөр ямар хүнд байдалд орсон билээ. Энэ бол маргаашийг төсөөлж болохоос тогтоож болдог зүйл биш гэдэг нь харагдаж байгаа юм.

**-Бусад орны явсан зам, туулсан түүхийг бид давтах уу эсвэл түүнээс ухрах уу?**

-Дэлхийн хөгжил одоогийнх шигээ урагшаа явна гэвэл монгол хүний үнэт зүйл юу байх талаар төсөөлөн ярьж болно. Гэхдээ тэр төсөөлөл даяаршилд өртөж байна. Нэг улс даяаршилд автахгүй, тусгаар байна гэж үзэж ярьж, үлдэж болно. Тэглээ л бол хоцорлоо. Энэ бол асуудал. Тиймээс өөрийн эрхгүй энэ даяаршилд орно. Яагаад гэвэл хүн жаргалтай сайхан амьдрахын тулд аль



болох тэр жаргалыг бага цагт бүтээмж өндөртэй хүртэх шаардлага гардаг. Энэ нь ямар ч аргагүй. XIII-зууны үед нум сум байсан бол энэ зуунд сумнаас хурдан интернет, технологи байна. Үүнээс гадуур өнгөрөх юм бол хоцорлоо. Тиймээс бид зэрэг уламжлал, соёлоо авч явах ёстой. Өөр арга байхгүй.

#### **-Өөр сонголт байхгүй юу?**

-Орчлон дээр тэнгэрээс бусад нь мөнх биш гэсэн нэг үзэл яваа. Хэрвээ тэр үзлээр явах юм бол даяаршил гэдэг зүйл мөнх бус болж таарна. Харин одоо өгөгдөөд буй замаар явбал бүгдээрээ ижил болно. Энэ чинь даяаршил. Унадаг унааг унана, галт тэргээ хурдлуулна. Сансарт ниснэ. Галт тэргээ улам хурдлуулна. Төмөр зам дээгүүр явж байгаад нисдэг болно. Ингээд л яваад байна. Ингээд явж байтал даяаршил дуусчихлаа гэж үзвэл хэнд хожоо ирэх вэ. Хэн эндээс хожих вэ. Хэн өөрөөрөө үлдсэн нь хожино. Өөрийгөө авч үлдсэн нь хожино. Өөрийг "алсан" нь хохирно. Тиймээс үүнд бэлэн байхын тулд монгол хүн ертөнцийг хэрхэн үздэг билээ. Мөн хэрхэн орших аргаа боловсруулдаг. Ямар уламжлалтай байсан. Энэ бүхнээ тээж авч хоцрох тухай асуудал үнэтэй үнэт зүйлс нэг гэж ойлгож болно.

Занабазарын урласан бурхныг музейд заалаад хүнд өгөхгүй байна гэхээс илүү монгол хүн байж чадаж байна уу гэдэг асуудал үнэн чанартаа тодорхойлогч нь болно. Бүгдээрээ англи хэлээр ярьж байна. Нэг өдөр энэ гадаад хэлээр ярихаа больчихвол яах вэ. Тэгэхээр монголоороо ярьж байвал, монголоороо үлдэж байна гэж нэг талаас нь харж болох юм. Нэг өдөр дэлхийн бүх шатахуун дуусчихлаа гэж бодъя. Бүх цахилгаан станц зогсчихлоо. Нэг өдөр эдгээр эрсдэл гарахыг үгүйсгэх аргагүй. Одоо морио унаж чаддаг байх хэрэгтэй. Тэгэхгүй бол цөмөөрөө явган явна. Морьтой үлдэх хэрэгтэй. Эмээл хазаартай үлдэх хэрэгтэй. Тэгж л чадвал ямар ч асуудал байхгүй бидний гарт ялалт байна. Үнэт зүйлийн хураангуй бол Монголоо авч үлдэх юм.

#### **-Монголоо авч үлдэнэ гэхээр хоцрох эрсдэл байгааг та хэлсэн. Одоо яах вэ?**

-Ухарлаа л бол хоцорлоо гэж дээр хэлсэн. Бид техник эзэмшиж, эрчим хүчийг зөв ашиглаж, инженерийн ухаанд суралцахгүй бол хүний гарт орно. Үүнийг яаж тэнцвэрцүүлэх вэ. Энэ нь улс төрийн болоод эдийн засгийн асуудал болж байгаа юм. Монголоо авч үлдэнэ гэхээр ертөнцийн хүмүүсийн хүрсэн амжилтаас ухарна гэж ойлгож болохгүй. Бүхнийг хамтад нь аваад явах боломжтой. Уртын дуу, морин хуур монголчуудын үнэт зүйл. Мөн морь уургалах, гүү саах хүртэл үнэт зүйлийн нэг хэсэг нь. Тиймээс бүгдийг танд нарийн тоочсонгүй.

#### **-Үнэт зүйлийн тээгч нь хэн бэ?**

-Өнөөдрийн малчин нүүдлийн соёлын тусгал мөн үү гэвэл мөн. Гэхдээ сүүлийн жилүүдэд, тэр тусмаа зах зээлийн нийгэмд энэ байдал хувьсан өөрчлөгдөж хувирч байгаа. Төрийн ихэс дээдсээс авхуулаад урлагийн бид хүртэл дэлхий дээр нүүдэлчин соёлоо хадгалж үлдсэн цорын ганц орон гэж амаа цангатах яриад байдаг. Дэлхийд нүүдлийн соёлоороо ийм гайхамшигт бүтээсэн, нүүдлийн соёлыг хадгалж байгаа гэж хэлдэг. Гэтэл нүүдлийн соёл малчин хүнд байна уу, үгүй юу.

Үүнийг эргэж бодох цаг болсон.

Хөдөө мориор малаа хариулж байгаа малчин хэд байна вэ. 100 км-т хоёр литр бензин иддэг мотоцикль байхад түүгээр олонх нь малаа хариулж байна. Малчдын амьжиргаа сайжирч байгаа. Тэмээгээр нүүх ямар ч шаардлага алга. Айл болгоны гадаа Портер машин зогсож байна. Тэмээгээр нүүхгүй юм бол сураар яах юм. Морио унахгүй бол хазаар ногт эмээлээр яах юм. Одоо ийм болж хувирч байна. Манай малчид нүүдлийн соёлыг хадгалж байна уу. Зүгээр орчин цагийн зах зээлийн нэг жижигхэн үйлдвэрлэгч амь зуугч болж байна уу гэдгээ бодох ёстой. Үүнийг соёл урлагийн нэгэн хүн ингэж хэлээд засна гэж хэзээ ч байхгүй.

Би одоо хөдөө очоод та мотоциклоо боль, мориороо хонио хариул. Та портероор яах юм, тэмээгээр нүү гэж хэлээд хэзээ ч бүтэхгүй. Ийм эрх ч байхгүй. Хом байхгүй. Тэмээний хом бамбай байлгах хэрэггүй. Яагаад гэвэл хом бамбай байлгах гэж ноосоор эсгий хийснээс түүнийгээ тушаагаад кг тутамд нь 2000 төгрөг авах нь илүү чухал болсон. Хом бамбай байхгүй юм чинь тэмээгээр яах юм. Бид нүүдлийн соёлын үнэт зүйлээсээ хариугүй хагацах дээрээ тууллаа.

#### **-Тэгвэл үнэт зүйлээ хадгалах нь хэний үүрэг вэ?**

-Жуулчны баазуудад очиж морь унаж, тэмээ унаж байгаа чинь соёл хадгалж байгаа зүйл биш. Мөнгө олж байгаа хэрэгсэл. Тэгэхээр нүүдлийн соёлын үнэт зүйлийг орчин цагийн бенз машинтай давхар аваад явуул бидэнд хожоо ирнэ. Давхар аваад яв гэхээр миний үгэнд малчид чинь орохгүй байна. Харин төрийн бодлогын үгэнд орж байна. Засаг ноолуурынхаа үнийг нэмчихээр ямаагаа олон болгож байна. Ноосонд 2000 төгрөгийн урамшуулал олгоно гэхээр хонио өсгөж байна. Тэгэхээр үнэт зүйлийн тухай асуудлыг ярихын тулд эх орны тухай, хайр энэрлийн тухай лекц уншаад явахгүй нь ойлгогдож байгаа юм. Лекц сонсож гараад тухайн хүнд дэлгүүрийн тал авах асуудал бодогдож байгаа. Өөр арга байхгүй. Бид нар ямар нийгэм байгуулж байгаагаа ухаарах ёстой. Одоогийн нэг гажуутай тал нь социализмээс өөр нийгэм байгуулж байгаа мөртлөө социалист аргаар хандаж байна.

Малчдыг уламжлалт соёлоо хадгалсан, хадгалах ёстой гэж хараад байна. Энэ чинь тэдний юун үүрэг юм бэ. Үнэт зүйлийг авч хоцорье гэвэл одоо засаг төр тогтолцоо боловсруулах учиртай. Энд дахиад урамшууллын асуудал гарч ирж байна. Эдийн засгийн аргаар үнэт зүйлээ барихаас өөр аргагүй. Төр засаг яаж малчдаас түүхий эд, ноос ноолуурыг нь авах вэ гэсэн бодлого явуулж байна. Харин уртын дуугаа хадгалах уу. Унаа малаа унаж сур ногтоо хийх үү гэдэгт анхаарахгүй байна. Бодит байдал ийм байхад уламжлал гэж ярих нь зохимжгүй. Үнэт зүйл нийгэм, эдийн засгийн асуудалтай холбоотой. Түүнээс үнэт зүйлээ хадгалж явах нь монгол хүн болгоны үүрэг гэж орхиж болохгүй. Байхгүй болох гээд байхад нь байгаа гээд дэлхий даяар ярина. Маргаашийн тухай бодож л байгаа бол өчигдөрөөс өнөөдөр лүү орж ирэхэд юу болоод байна вэ. Үүнийгээ эргэж харах ёстой. Зах зээлийн нийгэмд эдийн засгийн аргаар үнэт зүйлээ авч үлдэх л хэрэгтэй байна.

Б.Баяртогтох



**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:**

“МОНТС” ХХК-нь 2004 оны 9-р сард орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний чиглэлээр ажиллахаар үүсгэн байгуулагдсан. Үйл ажиллагааны хүрээнд БГД-т 14 байрны 1400 өрх, 3500 гаруй хүн ам, БЗД-т 8 байрны 430 өрх 1000 гаруй хүн амын ая тухтай амьдрах нөхцлийг хангах зорилгоор 2 хэсэгт ус, дулааныг 24 цагаар тасралтгүй дамжуулан түгээх, бохир усыг татан зайлуулах, сантехник, цахилгааны гэмтлийг шуурхай засварлах үйлчилгээг үзүүлдэг.

Салбартаа хувийн хэвшлийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, салбараа хөгжүүлэх үйл ажиллагаанд нэгдэн 2008 онд МНААҮХолбооны 54 дэх гишүүн байгууллагаар бүртгүүлсэн. Мөн УБ хотын Хувийн ОСНАА-н Хөгжлийн төвийн үүсгэн байгуулагчдын нэг.

Манайх орон сууцны инженерийн шугам сүлжээний халаалт, цэвэр усны 22 ялтаст цогц төхөөрөмж бүхий үзель, халаалт, халуун усны 8100 у/м шугам, цэвэр усны 6680у/м шугам, ариутгах татуургын 23000 у/м шугам, ариутгах татуурга, дулааны 53 худаг, цахилгааны 22 шитийг хариуцан ажилладаг.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Хэрэглэгчдээ эрхэмлэн дээдэлж, эрэлт хэрэгцээг нь бүрэн хангасан үйлчилгээг нэвтрүүлэх, шинэ техник технологийн ололтод тулгуурлан, мэргэжилтэй боловсон хүчнийг нэгтгэн НАА-н хөгжлийг бүтээх үйлсэд бодитой хувь нэмэр оруулах, харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн шилдэг түнш нь байх.

**ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

Бид өнгөрсөн хугацаанд ажиллахдаа шугам сүлжээний засвар хангалуулж цаг хугацаандаа гүйцэтгэн, харилцагч байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу төлбөрийг хугацаандаа барагдуулж өр үүсгэлгүй ажиллаж олон харилцагч байгууллагын хүндэт өргөмжлөлөөр шагнагдсан билээ.





### МАНАЙ ХАМТ ОЛОН:

Бид удирдах ажилтан -3, инженер техникийн ажилтан-6, засварчин-9, цахилгаанчин -2, ашиглалтын байцаагч-4 зэрэг ажлын дадлага туршлагатай мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн. Нийт ажилчдын 70% нь 20-40 насны залуучууд ажилладаг. Бидний дунд ажил мэргэжлээрээ бусаддаа үлгэр дууриалал болсон олон сайхан ажилчид бий.



Ашиглалтын байцаагч Б.Хувьзаяа, Засварчин Б.Олзбаяр, П.Мөнхбаатар, Б.Буяннэмэх нар нь ажил хөдөлмөрийн оны шилдэгүүд болно.



Засварчин Ганболд нь энэ салбарт 17 жил ажиллаж байгаа туршлагатай засварчин бөгөөд залуу засварчдад өөрийн арвин туршлагаасаа зааж сургадаг, урлагын авьяастай тэргүүний ажилтан болно.



Мөн нягтлан Б.Ичинноров волейболын спортын мастер. Эдгээр ажилчдаараа бид бахархдаг.

### ОЙГОО УГТСАН БҮТЭЭЛЧ АЖЛУУД:

2013-2014 оны засварын ажлаар 2 байрны 120 өрхийн халаалтын дотор босоо стекийн 970у/м шугамыг шинэчилэн сольсон, 43/А байрны дулааны 120у/м шугамыг шинэчилэн сольсон, халуун усны циркуляцийн насос -2ш , хүйтэн усны өргөлтийн насос 3ш,37/А байрны гадна бохирын Ф-200-ын 20у/м шугам сольсон, Цахилгааны ерөнхий шитний шинэчлэл, айл өрхийн давхар дундын шит шинэчлэх зэрэг бүтээлч ажлуудыг ерөнхий инженерийн удирдлаган доор цаг хугацаанд нь хийж ирсэн. 11 СӨХ-тэй гэрээтэй, ажил үйлчилгээгээ хамтран явуулж байна.

Ойгоо угтан харилцагч “Тэнгэр” СӨХ-д бүтээлч ажлын хандив өргөн, оршин суугч 10-н ахмад буурлуудад орон сууцны төлбөрийг 1 жил 100% чөлөөлөх үйл ажиллагаануудыг явуулсан.

37/А байрны Ф200-ын 20у/м бохирын шугам солих ажил



## ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН  
ЗҮҮНДЭЛГЭР БАГИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫГ  
ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААНААР ХАНГАСАН АЖИЛ,  
ТҮҮНИЙ ҮР ДҮН



#### 1. СУДАЛГАА

“Ирээдүй” Цэцэрлэг

Тус объект нь хоёр давхар, халаах нийт талбай  
1120 м.кв.

1994 онд сургуулийн дотуур байрны  
зориулалтаар баригдсан. Судалгааны явцад  
барилгын цонх хаалгаар дулааны алдагдал маш  
ихтэй байсан.

#### 2. ДУЛААНЫ НАСОСНЫ СОНГОЛТ

Виессманн /Viessmann / компаний Natura  
BWH 280 маркын 90кВт дулаан гаргах чадвартай  
Хөрс-Усны төрлийн дулааны насосыг тооцооны  
дагуу дагалдах тоног төхөөрөмжийн хамт сонгосон.



#### ЭРХЭМ ЗОРИЛТ

- БҮХНИЙГ БҮТЭЭГЧ  
ХҮН ТАНЫ АЯ  
ТУХТАЙ АЖИЛЛАЖ  
АМЬДРАХ НӨХЦӨ-  
ЛИЙГ БҮРДҮҮЛЭХИЙН  
ТӨЛӨӨ УС, ДУЛААН,  
АРИУТГАХ ТАТУУР-  
ГААР ҮЙЛЧИЛНЭ.



PE хоолойн холболт хийсэн шуудуу /2 м гүн/



ГАЗРЫН ГҮНИЙ ДУЛААНЫ НАСОС



НАРНЫ КОЛЛЕКТОРЫН УГСРАЛТ



### УСНЫ ҮНЭ ЦЭНЭ

Ус хомсдоноос дэлхий дээр өдөрт 14 мянган хүн (түүний 11 мянга нь таваас доош насны хүүхдүүд) нас барж байна. 2050 он гэхэд 48 орны хоёр тэрбум хүн усаар гачигдана.

Нэг талаас манай гаригийн усны нөөцийн 98 хувь нь давстай, нэг хувь нь туйлын мөсний дор бол мөн нэг хувь нь гол нуур, газрын дорх буюу ашиглаж болох цэнгэг ус аж.

Орон сууцныхан цэвэр усаар хоол ундаа хийж, хог шороогоо цэвэрлэж, машин тэргээ угааж, жорлонгоо ч зайлдаг учир өдөрт нэг хүн 276 литр ус хэрэглэдэг нь өндөр хөгжилтэй орны том

хотынхоос 2-3 дахин илүү хэрэглэдэг аж.

Харин гэр хорооллынхон усаа худгаас өөрсдөө зөөдөг тул өдөрт нэг хүн 8-10 литр ус хэрэглэж байгаа тооцоо байдаг.

Эвдэрхий цоргоор долоо хоногт 90 литр, жилд 4680 литр ус алддаг гэх тооцоо бий.

Нэг айл нийт хэрэглэж буй усныхаа 50 хувийг бие засах газарт, 21 хувийг хоол унданд, 20 хувийг хувцас угаах, долоон хувийг цэвэрлэгээнд зарцуулдаг юм байна.

Европын орнуудад нэг тонн усны үнэ дунджаар 5-6 евро байдаг гэнэ. Монгол Улсад нэг литр усыг дунджаар гэр хорооллын иргэдэд нэг төгрөгөөр, орон сууцныханд 32 мөнгөөр нийлүүлж байна. Үйлдвэр, аж ахуйн газрууд 55 мөнгө төлдөг.

Гэтэл АНУ-д нэг тонн усны үнэ доод тал нь 5 ам.доллар байх жишээтэй. Нөгөөтэйгүүр дээрх орнууд усны асар их нөөцтэй ч үнэлгээнд нь ийнхүү анхаарч байдаг.

Манай улсад ус хэрэглэсний төлөө хамгийн их мөнгө төлдөг нь уул уурхайнхан. Хэдий өндөр гэж байгаа ч энэ салбарынхан газрын гүнээс ус авч хэрэглэвэл тонн тутамд нь ердөө 959 төгрөг төлдөг аж.

Манай улсад хэрэглэж буй (БНХАУ-аас оруулж ирдэг) суултуурын усыг татахад дунджаар 13 литр ус зарцуулдаг бол Европын стандарт 3-5 литр байдаг.

Орон сууцны айл нэг тонн бохир усанд ердөө 230-хан төгрөг төлдөг.

2013 онд 2012 оны усны хэрэглээнээс 20000 м3-ээр бага ус олборлон түгээсэн байгаа нь манай хэрэглэгчдийн усны зөв зохистой хэрэглээг хэрэгжүүлж байгааг харуулсан бодит үр дүн юм.

Манай байгууллагын ус олборлолтын зардал 2012 онд 2780 төгрөг байсан бол 2013 онд 3250 төгрөг болж өссөн ч зөврийн усан сангаар 1 литр усыг 1 төгрөг 50 мөнгөөр инженерийн шугам сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд 1 хүнд сард 1200 төгрөгөөр борлуулж байна.

Дулааны эрчим хүчний зардал шингэсэн 1 литр усны үнэ 2012 онд 419 төгрөг байсан бол 2014 онд 653 төгрөг болж өссөн.

Усны олборлолт болон дулаан үйлдвэрлэлийн гол зардал болох цахилгаан, нүүрс, шатахуун, цалингийн зардал өсч буйтай уялдаатай юм.

ТӨВ ЧАНДМАНЬ-ДЭХГазар



## УС ХЭМНЭВЭЛ ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЖ, УРАМШУУЛНА



Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан гадаргын усны шоометр тутамд экологи, эдийн засгийн үнэлгээний 10, газрын доорхи усны шоометр тутамд экологи эдийн засгийн үнэлгээний 20 хувиар төлбөр тооцохоор болжээ. Түүнчлэн барилгын суурийн хөрсний усыг шавхан зайлуулсан тохиолдолд гадаргын усанд 10 хувиар /экологи эдийн засгийн үнэлгээний/, газрын доорхи усанд 15 хувиар тооцож төлбөр тогтоогоод байгаа юм.

Усны нөөцийн төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай Засгийн газрын тогтоол 2013 оны есдүгээр сарын 21-нд гарсан билээ. УИХ-аас 2012 оны тавдугаар сарын 17-нд баталсан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Усны тухай, Татварын ерөнхий хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ, хөнгөлөлтийг шинэчлэн тогтоосон юм.

Тогтоолын зорилго нь усны үрэлгэн хэрэглээг хязгаарлаж, нөөцийг зүй зохистой, үр ашигтай хэрэглэхэд чиглэж буй, Түүнчлэн бохирдлыг бууруулах, цэвэршүүлэх чиглэлээр дэлхий нийтэд хэрэглэж буй

дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулахад хөрөнгө оруулалт хийх зорилготой юм.

Усыг хэмнэлттэй ашиглах санхүүгийн механизмыг боловсронгуй болгохын тулд усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг бүс нутгийн онцлог, сав газар бүрээр тооцон тогтоосон байна. Тодруулбал, усны нөөцийн экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үнэ цэнийг Монгол орны усны 29 сав газар тус бүрээр тогтоож бодит хэрэглээнд ойртуулах, түүнийг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг механизмыг бий болгожээ. Мөн усны нөөцийг хэмнэх, дахин ашиглах эрх зүйн орчин бий болгох, нөөцийн үнэлгээг нэмэгдүүлж, гадаргын ус, хур тунадасны усыг хуримтлуулан ашиглах бүхий л боломжийг бүрдүүлж байгаа аж.

Түүнчлэн усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг огцом нэмэгдүүлэхгүйгээр тогтоож, мөн хуульд заасан нөхцлөөр усыг хэмнэлттэй ашигласан тохиолдолд хөнгөлөлт үзүүлж, урамшуулдаг болсон байна. Тухайлбал, хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашиглах тохиолдолд эргүүлэн ашигласан хэмжээгээр нь төлбөрөөс хөнгөлөх юм.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 326

### УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ, ХӨНГӨЛӨХ ТУХАЙ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15.3, 20.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ”-г 1 дүгээр, “Усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь, хэмжээг”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг усны сав газар тус бүрээр тогтоож мөрдүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 351 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Байгаль орчин, ногоон  
хөгжлийн сайд

С.ОЮУН

Засгийн газрын 2013 оны 326 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

#### УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

№	Төлбөр ногдох ус	Төлбөрийн хувь хэмжээ (экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар)	
		Гадаргын усанд	Газрын доорхи усанд
1.	Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоомер тутамд	-	-
2.	Хүнд үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоомер тутамд Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн	10	20
3.	зориулалтаар ашигласан усны шоомер тутамд	10	20
4.	Авто зам, засварт ашигласан усны шоомер тутамд	10	20
5.	Хөнгөн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоомер тутамд	10	10
6.	Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоомер тутамд:		
	а) архи, пиво, согтууруулах ундаа	10	20
	б) ундаа, цэвэр ус	10	10
	в) талх, чихэр, нарийн боов, бусад	1	1
7.	Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоомер тутамд:		
	а) ашигт малтмал олборлох, баяжуулах	10	20



б) зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	10	20
в) усыг шавхан зайлуулах	10	15
г) эрэл, хайгуулын өрөмдлөг хийх	10	20
8. Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар		
ашигласан усны шоометр тутамд	10	15
Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны		
9. шоометр тутамд	1	10
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл,		
10. үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага,	10	15
иргэний ашигласан усны шоометр тутамд		
		Үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс тооцох төлбөрийн хязгаар (хувиар)
		Гадаргын усанд
Усан цахилгаан станц, усан замын тээврийн		
11. үйлчилгээ эрхлэх		5
12. Усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, аялал зугаалга, усан спортын байгууламж		1

Тайлбар:

1. Барилгын суурийн хөрсний усыг шавхан зайлуулсан тохиолдолд хүснэгтийн 7в-тэй адил тооцно.
2. Энэхүү хавсралтын 10-т заасан ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны төлбөрийг усаар хангагч байгууллага тооцож авна.

Засгийн газрын 2013 оны 326 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

### **УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨЛӨХ ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Ус ашиглах зориулалт	Усны нөөц ашигласны төлбөрөөс хөнгөлөх хувь	
	Усны эх үүсвэр	
	Гадаргын ус	Газрын доорхи ус
1 Унд, ахуйн зориулалтаар усны эрдэжилт, хатуулгыг нь цэнгэгжүүлж зөөлрүүлэн ашигласан	100	100
2 Ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах болон ургамал тарьж ургуулах замаар байгалийн баялгийг нөхөн сэргээх	99	99
3 Хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашиглах тохиолдолд тухайн хэмжээгээр	эргүүлэн ашигласан хэмжээгээр	
4 Цас, бороо, үерийн усыг хуримтлуулж мал аж ахуй, газар тариалангийн зориулалтаар ашигласан	99	-



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 5 сарын 17 өдөр

"Төрийн мэдээлэл", 2012 он. № 22

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж

2.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."төсөл" гэж шинээр байгуулах болон ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, үүл үүрхэй, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх зэрэг аливаа үйл ажиллагааг;

3.1.2."төсөл хэрэгжүүлэгч" гэж тухайн төслийг хариуцагч иргэн, хуулийн этгээдийг;

3.1.3."байгаль орчны стратегийн үнэлгээ" гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, байгалийн гамшигт үзэгдэлтэй уялдуулан тодорхойлохыг;

3.1.4."байгаль орчны төлөв байдлын үнэлгээ" гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг;

3.1.5."хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ" гэж тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

3.1.6."байгаль орчны нөлөөллийн үнэлгээ" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;

3.1.7."үнэлгээний шинжээч" гэж энэ хуулийн 3.1.6-д заасан үнэлгээ, үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх бүхий этгээдийг;

3.1.8."үнэлгээний шинжилгээ" гэж энэ хуулийн 3.1.6-д заасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлыг холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, тайлан, дүгнэлт үндэслэлтэй, зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

3.1.9."хянан магадлагаа" гэж батлагдсан байгаль



орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт үнэн зөв эсэхэд мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

3.1.10. “эрсдэлийн үнэлгээ” гэж хүн, амьтан, ургамал болон байгаль орчинд хими, биологи, физикийн хүчин зүйлээс үзүүлж болзошгүй нөлөөлөл, мөн байгалийн гамшигт үзэгдлийн нөлөөллийг урьдчилан тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.11. “биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БҮТЭЦ, ТОГТОЛЦОО, ЗОХИЦУУЛАЛТ**

### **4 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ**

4.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт дор дурдсан үнэлгээ хамаарна:

4.1.1. байгаль орчны стратегийн үнэлгээ /цаашид “стратегийн үнэлгээ” гэх/;

4.1.2. байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /цаашид “төлөв байдлын үнэлгээ” гэх/;

4.1.3. байгаль орчны нөлөөллийн үнэлгээ /цаашид “нөлөөллийн үнэлгээ” гэх/;

4.1.4. хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ.

4.2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг зохицуулах, энэ хуулийн 4.1.1, 4.1.4, 7.1.2-т заасан үнэлгээний үр дүн, тайланд дүгнэлт өгөх, үүрэг бүхий байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөл /цаашид “мэргэжлийн зөвлөл” гэх/ ажиллана.

4.3. Мэргэжлийн зөвлөлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилон ажиллуулна.

### **5 дугаар зүйл. Байгаль орчны стратегийн үнэлгээ**

5.1. Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийлгэж, Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө уг үнэлгээний тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.2. Стратегийн үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор хийж тайлан гаргана.

5.3. Стратегийн үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний талаарх нарийвчилсан журмыг Засгийн газар батална.

5.4. Стратегийн үнэлгээний тайланг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт танилцуулна.

5.5. Төслийг хэрэгжүүлэгч салбарын яам болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээний дүгнэлтийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлж, өөрийн цахим хуудсанд байрлуулах бөгөөд хэвлэмэл хувилбартай танилцах боломжийг бүрдүүлнэ.

### **6 дугаар зүйл. Төлөв байдлын болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ**

6.1. Төсөл хэрэгжүүлэгч нь энэ хуулийн 3.1.4-т заасан үнэлгээг хийлгэж, болзошгүй нөлөөллийг судалсан байна.

6.2. Төлөв байдлын үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулна.

6.3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд энэ хуулийн 3.1.5-д заасан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийнэ.

6.4. Шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 6.3-т заасан үнэлгээ хийхэд мэргэжлийн баг томилж болно.

6.5. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажилд шаардагдах зардлыг нөлөөллийн цар хүрээг харгалзан төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулна.

6.6. Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.

### **7 дугаар зүйл. Нөлөөллийн үнэлгээ**



7.1.Нөлөөллийн үнэлгээ нь дараах үнэлгээнээс бүрдэнэ:

7.1.1.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ;

7.1.2.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.

7.2.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах,газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.

7.3.Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.

7.4.Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, байгалийн нөөц ашиглах төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг үнэлгээний шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах дүгнэлт гаргана:

7.4.1.техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах;

7.4.2.төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;

7.4.3.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэх.

7.5.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 7.4-т заасан хугацааг энэ хуулийн 7.6-д заасан ерөнхий шинжээчийн шийдвэрээр 14 хоногийн хугацаагаар нэг удаа сунгаж болно.

7.6.Үнэлгээний шинжээч болон тэдгээрийн үйл ажиллагааг удирдан зохицуулах ерөнхий шинжээчийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилно.

7.7.Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан

магадлага болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана.

## **8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ**

8.1.Энэ хуулийн 7.4.3-т заасны дагуу гарсан дүгнэлтэд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, хугацааг тодорхой заана.

8.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

8.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана:

8.4.1.төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал;

8.4.2.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн;

8.4.3.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж;

8.4.4.төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмж;

8.4.5.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ;

8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;

8.4.7.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд;

8.4.8.төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл;

8.4.9.төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой уялдсан бусад асуудал.

8.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төсөл хэрэгжүүлэгчээс албан ёсоор санал авна.

8.6.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.



8.7.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь хээрийн судалгааны анхдагч материал, үнэлгээний мэргэжилтний судалгааны ажлын дүнг эх хувиар нь хадгалах бөгөөд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг дөрвөн хувь бэлтгэж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэгч болон төсөл хэрэгжих сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт тус бүр нэг хувийг өгч, нэг хувийг өөртөө үлдээх бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна.

8.8.Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

### **9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

9.1.Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.

9.2.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.

9.3.Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.

9.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах болон нөхөн сэргээлт хийх журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нөхөн сэргээлтийн стандартыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус тус батална.

9.5.Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.

9.7.Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх

арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

9.8.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

9.9.Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

9.10.Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

9.11.Төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлага болон уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, энэ хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн энэ хуулийн 9.10-т заасан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгоно.

9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.

9.13.Шаардлагатай тохиолдолд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын шийдвэрээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл болон энэ хуулийн 9.12-т заасан хяналтын дүнд хөндлөнгийн хяналт хийж, дүгнэлт гаргах бөгөөд уг ажилд шаардагдах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

9.14.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ



хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12,9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ хуулийн 9.15-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

9.15.Энэ хуулийн 9.9,9.10-т заасан байгаль орчныг хамгаалах,нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

### **10 дугаар зүйл.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинжилгээ**

10.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж нь ерөнхий үнэлгээнд заасан хугацаанд үнэлгээний ажлын тайланг холбогдох бусад бичиг баримтын хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

10.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсан шинжээч ажлын 18 өдөрт багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч уг тайланд үнэлгээний шинжилгээ хийх шинжээчдийн баг томилно.

10.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч энэ хуулийн 10.2-т заасан хугацааг 18 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.

10.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн долдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

### **11 дүгээр зүйл.Хянан магадлагаа**

11.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж,байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадлагаа хийнэ.

11.2.Хянан магадлагааны дүгнэлт гаргах хугацааг

байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч тогтоож, холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тухай бүр ажлын хэсэг томилон ажиллуулна.

11.3.Хянан магадлагаа хийхэд шаардлагатай зардлыг үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хариуцах бөгөөд хянан магадлагааны дүгнэлтийг үндэслэн буруутай этгээдээр уг зардлыг нөхөн төлүүлнэ.

11.4.Хянан магадлагаа хийхэд шаардагдах баримт бичгийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж болон төсөл хэрэгжүүлэгч нар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад саадгүй бүрдүүлж өгнө.

11.5.Хянан магадлагаагаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдвол уг ажлыг зохих шаардлагын түвшинд хүртэл дахин хийлгэж, энэ хугацаанд бусад төсөлд нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлнэ.

11.6.Хянан магадлагаагаар нэмэлт ажил хийх шаардлагатай нь тогтоогдвол холбогдох зардлыг анх нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж хариуцна.

### **12 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх олгох, хүчингүй болгох**

12.1.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6-д заасан тусгай зөвшөөрлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын аж ахуйн нэгжид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

12.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргасан байна:

12.2.1.аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тухай танилцуулга;

12.2.2.үнэлгээний ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан,материаллаг бааз,боловсон хүчний хангамж болон чадавхийг илтгэх бичиг баримтууд.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу өргөдөл гаргасан аж ахуйн нэгжийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх чадварыг мэргэжлийн зөвлөл ажлын 28 өдөрт багтаан шалгаж, дүгнэлт гаргана.

12.4.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд



үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

12.5.Аж ахуйн нэгжид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гурван жилийн хугацаатай олгоно.

12.6.Аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн хугацаа дуусахаас хоёр сарын өмнө эрх сунгуулахыг хүссэн өргөдлөө гүйцэтгэсэн ажлын тайлангийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

12.7.Энэ хуулийн 12.6-д заасан өргөдөл болон тайлан, байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон бусад мэдээллийг мэргэжлийн зөвлөл хянан үзэж,байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн хугацааг сунгах эсэх талаар дүгнэлт гаргана.

12.8.Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр гурван жилээр сунгана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

### 13 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн эрх

13.1.Төсөл,хөтөлбөр хэрэгжүүлэгч дараах эрх эдэлнэ:

13.1.1.стратегийн болон нөлөөллийн үнэлгээ хийлгэх хүсэлтээ эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжид тавих;

13.1.2.төлөв байдлын,стратегийн болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх аж ахуйн нэгжийг сонгох;

13.1.3.тухайн бодлого,хөтөлбөр,төлөвлөгөө,төслийн техник, технологи, бизнесийн холбоотой зарим шаардлагатай мэдээллийг нууцлахыг стратегийн болон нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх аж ахуйн нэгжээс шаардах.

### 14 дүгээр зүйл. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг

14.1.Стратегийн үнэлгээнд хамрагдах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч дараах үүрэг хүлээнэ:

14.1.1.бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд хийх стратегийн болон төслийн нөлөөллийн үнэлгээтэй

холбогдол бүхий баримт бичгийг эрх бүхий байгууллага,албан тушаалтанд гаргаж өгөх;

14.1.2.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж,тайлагнах;

14.1.3.газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт,хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны өмнө боловсруулж,тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч,байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.

### 15 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн эрх

15.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж дараах эрх эдэлнэ:

15.1.1.байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажилд шаардлагатай баримт бичгийг төсөл хэрэгжүүлэгчээс гаргуулан авах;

15.1.2.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд ажлын байранд саадгүй нэвтрэн орох, сорьц, дээж авах;

15.1.3.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнг тусган боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд төслийг үргэлжлүүлэх эсэх талаарх дүгнэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тавих.

### 16 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгжийн үүрэг

16.1.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж дараах үүрэг хүлээнэ:

16.1.1.урьд хийгдсэн шинжилгээ, судалгааны дүгнэлтийг ашиглаж болох бөгөөд түүнийг тодотгох холбогдох чиглэлээр нэмэлт судалгаа хийх;

16.1.2.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд хийсэн шүүмжийн дүгнэлтийн дагуу нэмэлт,өөрчлөлт оруулах;

16.1.3.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн үнэн зөвийг хариуцах;

16.1.4.тухайн төслийн техник, технологи, бизнесийн холбоотой мэдээллийн нууцыг хадгалах.



16.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий аж ахуйн нэгж нь үнэлгээний ажилтай холбогдсон эрсдэлийг Даатгалын тухай хууль тогтоомжоор зохицуулна.

### **17 дугаар зүйл. Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллагын үүрэг**

17.1.Банк, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын байгууллага нь байгаль орчин болон нийгэм, хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар санхүүжүүлэх, зээл тусламж олгохгүй байх үүрэг хүлээнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО**

### **18 дугаар зүйл.Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо**

18.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн үнэлгээ хийгдэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан төслүүдийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

18.2.Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үндэсний болон бүс нутгийн хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд стратегийн үнэлгээ хийх явцад олон нийтээс санал авна.

18.3.Стратегийн үнэлгээнд олон нийтээс санал ирүүлэх хугацаа нь ажлын 30-аас дээшгүй өдөр байх бөгөөд амаар болон бичгээр санал авна.

18.4.Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

18.5.Олон нийтийн оролцооны асуудлыг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

### **19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

19.1.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл эрх бүхий байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

19.1.1.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, зохих шийдвэр гаргуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон орлогыг хурааж сум, дүүргийн төсвийн дансанд шилжүүлэх;

19.1.2.байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол зөрчил арилгах хүртэл үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоож, гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

19.1.3.байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

19.1.4.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар нотлогдвол үнэлгээг хийсэн аж ахуйн нэгжийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг хүчингүй болгож нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### **20 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх**

20.1.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэлгүйгээр төслийг хэрэгжүүлснээс буюу үнэлгээгээр тавигдсан шаардлагыг зөрчсөний улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан аргачлалын дагуу тооцож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

20.2.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг буруу хийснээс байгаль орчинд учруулсан хохирлыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар нөхөн төлүүлнэ.



*Сандуйжав овогтой Бумаа. Луу жилтэй. Эрүүл ахуйч, их эмч мэргэжилтэй. Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй эмч. Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага, хүнс, усны шинжилгээний лабораториудад 36 жил тасралтгүй ажилласан.*

## БИЕ МАХБОД УС НЭХЭХ НЬ

Цуврал 6

### УУЦНЫ ӨВДӨЛТ

Нурууны өвчин үүсэхэд булчингийн агшилт ба нурууны холбоосонд нэмэлт ачаалал үүсгэдэг жийргэвчний буруу хөгжил гэсэн хоёр хүчин зүйл нөлөөлдөг гэж дээр дурдсан. Нурууны өвчин нь гарын үений үрэвсэлтэй яг адилхан асуудал үүсгэдэг, цорын ганц ялгаа нь жийргэвчний дотор талыг дүүргэдэг шилжиж буй вакуумын үйлчлэлд жийргэвчний бөөм өртдөг учраас түүний орон зайд цус хүргэхэд хүндрэл учирдаг. Энэ үйл явц нь явах хөдөлгөөний бүрэлдэхүүн хэсэг юм. Ус цусны эргэлтийн тогтолцооноос гарч, жийргэвчийг дүүргэх хэмжээнд бие махбод усаар хангалттай хангагдсан байх ёстой. Нурууны багана нь 23 жийргэвч, 24 нурууны үеийн тусламжтайгаар биеийн тулгуур болж байдаг. Жийргэвчнүүд нь бие биенийхээ эсрэг хэвтээ байрласан нурууны үений хавтгай гадаргууг бүрхсэн мөгөөрсөн хавтасны хооронд байрладаг. Нуруу бүрийн бүтэц цоожлогдсон мөгөөрсний хаах хавтас, түүнийг тулах хавтгай гэсэн хэсэгтэй байдаг. Хөдөлгөөний үед нурууны жийргэвч нь хавтгайн дээд доод хэсэгт байрласан цоожлогдсон мөгөөрсний хооронд аль болох бага гулсаж хөдлөх ёстой. Хүний биеийн дээд хэсгийн жингийн 75% нь өөрийн бөөмдөө усыг тогтоох, шингээх жийргэвчний гидравлик шинж чанар дээр тулгуурладаг. Хөдлөх, хажуу тийш налахад хүний биеийн жин жийргэвчин доторх усыг байнга шахдаг ба усгүйжсэн үед алдсан усыг бүрэн нөхөж чаддаггүй. Хатсан бөөмтэй усгүйжсэн жийргэвч биеийн жинд тулгуур болохдоо муу байдаг. Жийргэвчнүүд

нь шаантагны үүрэг гүйцэтгэх чадвараа алддаг ба нурууны үе хэврэг болдог байна. Хэдийгээр усаар сайн ханасан байлаа ч уян байдалтай жийргэвч өөрөө биеийн хөдөлгөөн хийдэггүй, гэвч даралтын нөлөөгөөр байнга усаа алддаг ба үүний дараа өөрийн зөөлрүүлэгчийн үүргээ биелүүлэхийн тулд хоосон зайн хүчний ачаар усыг дахин авч, өргөсдөг. Жийргэвч нь усгүйжсэн үедээ буцаж хөдлөн улмаар түүний дагуу байрлах мэдрэлүүдийг дарж болдог. Ийм тохиолдолд нурууны доод талын өвдөлт аль нэг хөл даган өвддөг. Энэ өвдөлтийг суудлын мэдрэл "ишиас" гэж нэрлэдэг бөгөөд нурууны хэсгийн өвдөлтөөс илүү хүндрэлтэй байдаг. Энэ нь нурууны бүтэц хэр их гэмтсэнийг, агшиж сунах үүрэг гүйцэтгэх аль нэг жийргэвч өөрийн байрнаас хөдөлж, суудлын мэдрэлийг дарсаныг илэрхийлдэг. Үүний буруутан нь бие махбодын усгүйжилт, буруу суулт юм. Суудлын мэдрэлийн үеийн өвдөлтийг намдаах, нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл "Нуруу ба үений хэрх өвчний өвдөлттэй хэрхэн тэмцэх вэ?" гэсэн миний номыг олж уншихыг зөвлөж байна.

### ҮЕНИЙ ЯСНЫ ҮРЭВСЭЛ

Үений мөгөөрс гэмтэхэд ясны хатуу гадаргуу бие биеэ хүчтэй хавирч эхэлдэг. Энэ нь ясны эдийг гэмтээж, үрэвсүүлдэг. Ингэж хоёдах шат буюу усгүйжсэнээс үений ясны үрэвсэл эхэлдэг (нэгдэх үе шат нь мөгөөрсний гадаргуу гэмтсэнээс үүсдэг). Үений ясны үрэвслээр өвчилсөн хүмүүст өвчин намдаах ацетаминофен, ибупрофен, аспирин өгдгийг санан нэгэн сонирхолтой өгүүлэл саяхан



нийтлэгдсэнийг үзсэн юм. Гарвардын анагаах ухааны сургуулийн эрдэмтдийн "Archive of International Medicine" сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэлд өгсөн шүүмжийг 2002 оны 10-р сарын 28-нд "New York Times" сонинд "Даралт ихсэлт ба өвчин намдаагчийн хоорондын уялдаа холбооны талаар дэвшүүлсэн таамаглал" гарчигтайгаар хэвлүүлсэн байсан. Судалгаанд өмнө нь эмнэлгийн үзлэгээр даралт ихсэж байгаагүй 31-50 насны 80 мянга гаруй эмэгтэйчүүд оролцсон байна. Эдгээр эмэгтэйчүүдэд 1995 оноос хойш өвчин намдаагч хэрэглэсэн ба үүнээс хоёр жилийн дараа тэднийг эмнэлгийн үзлэгт хамруулсан байна. Хоёр жилийн дотор 1650 эмэгтэйд цусны даралт нь ихсэж эхэлсэн байна. Тайленол ба ибупрофен агуулсан өвчин намдаагч ацетаминофеныг хэрэглэсэн эмэгтэйчүүдэд даралт ихсэлт нь энэ бэлдмэлийг хэрэглээгүй эмэгтэйчүүдээс 86 хувиар илүү тохиолджээ. Энэ өгүүлэл нь аспириныг даралт ихсэхийн шалтгаан биш гэж, цайруулж байна. Энэ судалгааг хэн санхүүжүүлж, түүний үр дүнгээр ямар компани баяжиж байгааг ойлгохгүй байна. Дэлхийн томоохон анагаах ухааны сургуулиудын нэг Гарвардын их сургууль бие махбодын усгүйжилтийг илэрхийлэх олон аргуудын талаар ичгэвэртэйгээр чимээгүй байгаа нь миний сэтгэлийг түгшээж байна. Энэ судалгааг явуулсан судлаачид өвдөлт бол бие махбод ус нэхэж байгаагийн шинж, харин даралт ихсэлт бол усгүйжилтэнд үзүүлэх бие махбодын хариу урвал, усгүйжилттэй тэмцэх нэг хэлбэр гэдэг нотолгоог мартсан бололтой. Тэд даралт ихсэлт ба өвдөлт нь бие махбод ус дутагдаж байгааг илэрхийлэх хоёр өөр арга гэдгийг ойлгодоггүй. Өвчин намдаагч нь усгүйжилтийн аль нэг хэсгийн дохиог усаа алдсаны дараагийн үзүүлэлт болох даралт ихсэх хүртэл өнгөлөн далдалдаг. Аспирин, ацетаминофен уухын оронд ус уух нь шинжлэх ухааны үндэслэлтэй гэж би бодож байна. Энэ энгийн мэдээллийн тусламжтайгаар олон хүнийг өвчин зовлонгоос нь салгаж болно гэдгийг хэн мэдэх билээ.

### ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. УСГҮЙЖИЛТ БА ӨВЧНҮҮД

Дор дурдсан байдлууд нь усгүйжилтийн удаан хугацааны үр дүнд үүсдэг ба бие махбод тогтмол аажмаар суларч, өөрөө зарим онцгой төрлийн их тохиолддог өвчнүүдийн анхаарлын төвд ордог. Усгүйжилтийн энэ түвшинд "Гарал үүсэл нь тодорхойгүй өвчин" гэсэн нэрийг анагаахын нэр хүнтэй эрхэмүүд өгсөн. Бие

махбодын усгүйжилт ойлгомжгүй аргуудаар илэрхийлэгдэж байгааг анагаахын нэр хүндтэй эрхэмүүд ашиглан түүнтэй тэмцэх ямар ч ашиг тусгүй, бодит байдалд нийцэхгүй эмчилгээний лицензүүдийг авч чадсан.


Ийм байдлуудын тоонд:

1. Таргалалт
2. Цусны эргэлтийн системд бага нягттай холестерин түвшин нэмэгдэх
3. Триглицеридын түвшин нэмэгдэх
4. Артерийн судсанд холестерин товруу үүсэх
5. Титэм судасны тромбоз
6. Яс сийрэгжих
7. Үений ясны үрэвсэл
8. Зүрхний дутагдал
9. Олон удаагийн цус харвалт
10. Хүүхдийн чихрийн шижин
11. Альцгеймерийн өвчин
12. Тархмал склероз
13. Лоу Геригийн өвчин
14. Булчингийн хатингаршил
15. Паркинсоны өвчин
16. Арьс хатуурах
17. Хорт хавдар
18. ДОХ

Анх удаа хүний бие махбодын доройтлыг энгийн усаар эмчлэх боломж олдсон нь орчин үеийн анагаах ухааны түүхэнд дэх сайн мэдээ юм. Эрүүл мэндийн эдгээр асуудлуудын шалтгаан илэрсэн ба хүн бүрт танигдсан. Товчоор хэлэхэд өвчнөөс сэргийлэхийн тулд усгүйжилтийг арилгах хэрэгтэй. Энэ бүлэгт бид таргалалтын талаар авч үзнэ. Бусад сэдвүүд нь дараагийн бүлгүүдэд яригдана. Эдгээрээс заримыг нь өмнөх бүлгүүдэд дурдсан.

### ТАРГАЛАЛТ

Таргалалтыг энгийн аргаар шийдэхийг олон хүмүүс сонирхдог. Хэрэв бид хэтрүүлж идэх, усгүйжих хоёрын хоорондын холбоог тогтоож чадвал таргалалтаас яаж салж болохыг ойлгох болно. Бие махбодод хуримтлагдсан өөхийг хэрхэн





багасгах вэ гэдэгт хариулах нь дараагийн алхам юм. Энэ хоёр асуултын хариулт маш энгийн. Шууд сануулахад: танд сахилга бат, шийдэмгий зан чанар хэрэгтэй. Үүнээс гадна, илүүдэл жингээс салах арга нь өөхний бодисын солилцоо гэдгийг санах хэрэгтэй. Хэрэв та түүнийг ямар нэг муу үр дагаваргүйгээр хийхийг хүсэж байгаа бол энэ нь удаан үйл явц юм. Хамгийн чухал алхам бол өөрийн оюун санаандаа гуалиг биетэй байгаагаар төсөөлөн бодох. Таны биеийн жинг хэдэн кг-р багассан гээд бодоод үз. Энэ төсөөлсөн хэв маяг таны ухамсарт хадгалагдаж, ийм үр дүнд хүрэхийг тархи байнга хүсэх ёстой. Хэт их идэх зуршил нь хоёр үндсэн мэдрэхүй дээр үндэслэдэг. Эхнийх нь хоол хүнс буюу ихэнхдээ өлсөх, дараагийнх нь цангах мэдрэмж байдаг. Хоёулаа нэг газар гистаминаар үүсгэгддэг. Энэ хоёр дохиог андуурахад амархан байдаг, бид уухын оронд ихэнхдээ иддэг. Бид зөвхөн ам хатах үед л уух хүсэл төрдөг гэж алдуурч боддог. Энэ ам хатах дохио хамгийн сүүлд өгөгддөг гэдгийг санах хэрэгтэй ба ихэнхдээ их идсэний дараа л мэдрэгддэг. Цангах мэдрэмжийг өлсөхөөс салгах хамгийн сайн арга хоол идэхийн өмнө ус уух байдаг. Зарим төрлийн амьтдад ийм дараалал нь тогтмолжсон байдаг. Амьтад өглөө эрт усны эх булагт ирдэг ба өвс нь ус их агуулдаг байлаа ч зөвхөн ус уусны дараа л өвс идэхээр явдаг. Хүмүүст энэ дараалал нь эсрэгээрээ зуршил болсон. Бид эхлээд хоол идэж, дараа нь ус уудаг ба хуурай хоол идэхэд бие усгүйжсэн мэт санагдахад л хааяа ус уудаг. Энэ нь таргалалтын шалтгаан гэдэгт би итгэлтэй байна. Тарган хүмүүс гистамины ус хүссэн гуйлтийг биелүүлэхийн тулд хоолыг шингээдэг. Хоол хүнс аденозинтрифосфатыг (АТФ) үүсгэдэг, үүнээс гадна уснаас илүү амттай байдаг болохоор тэд үүнийг хийдэг. Гэхдээ тархины АТФ-ын хэрэгцээг хангах тал дээр ус хамаагүй хурдан, үр дүнтэй байдаг. Тархины үйл ажиллагаанд хэрэгтэй эрчим хүчийг бид зөвхөн сахараас авч болно. Гэсэн хэдий ч бид сахарыг тархины хэрэгцээнээс 5 дахин их хэрэглэдэг. Эцэст нь хүний бие махбод дах цусны эргэлтийн зөвхөн 20% тархинд очдог байна. Үлдсэн сахар ихтэй 80% цус нь өөхний эс зэрэг биеийн бусад эрхтэнд зарцуулагддаг. Хэдийчинээ бид их иднэ, төдийчинээ их сахар тархинд хэрэгтэй байтал өөхөнд хуримтлагддаг. Гэтэл энд сахар нь тархинд хэрэгтэй байдаг. Усгүйжилтэнд буюу сэтгэл хямралд үзүүлэх гистамины энэ хариу үйлдэл нь яваандаа бие махбод ус нэхэж байхад хэтрүүлж идэхийн үндэс суурь болдог. Үүнээс үзэхэд усгүйжилт нь таргалалтын суурь болдог. Таргалалтын

ихэнх тохиолдол нь даралт ихсэлтэд хүргэдэг ба дараагийн шат нь чихрийн шижин байдаг. Чихрийн шижний тухай мэдээлэлд таргалалт гэсэн ойлголт нэмэгддэг. Энэ асуудлыг маш энгийн аргаар шийдэж болно. Хоол идэх бүрээс хагас цагийн өмнө, хоол идсэнээс хоёр цаг гучин минутын дараа тус бүр 2 аяга ус уух хэрэгтэй. Ойролцоогоор хагас цаг өнгөрөхөд хоолны хэрэгцээнээс биеийн усны хэрэгцээг салгаж чаддаг. Та өөрийгөө цатгалан байгаага мэдэрэх бөгөөд хэзээ бие махбодод жинхэнэ ёсоор хоол хэрэгтэй болно тэр үед иддэг болно. Та бага иддэг болж, хоол идэх хүсэл өөрчлөгднө. Хэрэв та хангалттай ус хэрэглэж байвал та нүүрсустөрөгчөөс илүү уураг идэхийг хүсэх болно. Дараагийн алхам нь хуримтлагдсан өөхийг багасгах. Усны хэрэглээг нэмэх нь илүүдэл жингээ багасгахад нөлөөлнө. Ойролцоогоор 3 долоо хоногт 3-6 кг жин хасна. Эдэд хавагнасан шингэн гадагшилж, нэн чухал эсүүдэд усыг буцаан хүргэх тогтолцоонд тусалсны үр дүнд ингэж илүүдэл жингээ хурдан хасдаг. Усны ихэсгэсэн хэрэглээгээ нэмэгдүүлэх нь дааварт мэдрэг өөх боловсруулах ферментыг идэвхижүүдэг ба тэнцвэртэйгээр илүү мэдэгдэхүйц жингээ хасдаг. Америкийн нийт хүн амын 37% нь илэрхий таргалалттай. Бүр хүүхдүүд ч таргалалттай болж байна. Зарим нэг үнэлгээгээр таргалалт жил бүр 400 мянган хүнийг цагаасаа өмнө нас барахад хүргэж байна. Энэ өвчнийг усны зөв хэрэглээгээр арилгаж, бүр эмчилж болно. Шалтгаан нь их энгийн. Өөхний хуримтлал - энэ нь усгүйжилтийн гол хүндрэлүүдийн нэг. Энэ нь хүн цангах мэдрэмжээ өлсөхтэй андуурч ус уухын оронд иддэгээс үүсдэг. Тархины хувьд тархины усан цахилгаан станцын боловсруулсан "цэвэр" эрчим хүчийг ашиглахыг илүүд үздэг. Хоолноос авсан "бохир" эрчим хүчийг зайлшгүй хэрэглэх болсон үед тархинд түүний дөнгөж 20% нь л очдог. Хэрэв үлдсэн эрчим хүчийг хөдөлгөөн, биеийн дасгал болон эрчим хүч боловсруулах бусад зүйлд зарцуулахгүй бол өөх болж хуримтлагддаг. Өөх үүсэж, хуримтлагдсан бол түүнийг зөвхөн химийн тусгай нэгдлээр л задалж болдог. Липаза- энэ нь өөхийг шингээж, дараа нь түүний булчин, бөөрөнд ашиглагдах өөхний жижиг хэсэгт хувиргадаг фермент юм. Липазын идэвхийг эрчимжүүлдэг тодорхой дааврууд байдаг ба энэ жагсаалтыг симпатик мэдрэлийн тогтолцооны адреналин тэргүүлдэг. Аяга ус гучин минутаас хоёр цагийн турш симпатик мэдрэлийн тогтолцоог эрчимжүүлдэг болох нь батлагдсан байна. Адреналины шүүрлийн



эцсийн үр дүн нь хуримтлагдсан өөх аажмаар алдагдан, илүүдэл жинг гайхалтайгаар багасгадаг явдал юм. Ийм аргаар турах нь хоолны дэглэм сахиж, илчлэгийг бууруулснаас илүү тогтвортой байдаг. Өөх боловсруулах фермент нь адерналин, түүний төрлийн идэвхжсэн дааварт мэдрэг байдаг. Булчингууд идэвхжиж хоолны гол бүтээгдэхүүн өөхийг шатааж эхлэхэд энэ даавар боловсордог. Үүнээс биеийн хөдөлмөрийн ашиг тус тодорхой болно. Усны хэмжээг ихэсгэж, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийсний ачаар харьцангуй богино хугацаанд 10-20 кг турсан олон хүнийг би мэднэ. Нэг жилийн дотор нэг нь 131 кг, нөгөө нь 16 сарын хугацаанд 138 кг турсан хүнийг би өөрийн нүдээр харсан. Нэг нь гэдэснийхээ унжсан илүүдэл арьсаа авахуулахын тулд хоёр удаа хагалгаанд орсон. Минийхээр бол биеийн жингээ барихын тулд хоолны хатуу дэглэм сахиж, өөрийгөө зовоох хэрэггүй. Хүсэж байгаа хоол ундаа бүгдийг идэж болно. Таны бие махбод түүнд ямар хоол хэрэгтэй байгааг өөрөө тодорхойлж эхэлдэг. Бие махбодын мэдрэг чанар, тухайлбал бие махбодын хэрэгцээг тогтоон, сонгох хүлээн авагч нэмэгддэг. Булчингийн идэвх ба дааварт мэдрэг липазын эрчим хоёр хоорондоо шууд хамааралтай болохыг Шведэд нээсэн байна. Шведийн арми хэдэн жилийн өмнө гурван долоо хоногийн түргэн алхалт хийсэн цэргүүдийн дунд хээрийн судалгаа явуулжээ. Цэргүүдийн физиологид үзүүлэх маршийн нөлөөг тогтоохын тулд цэргүүдээс тогтмол давтамжаар цус авч, төрөл бүрийн шинжилгээ хийсэн байна. Алхсанаас нэг цагийн дараа цусны эргэлтийн тогтолцоонд 12 цагаас доошгүй эргэлдсэн дааварт мэдрэг липаз идэвхжсэн болохыг эрдэмтэд илрүүлсэн байна. Мөн тэд тасралтгүй алхааны үр дүн хуримтлал үүсгэж, ферментийн идэвхийг хоногийн дуртай үедээ илрүүлж болохоор байдгийг тогтоосон байна. Энэ туршилт судалгааны үр дүнгээс харахад өдөрт хоёр удаа явган зугаалах нь бие махбодыг хоногийн турш өөх шатаах дэглэмд оруулдаг байна. Иймээс жин хасахад явганаар явах заавал хэрэгтэй байх нь. Илүүдэл жин хасахад ус ямар гайхамшигтай үр дүнтэй байдаг талаар нэгэн түүхийг дор өгүүлье.

### ЭРХЭМ ХҮНДЭТ БАТМАНГХЕЛИДЖ,

Амьдралынхаа ихэнх хугацааг би илүүдэл жингээс болж шаналж өнгөрөөсөн. Бүх айлд тарган хүүхэд байдаг шүү дээ харин би гэртээ тэр хүүхэд нь байлаа. Хүмүүс намайг зүгээр л яс томтой, ийм төрсөндөө баярлах естой

гэдэг байв. Дараа нь би “Усаар эмчлэх” хөтөлбөрийн талаар сонссон юм. Эхэндээ би итгэхгүй байлаа, мөстэй цай, кола ийм асуудалд хүргэдэг гэдгийг төсөөлөх ч үгүй байсан. Өөрийн жингээс өөр алдах зүйлгүй учраас усаар эмчлэхийг аргыг хэрэглэхээр шийдсэн. Ингэж би хагас жилийн дотор ойролцоогоор 45 кг турсан. Түүнээс гадна, надад удаан хугацаанд байсан сөргөө алга болсныг анзаарсан юм. Харин одоо урьд нь дотор муухай оргилуулж байсан хоолыг амтархан иддэг болсон. Мөн байнгын, арилахгүй гэж боддог байсан чихний халдварт өвчин маань ч эдгэсэн. Одоо би урьдынх шигээ хурдан ядардаггүй болсон ба өөрийгөө илүү эрч хүчтэй, өөр хүн болсныг мэдэрч байна.

Надад тусалсанд баярлалаа, доктор Батмангхелидж !

Усны хэрэглээгээ нэмэгдүүлж, бага зэргийн давс, дасгал хөдөлгөөн хийснээр илүүдэл жингээ хасах нь хоолны дэглэм сахихаас илүү ухаалаг сонголт юм. Хоолны дэглэм сахиж, зөвхөн жиндээ анхаарал хандуулснаар өөрийн бие махбодод нэн чухал бичил элементүүдээр дутагдуулан түүнийг сульдуулж байгаа хэрэг. Эрчим хүчний гол эх үүсвэр бол ус, илүүдэл нь шээстэй ялгардаг сайн талтай. Өөр нөхцөлд өөх боловсруулах үйл явц нь нүүрсхүчлийн давхар исэлд хувиран уушгаар дамжин гадагш ялгарах хүртлээ олон шат дамждаг. “Woman’s World Magazine” сэтгүүлийн 2001 оны 9-р сарын 4 –ний дугаарын хавтас ба хоёр хуудас нь жингээ хасах “Усаар эмчлэх” хөтөлбөрт зориулагдсан байсан. Гарчиг нь “Анагаах ухаан дах хувьсгалт үсрэлт! Усны тусламжтай турах шинэ хөтөлбөр! Яаж 20-иос дээш кг турахыг мэдэж ав!”

Үргэлжлэл дараагийн дугаарт

